

# Хямралаас Энхтайванд

*Шийдэл нь  
ОРГАНИК ВЕГАН ХҮНС*



Төгс Гэгээрсэн  
Их Багш Чин Хай

**ХЯМРАЛААС ЭНХ ТАЙВАНД**  
**Шийдэл нь ОРГАНИК ВЕГАН ЗАМ МӨР**

*ЛӨГС ТЭГЭЭРСЭН ИХ БАТШ ЧУН ХАЙ*



Зохиогч:  
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хавтасны дизайн:  
Жена Балариа, Даун Фэйт

Эх бэлтгэл:  
Матио Ривера

Хянасан:  
Хайрын Тэнгис Олон Улсын Бүтээлч Компани, ХХК  
Шуудангийн хайрцаг 109-973 ТАЙБЭЙ  
Тайбэй хот, 11099  
Тайвань

[www.loveoceancreative.com](http://www.loveoceancreative.com) / Цахим хаяг: [info@loveoceancreative.com](mailto:info@loveoceancreative.com)

/ E-mail: [info@loveoceancreative.com](mailto:info@loveoceancreative.com)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 2010  
Анхны хэвлэл: 2010 оны 11 дүгээр сар  
Хоёр дахь хэвлэл: 2012  
Тайваньд хэвлэв  
ISBN: 978-986-86252-6-6 (Зөөлөн хавтастай ном)

Бүх эрх хамгаалагдсан.  
Хэвлэн нийтлэгчээс урьдчилан зөвшөөрөл авч,  
энэхүү хэвлэлийн агуулгаас хувилж болно.

Хэмжээлшгүй их хайрыг түгээхийн тулд энэ номыг  
найз нөхөд, хайртай хүмүүстээ хүртээнэ үү.



Дэлхийн бүх оршин суугчийн сайн үйлийн үрээр энэ  
үзэсгэлэнт гараг маань бүтээгдсэн. Гэвч түүнийг  
шинээр үүссэн муу үйлийн үрээр хучих аваас гараг ч,  
оршин суугчид ч мөхөх болно.

Сайн үйлийн үрийг бүтээе:  
Хайрлан нигүүлсэгч байя  
Веган байя  
Байгаль дэлхийгээ хамгаалъя

— Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



## ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ .....</b>	<b>8</b>
<b>ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР ...</b>	<b>10</b>
<b>ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ДЭЛХИЙН БҮХ УДИРДАГЧ НАРТ ХАНДАН ГАРГАСАН УРИАЛГА .....</b>	<b>13</b>
<b>ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛИЙН ТУХАЙ .....</b>	<b>16</b>
<b>ТАЛАРХЛЫНЗАХИДАЛ.....</b>	<b>17</b>
<b>1. ДЭЛХИЙГ АВРАХ ВЕГАН ШИЙДЭЛ .....</b>	<b>21</b>
I. МАНАЙ ГАРГИЙН ОНЦ НОЦТОЙ БАЙДАЛ .....	21
II. БИДНИЙ ХООЛ ХҮНСНИЙ СОНГОЛТ НЬ ҮХЭХ-СЭХЭХИЙН ТУХАЙ АСУУДАЛ .....	24
<b>2. ХҮН ТӨРӨЛХТНИЙГ СЭРЭЭХ ГЭСЭН АНХААРУУЛАХ ДОХИО .....</b>	<b>30</b>
I. БАЙДАЛХАМГИЙНМУУГААРТООЦСОНООСЧДОРБАЙНА...30	
II. БИДЭНД МАШ БАГА ХУГАЦАА ҮЛДСЭН .....	43
III. ОДОО АСУУДЛЫНГОЛШАЛТГААНЫГ АРИЛГАЯ.....	44
<b>3. ГАРАГ ДЭЛХИЙГ ИЛААРШУУЛАХ ОРГАНИК ВЕГАНИЗМ ...50</b>	
I. ГАРАГ ДЭЛХИЙГЭЭ СЭРҮҮЦҮҮЛЖ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭЕ .....	51
II. ХАМГИЙН ДӨТ, НОГООН ШИЙДЭЛ .....	70
III. АМЬ АМЬДРАЛАА АВРАХЫН ТУЛД БУСДАД АМЬДРАХ БОЛОМЖ ОЛГОЁ .....	73
<b>4. ВЕГАН ХУУЛЬ, БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ .....</b>	<b>77</b>
I. ДЭЛХИЙН УДИРДАГЧИД ӨӨРСДӨӨ ҮЛГЭР ДУУРАЙЛ ҮЗҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ .....	77
II. ТӨР ЗАСАГ НЭН ДАРУЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЁСТОЙ .....	78

III. МАЛ АМЬТНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧИД ӨӨР АЖИЛ МЭРГЭЖИЛД АМЖИЛТТАЙ ШИЛЖИХ НЬ .....	93
IV. САЙН ЗАСАГЛАЛЫН ЖИШЭЭ .....	94
V. ОРГАНИК ВЕГАНИЗМ БОЛ БУРХАНЛАГ ХӨДӨЛГӨӨН .....	97
<b>5. УРГАМАЛД СУУРИЛСАН ХООЛНЫ ДЭГЛЭМД ДЭЛХИЙ НИЙТЭЭРЭЭ ШУУД ШИЛЖИХ НЬ .....</b>	<b>100</b>
I. ДЭЛХИЙД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙНХНИЙ ЭРХЭМ ТУСЛАЛЦАА, МАНЛАЙЛАЛ ХЭРЭГТЭЙ .....	100
II. ШАШНЫ ТЭРГҮҮНҮҮД БУСДЫГ АМЬДРАЛЫН ЗӨВ ЗАМД ХӨТӨЛДӨГ .....	102
III. ЭРХЭМ АРИУН БОЛОВСРОЛ НЬ ЭРҮҮЛ НОГООН АЖ ТӨРӨХ ХЭВ МАЯГИЙГ ЗААДАГ .....	103
IV. ТББ-УУД ВЕГАН ХӨДӨЛГӨӨНИЙГ ДЭМЖДЭГ .....	107
V. ТА ХАРАХЫГ ХҮСЭЖ БУЙ ӨӨРЧЛӨЛТӨӨ ХИЙГЭЭРЭЙ .....	108
<b>6. ХҮН ТӨРӨЛХТӨН АЛТАН ЭРИНД ҮСРЭНГҮЙ ШИЛЖИХ НЬ .....</b>	<b>119</b>
I. ХҮН ТӨРӨЛХТНИЙ ХӨГЖЛИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГ .....	119
II. ДЭЛХИЙ САНСАР ОГТОРГУЙН ДЭЭД СОЁЛ ИРГЭНШИЛД ДЭВШИЖ БАЙНА .....	123
III. ДИВААЖИНГИЙН МӨРӨӨДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ .....	126
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>129</b>
<b>ТЭМДЭГЛЭЛ .....</b>	<b>140</b>
<b>ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН АЙЛДВАРУУДЫН НОМ ЗҮЙ .....</b>	<b>163</b>
<b>НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ .....</b>	<b>170</b>
<b>НОМ ХЭВЛЭЛ .....</b>	<b>173</b>

## ***Хянан толилуулагчийн тэмдэглэл:***

Энэхүү ном нь олон улсын бага хурал, шавь нарын цугларалт, мөн сэтгүүлчидтэй хийсэн ярилцлагын үеэр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ярьсан айлдваруудын эшлэлүүдийг бүрэн эхээр нь багтаасан билээ. Эдгээр эх сурвалжийг 163 дугаар хуудаснаа буй “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдваруудын ном зүй”-гээс лавлан үзээрэй.

Эзэн Бурхан болоод Дээд Сүнсний тухай ярихдаа Бурхан эр эсвэл эм хүйстэй аль нь болох тухай гарч болзошгүй маргаанаас зайлсхийж, хүйсийн ялгаа заадаггүй нэр томъёог Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хэрэглэдэг билээ.

*She + He = Hes (Bless гэдэгтэй адил дуудна.)*

*Her + Him = Hirm (Firm гэдэгтэй адил дуудна.)*

*Hers + His = Hiers (Dears гэдэгтэй адил дуудна.)*

*Жишээлбэл: Бурхан хүсвэл Тэрбээр (Hes) юмсыг  
Өөрийн (Hirmself) таалалд нийцүүлэн, Түүний  
(Hiers) хүсэл зоригийн дагуу зохицуулдаг.*

Уран бүтээлч, бурханлаг багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дотоод гоо сайхны аливаа илэрхийлэлд дуртай. Тиймээс ч Тэр Вьетнамыг “Ау Лак”, Тайваныг “Формоса” хэмээн нэрлэдэг. Ау Лак гэдэг нь “Аз жаргал” гэсэн утгатай, Вьетнам орны эртний нэр. “Үзэсгэлэнтэй” гэсэн утгатай Формоса хэмээх нэр энэ арлын орон болон хүн ардынх нь гоо сайхныг илүү төгс төгөлдөр илэрхийлдэг. Төгс Гэгээрсэн Их Багш энэ нэрсийг хэрэглэх нь нутаг орон хийгээд оршин суугчдад сүнслэг хөгжил дэвшил, аз хийморь авчирна гэж үздэг юм.

## ӨМНӨХ ҮГ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай сүүлийн жилүүдэд хийсэн видео уулзалт, сэтгүүлчидтэй хийсэн ярилцлага болон шавь нарын цугларалтын үеэр Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалсан өнөөгийн хямралын тухайд яаралтай арга хэмжээ авах шаардлагатайг ярьсаар ирсэн билээ. Тэрбээр “Манай гараг гал авалцаж буй байшинтай адил болжээ. Хэрвээ бид галыг унтраахын тулд нэгэн сэтгэлээр хамтдаа ажиллахгүй бол орон гэргүй болох болно.” гэж хэлсэн байдаг. Төгс Гэгээрсэн Их Багш үүний зэрэгцээ хүн бүрийн хэрэгжүүлж чадахуйц нэгэн дэвшилтэт арга замыг санал болгосоор байна. Энэ нь “Таргаа аврахын тулд Веган болоорой” хэмээх айлдвар юм.

Уг хямрал гүнзгийрэх тусам байгалийн гамшиг олон мянган хүний амь насанд хүрч, хэдэн сая хүнийг орон гэргүй болгож, тэрбумаар тоологдох долларын санхүүгийн хохирол амсахад хүргэж байна. Далайн усны түвшин дээшилснээр 18 арлын үндэстэн хэдийнээ живж, бусад арлын оронд энэ аюул бодитойгоор заналхийлэх боллоо. Хур тунадасны хэм алдагдаж, ган гачиг ихэссэн нь олон бүс нутагт нөлөөлж, ус, хүнсний хомсдолыг даамжруулж байна. Уур амьсгалын мэргэжилтнүүд цаг агаарын бүр илүү цочир үзэгдлүүд тохиохыг, тэр дундаа “дэлхийн дулаарал газар авч” магадгүйг хүмүүст сануулж сэрэмжлүүлсээр байна.

Энэхүү номд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дэлхийн дулааралд нөлөөлж буй гол хүчин зүйлс, тэр дундаа үндсэн шалтгаан нь болох мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаар танилцуулж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 20 гаруй жилийн турш учирлан тайлбарлаж ирсэн үзэл санаа нь шинжлэх ухааны олон судалгаагаар нотлогдсон билээ. Мал амьтныг хоол хүнсний зориулалтаар өсгөн үржүүлэх нь газар, ус, эрчим хүчний үнэт нөөц баялгийг тоймгүй их хэмжээгээр устгадаг төдийгүй дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 51%-ийг бий болгодог. Мал аж ахуй нь агаар дахь метаныг бий болгогч хамгийн том, цорын ганц эх үүсвэр. Метан нь нүүрсхүчлийн хий ( $\text{CO}_2$ )-гээс илүү хүчтэй нөлөөтэй хүлэмжийн хий бөгөөд агаарт задрах хугацаа нь богино юм.

Тийм учраас махны үйлдвэрлэлийг зогсоож, “веган болох” буюу хүн төрөлхтөн ургамалд суурилсан хүнсэнд шилжих нь дэлхийн дулаарлыг даруй бууруулж, мал аж ахуйгаас үүдсэн байгаль орчны



доройтлыг зогсоож эргэн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад зарцуулж буй зардлыг хэдэн их наяд доллараар бууруулах цорын ганц логик арга зам гэдгийг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай сургамжлан айлдсан билээ. Энэ арга замаар гараг дэлхий болон хүн төрөлхтөнд ямар ч сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр дээрх үр дүнд хүрэх юм. Харин аж үйлдвэр, тээврийн салбарт нүүрсхүчлийн хийн давхар ислийн ялгаруулалтыг ийм байдлаар зогсоох нь эдийн засгийн маш их хор хохирлыг дагуулж болзошгүй. Цаашилбал, байгальд ээлтэй ногоон технологийг хөгжүүлэн, нэвтрүүлэхэд асар их цаг хугацаа шаардана. Харин веган хоол хүнсэнд шилжсэн хүн нэг бүрийн тоогоор метаны хийн ялгарах хэмжээ тэр даруй багасна. Бидэнд маш бага хугацаа үлдээд байгаа учраас веган амьдралын хэв маягт шилжих нь уур амьсгалын өөрчлөлтийн хямралаас гарах хамгийн хялбар, хамгийн хурдан, хамгийн бага өртөгтэй арга зам төдийгүй, цорын ганц аврал юм.

Дэлхийн олон орны төрийн зүтгэлтэн, уур амьсгалын шинжээч, байгаль орчны мэргэжилтнүүд уур амьсгалын өөрчлөлтийн хамгийн хөнөөлт үр нөлөөнөөс дэлхийг аврах энэ арга замыг аль хэдийн дэмжин сурталчилж эхэллээ. Тэд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн: “Шийдвэр гаргах эрх мэдэлтэй хүн бүр энэ шилжилтийг нэн даруй хэрэгжүүлэх хууль эрх зүйг баталж гаргахын төлөө зоригтой алхам хийх” уриалгыг дэмжин, 2010 оны 6 дугаар сарын Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ)-ын тайланд дэлхий нийтээрээ махан ба сүүн бүтээгдэхүүнээс таггалзахыг давтан уриалж дуу хоолойгоо хүчтэй хүргэсэн билээ.

Хүн төрөлхтөн жил бүр гэм зэмгүй хэдэн тэрбум мал амьтныг нядалдгаас үлдсэн цусан ул мөр нь уур амьсгалын өөрчлөлтийн хямралыг үүсгэж буй чухамдаа бидний бий болгосон нүүрстөрөгчийн ул мөрөөс ч илүү ихээр сүйрлийг дагуулж мэднэ. Хүн төрөлхтний ёс суртахууны энэ гэмт хэрэг хэдийнээ дэлхий даяар түгж, ийм хэрцгий үйлийн үр “Бид юу тарина, түүнийгээ хурааж авна” хэмээн дэлхийн бүхий л агуу сургаал номлолд заасан байдагчлан эцэстээ бидэнд байгалийн гамшиг байдлаар буцаж ирж байна гэдгийг Төгс Гэгээрсэн Их Багш олонтоо анхааруулдаг.

Хүн төрөлхтөн амьдралын хэв маягтаа эргэлт хийх шийдвэрлэх цэгт тулаад байна. Бидэнд гаргаа аврах боломж ганцхан энэ цаг үед л байна. Гагцхүү энэрэлтэй, амьдралыг аврах, ургамалд суурилсан хүнсэнд шилжсэнээр биднийг бүрхээд байгаа энэ харанхуйг үлдэн хөөж чадна. Энэхүү жижигхэн алхам хүн төрөлхтнийг ухамсрын илүү өндөр түвшинд дэвшүүлэх болно. Бид Эх дэлхийд эе эв, зүй зохицлыг хамгаалан үлдээж, үүгээрээ энх тайван, хайр, үзэсгэлэн төгөлдрийн Алтан Эринийг цогцлоох болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн баглан өгүүлснээр бид Дэлхий дээрээ Диваажинг бүтээж чадна.

Бүгдээрээ энэ сайхан боломжийг алдалгүйгээр, өнөөдрөөс эхлэн өөрчлөлт хийе. Бүгдээрээ соёл иргэншил болон гараг дэлхийгээ хувьсган өөрчилж, улам дээш дэвшүүлбэ.

Редакцийн ажлын баг

## ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай нь дэлхийд алдартай хүмүүнлэгийн үйлстэн, байгаль орчныг хамгаалагч зүтгэлтэн, зохиолч, зураач, загвар зохион бүтээгч, хөгжимчин, кино найруулагч, сүнслэг багш бөгөөд түүний хайр, халамж нь арьс өнгө, улс үндэстний хил хязгаараас үл хамааран бүхий л хүн төрөлхтөнд түгж байдаг. Тэрбээр 1980-аад оны эхэн үеэс эхлэн хүрээлэн буй орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах, ойжуулах, тогтвортой амьдралын хэв маягийг дээдлэх, нэн ялангуяа дэлхийн уур амьсгалын хямралыг шийдэх хамгийн түргэн бөгөөд үр дүнтэй арга зам болох ургамлан хүнсэнд шилжихийг уриалан дэмжиж, цуцалтгүй сурталчилсаар ирсэн дэлхийн хамгийн нэр хүндтэй байгаль орчны анхдагч зүтгэлтнүүдийн нэг юм.

Тэрбээр энэ олон жилийн туршид уур амьсгалын өөрчлөлтийн аюултай үр нөлөө болон түүнийг шийдэх арга зам болох веган хүнсэнд шилжихийг хүн төрөлхтөнд ухуулан таниулахад бүхий л цаг хугацаа, нөөц бололцоогоо харамгүй зориулсаар ирсэн билээ. Их Багш 2006-2008 онд “Өөрөөр амьдрахуй”, “СОС-Дэлхийн дулаарал”-ыг таниулах компаниг ажлуудыг эхлүүлсэн байдаг. Тэрбээр энэ чиглэлээр ном бичин, сэтгүүл хэвлүүлж, 2005 онд ургамал хоолны Жинхэнэ баатрууд баримтат кино, Хаан ба түүний харьяатууд хэмээх дэлгэцийн цуврал киног найруулсан нь уур амьсгалын өөрчлөлт, ургамалд суурилсан хүнс болон бусад дэвшилтэт сэдвээр мэдээ мэдээллийг өдөр бүр 24 цагаар дамжуулдаг хиймэл дагуулын Суприм Мастер Телевиз хэмээх дэлхийн хэмжээний сувгаар цацагдсан билээ. Түүнчлэн Их Багш Чин Хай 2007 оноос хойш дэлхийн 15 орноос хиймэл дагуулын телевиз, радиогоор шууд дамжуулсан уур амьсгалын өөрчлөлтийн тухай 29 удаагийн бага хуралд оролцож, байгаль орчны мэргэжилтэн, төр, нийгмийн зүтгэлтнүүд болон иргэдтэй билэг оюуны үнэт мэдлэгээ солилцжээ. Эдгээр хүчин чармайлтын үрээр “Таргаа аврахын тулд Веган болж, Байгалиа хамгаалъя” хэмээх Түүний айлдсан уриалга дэлхий дахинд түгж, хүн төрөлхтөнд эрүүл, тогтвортой веган амьдралын хэв маягийг сонгох, энх амгалан, эв зохирлын илүү өндөр түвшинд дэвшин хөгжих урам зоригийг хайрласаар байна. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн үлгэр жишээгээр бидний дотоодын мөн чанар, Бурханы бүх бүтээлийг хайрлах хайрыг сануулдаг. Сүнслэг дэвшилд хүрч олсон гүн ухаарлаараа Тэрээр хүмүүний зовлон, нийгмийн зөрчил, хүрээлэн

буй орчны доройтлын үндсэн суурь шалтгаан нь гэм зэмгүй амьтад болон бусад төрөлтөнд бидний учруулдаг харгис хэрцгий үйлдэл болохыг олж илрүүлсэн байна. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай сэтгэлийн дуудлагаараа сул дорой, өөрийгөө хамгаалах чадваргүй амьтныг энэрэхийн тухайд “Шувууд миний амьдралд”, “Миний амьдрал дахь ноход”, “Эрхэм ариун амьтад” номоо бичсэн нь олон улсад борлуулалтаараа тэргүүлж байна. Олон улс үндэстний хэлээр хэвлэгдсэн эдгээр уран зохиолын сор бүтээлүүд нь бидэнтэй зэрэгцэн орших эрхэм амьтдын гүн бодол, мэдрэмжийг уудлан илрүүлж, тэдний бурханлаг чанар, нөхцөл болзолгүй хайрыг онцлон өгүүлсэн байдаг.

Төв Ау Лакт (Вьетнам) мэндэлсэн Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Европт боловсрол эзэмшин, тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажиллаж байжээ. Зовлон зүдгүүр гараг дэлхийн хаа ч нэгэн адил оршин байдгийг ухаарснаар үүнээс гэтлэн гарах арга замыг эрж олох нь Түүний амьдралын нэн тэргүүний зорилго болсон юм. Тэрбээр Гэгээрлийг эрэлхийлэх аяллаа эхлэн Энэтхэгийн их Хималайн ууланд даяанчилж, жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багшаас дотоодын Гэрэл, Аялгууг уламжлан авч, түүнийгээ хожим нь Гуань Инь (Арьяабалын) арга хэмээн нэрлэжээ. Хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасныхаа дараа Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Агуу Гэгээрэлд хүрсэн билээ. Хималайн уулнаас бууж ирснийхээ дараахан Их Багш Чин Хай эргэн тойрныхоо үнэнийг эрэлхийлэгч сүсэгтэн олон болон жирийн хүмүүсийн чин хүслийн гуйлтаар Арьяабалын аргыг уламжилж, бурханлаг агуу чанараа дотоодоосоо эрж хайхыг шавь нартаа заадаг байжээ. Удаж төдөлгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк тивээс Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг морилон ирж, ном тайлахыг хүссэн урилга ихээр ирүүлэх болжээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн энэрэнгүй сэтгэл нь ядарсан нэгнийг гэх хайр халамжаар нь илэрдэг. Их Багшийн уран бүтээлийн борлуулалтаас орсон орлого нь дэлхий дахинд болж буй байгалийн гамшигт нэрвэгдэгсдэд туслах болон бусад буяны ажлаар дамжуулан “Бурханы хүүхдүүд”-ийг хэрэгцээтэй үед нь тэтгэх боломжийг түүнд олгодог.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүмүүнлэгийн ажил үйлсийнхээ төлөө ямарваа гавьяа шагнал горилдоггүй хэдий ч дэлхийн олон орны Засгийн газар, хувийн байгууллагууд, түүний хөдөлмөр зүтгэлийг өндрөөр үнэлж, түүнд Дэлхийн Энх Тайвны Шагнал, Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн Шагнал, Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал, Дэлхийн Хүмүүнлэг Иргэн Шагнал, Хүн төрөлхтний сайн сайхны төлөө гарамгай гавьяа байгуулсны шагнал, 2006 оны Гүси Энх Тайвны Шагнал, Лос Анжелесын Хөгжмийн Долоо Хоногийн Сайшаалын гэрчилгээ, 2006 оны 27 дахь Телли Аворд шагналын Тэргүүн байрын Мөнгөн өргөмжлөл, АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Бушийн гардуулсан Ерөнхийлөгчийн нэрэмжит Идэвхтэй Амьдралын шагнал, АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагаас гардуулсан 2010 оны Ерөнхийлөгчийн нэрэмжит Сайн дурын Үйлсийн Шагнал зэрэг хүндэт шагнал,

өргөмжлөлүүдийг харамгүй хүртээж ирсэн байна.

Түүнчлэн АНУ-ын Хавай, Иллинойс муж улсын Засгийн газраас жил бүрийн 10 дугаар сарын 25 болон 2 дугаар сарын 22-ныг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” хэмээн тэмдэглэж байхаар зарласан. Иллинойст болсон ёслолын үйл ажиллагааны үеэр АНУ-ын Ерөнхийлөгч асан Клинтон, Буш, Рейган нар түүнд баярын мэндчилгээ ирүүлсэн байдаг. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай сайн үйлс бүтээгч хүмүүсийг алдаршуулж, бусдыг тэдний үлгэр жишээг дагахыг уриалах зорилгоор Дэлхийн Гэрэлт Үйлстний цуврал шагналуудыг санаачлан бий болгож, онцгой баатарлаг сайхан үйлс, энэрэнгүй сэтгэл, манлайлал, зориг, оюун ухаанаараа бусдад үлгэр дуурайл болж байгаа хүн, амьтдыг урамшуулан шагнадаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ийнхүү өөрийгөө умартан бидний хайрт гараг, түүний эрхэм нандин оршин суугчдын ирээдүйг үзэсгэлэнтэй сайхнаар бүтээхийн төлөө амьдралаа зориулдаг юм. Бүхий л түүхийн туршид агуу зөнч мэргэд мөрөөдөлтэй байсны нэгэн адил Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн мөрөөдлийг: “Надад мөрөөдөл бий. Дэлхий тэр чигээрээ энх амгалан болоосой гэж би мөрөөддөг. Бүх аллага зогсоосой гэж би мөрөөддөг. Бүх хүүхэд амар амгалан, эв найртай орчинд амьдраасай гэж би мөрөөддөг. Бүх үндэстэн гар гараасаа барилцан, бие биеэ өмгөөлж хамгаалан, бие биедээ тусалж байгаасай гэж би мөрөөддөг. Үзэсгэлэнт гараг маань бүү устгагдаасай гэж би мөрөөддөг. Энэ гараг бий болоход хэдэн тэрбум жил шаардагдсан бөгөөд энэ гараг үнэхээр үзэсгэлэнтэй, үнэхээр гайхамшигтай. Энэ чигээрээ, гэхдээ энх тайван, гоо үзэсгэлэн, хайраар дүүрэн үлдээсэй гэж би мөрөөддөг” хэмээн айлдсан байдаг.

*Энэ дэлхийн бүх хүн, удирдагчид, жирийн иргэдийг тэвэрч, “Сэрээч” гэж хэлэхийг Би ямар их хүснэм. Би тэднийг бүгдийг нь тэвэрч “Сэрцгээ, яг одоо сэрцгээ. Хайрт үр минь сэр; найз минь сэр, өөрийгөө авар” гэж хэлэхийг хүсэж байна.*

## **ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ДЭЛХИЙН БҮХ УДИРДАГЧ НАРТ ХАНДАН ГАРГАСАН УРИАЛГА**

Зориг гарган өөрсдийн хил хязгаарыг давж, хүн төрөлхтний тусын тулд үзэл бодлоо илэрхийлэн дуу хоолойгоо хүргэж байгаа бүхий л удирдагчдад би ихэд талархаж байна. Тэдний сайн үйлсийг олон нийт анзаарч үнэлдэггүй юм гэхэд Диваажин мэдэх болно. Үүнийхээ төлөө тэд дараа аугаа их шагналыг хүртэх болно. Эрх мэдэлтэй өндөр албан тушаал хашна гэдэг мэдээж маш хэцүү.

Удирдагч хүн зоригтой, нигүүлсэнгүй, эрхэм дээд сэтгэлтэй байх ёстой. Тиймээс л та Удирдагч байгаа юм. Мэдээж, удирдагчийн байр сууринд байх амар биш. Тиймээс ч удирдан манлайлагч хүн цөөхөн байдаг. Улс оронд зөвхөн нэг л хаан, нэг л хатан, хэдхэн гүнж, хэдхэн ханхүү, нэг ерөнхийлөгч, нэг ерөнхий сайд байдаг шүү дээ. Энэ дэлхийн үй олон хүнтэй харьцуулахад удирдагчид тун цөөн. Гэвч цөөн удирдагчид эрэлхэг, зоригтой, зөв шударга, мэргэн ухаантай байсаар байна.

Тэдгээр ухаалаг, зоригтой удирдагчдыг бид бүрэн дэмжиж, хүндэлсээр ирсэн. Эрхэм ариун үүргээ гүйцэтгэхэд нь тэдэнд илүү хүч чадал, мэргэн ухаан хайрлаарай гэж бид Диваажингаас гуйн залбирах болно. Яагаад гэвэл ийм манлайлагч нар цөөхөн гэж би хэлсэн шүү дээ. Цөөн хэд нь мэргэн ухаантай, эр зоригтой хэвээр л байна. Манлайлан жолоодогч байснаараа бид ард иргэдэд юу сайн, юу муу болохыг мэдэж байх ёстой. Иргэдээ сайн зүйл хийхэд зоригжуулан урам өгч, дэмжих хэрэгтэй. Харин муу зүйлийг таслан зогсоож, иргэдээ хамгаалах үүрэгтэй. Энэ бол удирдагч хүний жинхэнэ үүрэг билээ.

***Бүх хүнд ач тустай амьтны бус гаралтай хүнсийг хөхиүлэн дэмжье***

Хамгийн сайн төр засаг ард иргэддээ ач тустай бодлогыг дэмждэг байх хэрэгтэй. Үр бүтээмжтэй байхын тулд төр засгийн удирдлагууд энэ цаг үе онцгой арга хэмжээ авахыг шаардсан маш чухал нөхцөл бүрэлдээд буйг ухаарвал зохино.

**Дэлхийгээ аврахын тулд аливаа амьд амьтныг хөнөөхөөс татгалзсан аж төрөхүйн хэв маягийг дэмжин, аль болох хурдан хэрэгжүүлэхийг Би дэлхийн бүх төрийн тэргүүн, төр засагт санал болгож байна.**

Бидэнд цаг бараг л үлдээгүй, үлдсэн цаг хугацаа тийм ч их биш. Энэ нь улс төрийн ч асуудал биш, харин бид болон бидний үр хүүхдүүдийн эсэн мэнд үлдэж чадах эсэх тухай асуудал болоод байна. Бүх төр засаг ард иргэддээ амьтны амь таслахаас ангид байх, эрүүл хоол хүнсэнд шилжихийг уриалан дэмжиж хэрэгжүүлэх аваас бид гараг дэлхийгээ нэн даруй аврах болно.

Дэлхийд маань эерэг сайн нөлөөтэй арга хэлбэрээр бид амьдралаа тэтгэж болно шүү дээ. Бидэнд хүнсний хомсдол нүүрлээд байгаа тул Засгийн газраас эргэлзэж тээнгэлзэлгүйгээр органик веган фермийн болон бусад ногоон дэвшилтэт туршлагыг дэмжих нь зүйтэй. Үүний ач тус нэн их байх болно. Засгийн газар гараг дэлхийгээ аврах, органик газар тариаланг тэргүүлэх чиглэлээ болгон, төрөөс татаас олгож дэмжих шаардлагатай.

Улс орныхоо ард иргэд, үр хүүхдүүдээ хайрлах сэтгэлээ эн тэргүүнд тавьж, тэднийхээ төлөө хийх ёстой тэрхүү үйл хэргийг зоригтой эхлүүлж, ард түмний зүгээс тэдэнд итгэж олгосон тэр эрх мэдлийг эх дэлхийгээ аврахын төлөө ажил хэрэг болгоно уу хэмээн Би дэлхийн бүх удирдагч нарт хандан дахин нэг уриалж байна.

Дэлхийн мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь дэлхийн дулааралд эрчим хүчний салбартай дүйх хэмжээнд, бараг түүнээс ч илүүтэйгээр нөлөөлж байна. Миний мэдэж байгаагаар дэлхийн дулаарлын 80-аас багагүй хувь нь мал аж ахуйн салбараас үүдэлтэй. Махны үйлдвэрлэл нь танай улс орны ард иргэдийн уух уснаас хороож, эрүүл мэндийг доройтуулж, амь насанд нь халтай шинэ төрлийн өвчнийг өдөр бүр бий болгож, дайн дажинд ч турхирч байна.

Энэ бүхэн Танай ард түмнийг хөнөөж байна шүү дээ. Зөвхөн Та л үүнийг зогсоож чадна.

Хүмүүс төр засаг, удирдагч нартаа үнэхээр их найдаж хүлээлттэй байдаг учраас тэдэнд Таны веган байх, баатарлаг, гялалзсан үлгэр жишээ хэрэгтэй байна.

**Органик газар тариалангийн тухай, эсвэл зайлшгүй шаардлагатай байгаа веган амьдралын хэв маягийн өөрчлөлт хийх тухай таны хууль, компанит ажлууд нь тэдэнд маш их дэмжлэг болно.**

Танай улсын иргэд бол таныг дэмжигч, дагагч хүмүүс. Тэд эх

дэлхийгээ ирээдүй хойчийнхоо төлөө, тэдний болон хайртай хүмүүс, ирээдүйн хүүхдүүдийнх нь амь, амьдралыг аварсанд тань талархаж, таныг магтан сайшааж, хайрлан дэмжиж, дурсан санах болно. Диваажин ч бас таныг маш ихээр шагнах болно.

Веган болох хөдөлгөөнийг манлайлна уу! Уучлал өршөөл, энх тайвныг урамшуулан дэмжинэ үү. Тэгвэл бусад бүх бэрхшээл, ядуурал, зөрчил мөргөлдөөн, тахал өвчин, тэр бүү хэл санхүүгийн хямрал хүртэл аяндаа шийдэгдэнэ.

Улс үндэстний төрийн тэргүүн, удирдагч нарын зүгээс өдийг хүртэл энэ чиглэлээр хийж байгаа бүхий л ажил үйл, гаргаж буй хүчин чармайлтад тань талархдагаа би илэрхийлж байна.

### ***Бид бүгдээрээ шийдлийн нэгэн хэсэг***

Хэрвээ та бүхэн болгоовол одоо бидний хийж, төлөвлөж байгаа зүйлс хангалттай биш, мөн хангалттай хурдан ч хийхгүй байгааг би шударгаар хэлмээр байна. Түүнчлэн илүү ихийг, илүү хурдан хийх зориг, итгэл үнэмшилтэй байхыг би та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна.

Дэлхийн даяарх байгууллагууд, тэр дундаа нийгмийн хөдөлгөөний хүчийг илүү мэдэрдэг хэвлэл мэдээллийнхэн Та бүхэнд, гайхалтай, хүмүүнлэг, бүх талын ашиг тустай, сонирхол татахуйц, амьтны амь хөнөөхөөс ангид, веган амьдралын хэв маягийн талаар хүмүүст мэдээлж, зоригжуулж байдаг үйл хэргийн тань төлөө талархал илэрхийлье.

Хувь хүн танд, гараг дэлхийгээ аврахын төлөө өөрт хамаарах үүргээ гүйцэтгэж байгаад тань баярлалаа. Гэхдээ бидэнд хийх ажил их, хугацаа маш бага байгаа тул өөрөөсөө хамаарах бүхнээ цагтаа амжиж хийнэ үү.

Өөрийгөө, гэр бүл, үр хүүхэд, амьтад зэрэг амьдралынхаа хамгийн үнэ цэнэтэй бүхнээ аврахын тулд веган болж өөрчлөгдөхийг бид удирдагчид, айл хөрш, хувь заяа нэгт зон олондоо хэлж шавдуулсаар байх хэрэгтэй.

Бид зөв чигт явснаар аюулыг гэтэлж чадна. Бидний гэр түймэрт автаж байна. Гэхдээ усны хоолой бидний яг урд байна.

**Зүгээр л тэр усны хоолойг шүүрч аваад хэрэглэ. Шийдэл яг үүн шиг л хялбар тул цаг хугацаа алдалгүй зүгээр л веган бол гэж гуйя. Бидэнд тоотой хэдэн өдөр л үлдсэн шүү.**

Бүх хүмүүн төрөлтөн минь ээ, Диваажин Та нарт маш их хайртай. Бид урьд урьдынхаас ч илүү эх дэлхийгээ аврагдана гэж найдаж байна. Бид Диваажингийн хязгааргүй адислал, хайрын энергигэр бялхсан энэрэнгүй, эелдэг найрсаг уур амьсгал бүхий шинэ веган гарагт сэрэх болно.

Та бүхэн бүгдээрээ бидний хүрч чадах энх тайвныг угтан явсаар байх болтугай гэж би залбиръя. Та бүхэнд маш их баярлалаа. Баярлалаа.

## ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛИЙН ТУХАЙ

“Хямралаас Энхтайванд – Шийдэл нь Органик Веган Хүнс” ном анх 2010 онд хэвлэгдсэн. Энэхүү ном болон Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бусад хүчин зүтгэлээс урам зориг авсан засгийн газрын ажилтнууд, шашны тэргүүнүүд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүн төрөлхтний эрүүл мэндийг сайжруулах арга зам бол веган амьдралын хэв маяг гэдгийг илүү ихээр сурталчилж байна. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хэдэн сарын турш эрчимтэй бясалгасныхаа дараа 2012 оны гуравдугаар сард айлдсанаар эдгээр бүтээлч хүчин чармайлт манай гаргийн хувь заяаг өөрчилж, Дэлхийн соёл иргэншил оршин тогтнох хугацаа хамгийн багадаа дахин хагас зуунаар сунгагджээ. Мэдэгдлийнхээ дараа Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дэлхийн иргэд, нийгмийн бүлгүүдийн үнэлж баршгүй ажил үйлсэд талархлаа илэрхийлэн нээлттэй захидал бичсэн юм. Хямралаас Энхтайванд номын энэхүү сайжруулсан хэвлэлд захидлын орчуулгыг англи хэлээрх эх хувийн хамт толилуулж байна.



## ТАЛАРХЛЫН ЗАХИДАЛ

*Засгийн газрын Эрхэм Хүндэт гишүүд; дэлхий дахинд хүндлэгдсэн шашны Ариун гэгээн, Эрхэмсэг Дээд тэргүүнүүд; хэвлэл мэдээллийн нэр хүндтэй удирдагчид; олон нийтийн эрхэм төлөөлөгчид өө:*

*Бидний гоо үзэсгэлэнтэй гаргийн оршин тогтнох хугацаа дахин хагас зуун жилээр сунгагдаж, цаашид ч үргэлжлэн нэмэгдэх тухай сайхан мэдээг дуулгаж байгаадаа сэтгэл хөдлөн, халуун зүрхний угаас талархаж байна.*


*Та бүхний эрхэм ариун үйлс, хичээл зүтгэлд чин сэтгэлийн талархлыг дэвшүүлье. Хамтын ийм хүчин чармайлт хэтдээ Дэлхийг болон оршин суугчдыг нь хамгаалахад хөтөлнө.*

*Компанит ажилд оролцох, иргэний эрх, эв нэгдэл, илүү амар амгалан, эрүүл аж төрөхүйг дээдлэн баталгаажуулсан хууль тогтоомж гаргах, амьтдыг асран хамгаалах, хүмүүнлэгийн ажил хийх, нийгмийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэг нь эдгээр ухаалаг, халамжит үйлсэд хамаарна.*

*Та бүхэнтэй би биечлэн уулзаагүй ч, бидний гайхамшигт гараг дээрх бүхий л амь амьдрал эв зохиролтой оршиход дэм болж, аюулгүй байдлыг хангахын төлөө бид яг нэг баг шиг ажиллаж байгаа мэт надад санагддаг.*

*Бүхий л оршихуйн хувьд Дэлхий энх амгалан, дэвшингүй, элбэг дэлбэг байх нөхцөлийг цаашид ч батжуулахын тулд урьд өмнөхөөсөө илүүтэйгээр энэхүү эрхэм хүчин чармайлтаа хамтдаа үргэлжлүүлнэ хэмээн бид найдаж байна.*

*Та бүхнийг хүндэтгэсэн*



*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*



## LETTER OF APPRECIATION

*Most Excellent and Honorable government leaders; Holy, Eminent and Reverend leaders of the world's esteemed religions; distinguished members of the media; and noble members of the public:*

*With heartfelt gratitude, we are excited to share the good news that the continuation of our precious planet has been extended for another half century and counting.*


*We extend our sincere thanks for all of your noble endeavors. Such combined efforts have led to the further safeguarding of the Earth and her inhabitants.*

*These wise and considerate actions include participation in campaigns and protective laws encouraging adoption of healthier living, greater peace, unity and civil rights, animal welfare, humanitarian works, social programs and environmental conservation.*

*Even though I have not met you personally, I feel like we are working as a team to secure and foster the harmonious existence among all life on our magnificent planet.*

*We look forward to continuing these noble efforts together, more now than ever before to further ensure a peaceful, more advanced, and abundant world for all beings.*

*Respectfully yours,*



*Supreme Master Chng Hai*

**BE VEGAN, MAKE PEACE**  
**PEACE:**  
It begins on our plate.  
**VEGANISM:**  
The best saving way to live.

Хэрвээ хүн бүр яг энэ цагаас эхлэн мах идэхээ зогсоох юм бол найман долоо хоногийн дотор дэлхийн цаг агаар таатай сайхан болж өөрчлөгдөнө. Найман долоо хоногийн дотор сүйдсэн болгон эргэж хэвэндээ орох болно. Энэ дэлхийн хүн болгон мах идэхгүй, энэрэнгүй сэтгэлтэй нэгэн болбоос үр дүн нь шууд мэдрэгдэх болно.



Олон жилийн турш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай манай гараг Дэлхийг сүйрлээс аврахын тулд тасралтгүй урт удаан хугацаанд гүн гүнзгий бясалгал хийсэн юм. Үүний эцэст 2012 оны 12 дугаар сард Их Багш баяр хөөртэйгөөр Диваажингаас дэлхий дахинд ирүүлсэн гайхамшигт мэдээг дуулгасан нь манай гараг аврагдан, дахин хэдэн сая жил амьдрах болсон тухай байсан билээ.

*“Бидний гараг дэлхий маань аврагдан, дахин маш урт удаан хугацаанд амьдрахаар боллоо. Бид ямагт дотооддоо төвлөрөхийг хичээж, дотоодын тэр ариун Бурханлаг эхүүсвэртэйгээ сүнсээрээ холбогдохыг хичээх хэрэгтэй.”*

*~Их Багш Чин Хай  
2012 оны 12 дугаар сарын 22*

# 1

## ДЭЛХИЙГ АВРАХ ВЕГАН ШИЙДЭЛ

Яг одоо энэ нь маш яаралтай хийх зүйл болоод байна. Эхлээд бид амьд үлдэхийн тулд дэлхийн дулаарлыг зогсоох хэрэгтэй. Тиймээс веган болох нь бид энэ дэлхийд эсэн мэнд, эрүүл энх амьдрах, байгаль орчин, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдэх хамгийн дөт арга зам юм.

Манай гараг амьтан, мод, ургамал зэрэг бүхий л оршин суугчдынхаа сайн сайхны төлөөх бүтээлч өөрчлөлтийн босго тулж ирээд байна гэдэгт би итгэлтэй байна.

Хэрвээ бид дээрх боломжийг мах идэх, тамхи татах, мансууруулах бодис хэрэглэх, архидах зэрэг муу дадал зуршлуудаа өөрчлөхийн төлөө хамтран ажиллахад хэрэглэж чадах аваас улс үндэстнүүд тамхидалтыг таслан зогсоосон тэр л арга замаар бид даруй нэгдэж, гараг дэлхийд гарах агуу, гайхамшигт өөрчлөлтийн гэрч болно.

## I. МАНАЙ ГАРГИЙН ОНЦ НОЦТОЙ БАЙДАЛ

### ХУГАЦАА БАГА ҮЛДСЭН БАЙНА

“Хугацаа оройтож байна; шийдвэр гаргах цаг нь болсон. Таныг ухаалаг сонголт хийнэ гэдэгт би бүрэн итгэлтэй байна. Дэлхийн дулаарлын асуудлыг хэрхэн шийдэхийг эрдэмтэд тун тодорхой болгосон билээ.”<sup>1</sup>

—*Бан Ги Мүн*

“Уур амьсгалын хямрал нь гараг дэлхийд тулгамдсан аюул болчихоод байна.”

—*Аль Гор*

Хэрвээ бид энэ босгыг өнгөрчихвөл уур амьсгалын өөрчлөлтийн дараагийн үе шатууд маш хурдан байгаад зогсохгүй буцаах аргагүй, сүйрлийн шинжтэй байх болно гэж дэлхийн эрдэмтэд түгшиж байна. Энэхүү аюулт мөч дөхөж буйн шинж тэмдгүүд нь нуурын ажиглалтаас болон Дэлхийн мөсөн давхаргын дор аюулгүй байдалд байсан метан хий өөр хаа нэгтээ бургилан гарах байдлаар аль хэдийн илэрч эхэлсэн байна.

Тоймгүй их хэмжээний метан хий ямар ч хяналтгүйгээр дэгдэж агаарын хэмийг гэнэт огцом өсгөн, сүйрүүлэх дулааралд хүргэж болзошгүй тэр өдөр хэзээ тохиохыг хэн ч мэдэхгүй. Энэ нь бидэнд хамгийн аюултай гамшигт үзэгдэл болох юм.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй бусад сүйрлийн үр дагавар хэдийнээ илрэлээ олжээ: Дулааныг эргэн ойлгогч Арктикийн мөсөн бүрхүүл нь ойрын ирээдүйд бүрэн хайлж дуусах замдаа орсон байна; далайн усны түвшин нэмэгдсэний улмаас хэдэн арван арал усанд автсан буюу заримд нь живэх аюул нүүрлээд байна; далай орчмын үхмэл бүсэд CO<sub>2</sub>-ын түвшин хэвийн хэмжээнээсээ хэтэрснээс болж ус нь хэт хүчиллэг болж байна; ой хээрийн аюулт түймрийн давтамж ихэссэн; амьд байгаль дахь төрөл зүйлүүд хэвийн үеэс 100 дахин хурдан устаж байна; хар салхи, шуурганы хүч улам нэмэгдэж их хэмжээний сүйрлийг дагуулах болжээ; дулаарч буй бүс нутгуудад өвчин тээгч шумуул тархаж байна; дэлхийн мөнх цэвдгүүд хайлж байна; нуур, гол мөрөн хэдэн арван мянгаараа ширгэн хатаж, элсэн цөл улам бүр тэлсээр байна.

Байгаль орчны эдгээр сөрөг үр дагаврын улмаас 2 тэрбум хүн усны хомсдолд орж, 20 сая хүн албан ёсны хамгаалалтгүйгээс гадна дүрвэгсэд шиг л цөхөрсөн байдалд байна.

**Үнэн хэрэгтээ энэ бүхэн хүн төрөлтийн харгис, хүчирхийллийн үр дагавар бөгөөд хамгийн гол нь амьтны махаар хооллож байгаатай холбоотой.**

[Түүнчлэн,] мал аж ахуйн үйлдвэрлэл нь дэлхийн хөрсний элэгдэл эвдрэлд хамгийн ихээр нөлөөлдөг. Энэ нь цөлжилт үүсэх, биологийн олон янз байдал устах, усыг үр ашиггүй хэрэглэх, бохирдуулах гол хүчин зүйл болж байна. Тэгээд ч дэлхийн дулаарлын улмаас усны нөөц өдөр бүр хомсдож байгаа билээ. Үүнээс гадна мал аж ахуйн салбар бидний шатах ашигт малтмал болон хүнсний үр тарианы нөөцийг ямар ч үр ашиггүй шавхаж байна. Товчхондоо, нэг таваг махыг үйлдвэрлэхэд, түүнээс дутахгүй, бүр илүү ч шим тэжээлтэй веган хүнстэй харьцуулбал 12 дахин их үр тариа, дор хаяж 10 дахин их ус, 8 дахин их малтмал түлшний эрчим хүчийг үргүй зарцуулж байна.

## МАЛ АЖ АХУЙ: ДЭЛХИЙН ХЯМРАЛЫН ГОЛ ШАЛТГААН

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах сүйрлийг “буцаахын аргагүй болох тэр цэгт” хүргэхээс зайлсхийх цорын ганц арга зам бол хамгийн их сөрөг үр дагавартай махны үйлдвэрлэлээс татгалзах үйлдэл юм. Үүнийг баталгаажуулсан бүхий л баримт нотолгоо, мэдээлэл одоо бидэнд байна. **Мал аж ахуйн салбар бол хүлэмжийн хийн тэргүүлэгч үүсгүүр мөн.**

НҮБ-ын 2006 онд хэвлүүлсэн баримтаас үзэхэд мал аж ахуйн үйлдвэрлэлээс үүсдэг хүлэмжийн хийн ялгарал нь онгоц, галт тэрэг, машин, мотоцикл гэх мэт дэлхийн бүх тээврийн хэрэгсэл нийлээд үүсгэж буй хийн ялгарлын хэмжээнээс ч **илүү их** байна.<sup>2</sup> **Хамгийн сүүлийн үеийн мэдээгээр дэлхийн дулаарлын наанадаж 50% нь мал аж ахуйн салбараас үүдэлтэй байна.**<sup>3</sup>

“Мал аж ахуй болон түүний дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь жилд хамгийн багадаа 32,564 сая тонн CO<sub>2</sub> буюу дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 51 хувийг үүсгэж байгааг бидний дүн шинжилгээ харуулж байна.”<sup>4</sup>

—*Дэлхийг ажиглалтын хүрээлэн (Worldwatch Institute)*

## МЕТАН ХИЙ НЬ СО<sub>2</sub>-ООС ИЛҮҮ НӨЛӨӨТЭЙ

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хамгийн их метан ялгаруулагч эх сурвалж нь мал аж ахуй юм. **Метан хий нь нүүрсхүчлийн хий (СО<sub>2</sub>)-нээс 72 дахин их дулаан хураах чадвартай төдийгүй богино хугацаанд задардаг байна.** Энэ нь агаар мандалд метан хий урвалд орж СО<sub>2</sub>-оос илүү хурдан буюу ердөө арван жилийн дотор задардаг, харин СО<sub>2</sub> нь хэдэн мянган жил хадгалагддаг болохыг илэрхийлнэ. Тийм учраас мал үржүүлгийн ажлыг бүрэн зогсоон, метан хийг агаар мандалд хуримтлуулалгүй арилгах нь гараг дэлхийгээ сэрүүцүүлэх хамгийн дөт арга зам юм.

**Тийм ээ, бид дулааралд хамгийн ихээр нөлөөлөгч эх сурвалжийг зогсоох хэрэгтэй.**

Ухаалаг мэргэн удирдагч нар маань биднийг буцаахын аргагүй байдалд хүргэх гол хүчин зүйл болох энэхүү аюулт метан хий үүсгэгч мах үйлдвэрлэх үйл ажиллагааг яг одоо зогсоогоосой хэмээн би залбирч байна. Эс бөгөөс, нүүрсхүчлийн хийн ялгаралтыг бууруулах гэсэн бидний бусад бүхий л хүчин чармайлт ямар ч үр дүнгүй, эсвэл нэн түрүүнд хэрэгжүүлэх боломжгүй болж болзошгүй.

Мах болон бусад амьтны гаралтай бүтээгдэхүүнийг идэх болон үйлдвэрлэхээ зогсоохгүй бол бид эх дэлхийгээ устгах болно.

## II. БИДНИЙ ХООЛ ХҮНСНИЙ СОНГОЛТ НЬ ҮХЭХ-СЭХЭХИЙН ТУХАЙ АСУУДАЛ

### БИД ГАРАГ ДЭЛХИЙГЭЭ ЦӨЛМӨЖ БАЙНА

**Хэрвээ хүнснээс махны хэрэглээг хасах эсвэл хязгаарлахгүй бол гараг дэлхий маань бүхэлдээ устана.** Энэ нь ганц хувь хүний сонголтын асуудал биш, хүн бүрд хамаатай үхэх-сэхэхийн асуудал юм. Бид мах идэж байхдаа гараг дэлхийгээ бүхэлд нь шавхаж, дэлхийн хүнсний нөөцийн 90%-ийг идэж, улмаар бусдыг өлсгөлөнд нэрвэгдэхэд хүргэж байдаг.<sup>5</sup> Энэ огтхон ч зөв сонголт биш.

Махан хоолтой хүмүүс энэхүү аюул нүүрлэхээс өмнө ч гараг дэлхийг шавхан, маш их хүнсний нөөцийг идсэнээр өлсгөлөн болж, дайн дажин дэгдэж байсан билээ. Энэ нь анхнаасаа л зөв сонголт байгаагүй.

“Бид хүнсний сонголтоо өөрчлөхгүй л юм бол өөр юу ч бидэнд тус болохгүй. Яагаад гэвэл мах нь ой модны дийлэнхийг устгаж байна. Усыг бохирдуулагч нь мах юм. Бидний бүх мөнгийг эмнэлэг рүү урсгаад байгаа өвчнүүдийг үүсгэгч нь мах юм. Тиймээс Дэлхийг аврахыг хүсэж буй бүх хүний хамгийн эхний сонголт бол хүнсний сонголтоо өөрчлөх явдал.”<sup>6</sup>

—Манека Ганди

Бид амьдралын хэв маягаа өөрчлөхөөс нааш энэ бүх [дэлхийн дулаарал] нөхцөл байдал улам дордож хэзээ ч зогсохгүй. Үүнээс гарах гарц тун хялбар: ердөө л мах идэхээ зогсоох; энэ бол хамгийн шилдэг шийдэл. Гараг дэлхийн нөхцөл байдал туйлын аюултай болж, бидэнд цаг хугацаа бараг үлдээгүй тул үүнийг зайлшгүй хийх шаардлагатай.

Махны үйлдвэрлэлийг зогсоосноор хүлэмжийн хийн ялгарлыг хамгийн хурднаар багасгаж, уур амьсгалын өөрчлөлтөөс эхлэн газар болон усны нөөцийн буруу хэрэглээ, бохирдол, байгаль дахь (зэрлэг) амьтан, ургамлын хомсдол, хүний эрүүл мэндэд учрах аюул зэрэг хүрээлэн буй орчны өгүүлж баршгүй хохирлыг таслан зогсоох болно.

[Дэлхийн дулаарлын] 50%-ийг зогсоохоос гадна – энэ нь нэлээд багасгасан тооцоо – ашиг тус нь үүнээс ч илүү байх болно гэж би хэлэх гэсэн юм. Үүгээр усны хомсдол, дэлхийн өлсгөлөнгийн хямрал, газрын доройтол, бохирдлын асуудлыг шийдэх болно.

**Веган хүнстэй харьцуулахад махан хүнс бэлтгэхэд 17 дахин их газар нутгийг хэрэглэж, 14 дахин их ус, 10 дахин их эрчим хүч зарцуулдаг.**<sup>7</sup> Хүн төрөлхтнийг бүхэлд нь элбэг хангалуун тэжээх



хэмжээний үр тариаг бид хураадаг. Бидэнд дэлхийн бүх хүн амыг, тэр бүү хэл хоёр дахин илүү хүн амыг элбэгхэн тэжээж хүрэлцэхүйц их хоол хүнс байгаа атал одоо 1 тэрбум хүн өлсгөлөн амьдарч, жил бүр 6 сая хүүхэд, өөрөөр хэлбэл, 5 секунд тутамд 1 хүүхэд эндэж байна.<sup>8</sup> Нөгөө талаар, 1 тэрбум орчим хүн хэт таргалалт болон хэт их мах идсэнээс үүдэлтэй өвчнөөр шаналж байна.

**Тэгэхээр амьтай бүхнийг хамгаалснаар бидний энэрэнгүй чанар хөгжихөөс гадна өөр олон бодит шалтгааны улмаас бид веган байх нь зохистой.** Энэ ч бас чухал. Хэрвээ хүмүүс өөрчлөлтөө ердөө л веган хүнснээс эхэлчихвэл аяндаа бусад бүхий л амь амьдралд анхаарал халамж тавьдаг болчихно.

**НҮБ-аас махан болон сүүн бүтээгдэхүүнээс ангид хүнсэнд шилжихийг дэлхий нийтэд уриалж байна:**

Хүн ам өсөж, малын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байгаагаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үр дагавар жинтэй өсөх хандлагатай байна. Энэ үр дагаврыг дорвитой багасгах ганц арга зам нь дэлхий нийтээрээ амьтны гаралтай хүнснээс татгалзах явдал юм.<sup>9</sup>

## **УРГАМАЛД СУУРИЛСАН ХООЛЛОЛТ БОЛ ХАМГИЙН ШУУРХАЙ ШИЙДЭЛ**

“Малын гаралтай бүтээгдэхүүнийг орлуулах арга хэмжээ нь агаар мандал дахь хүлэмжийн хийг хамгийн хурдан багасгаад золсохгүй дэлхийн хүнс, усны нөөцийн хямралыг шийдвэрлэж чадна.”<sup>10</sup>

*—Дэлхийн ажиглалтын хүрээлэн*

Веган болох нь нүүрсхүчлийн давхар ислээс 72 дахин их дулаан хураах чадвартай метан хийг агаар мандлаас нэн даруй зайлуулахад нөлөөлнө.<sup>11</sup> Веган болсноор цөлжилтийг сааруулж, байгалийн үнэт баялаг болох гол, нуур, ой модыг хамгаалах болно.

Та бүхэн мод тарих, ногоон технологид шилжих зэрэг байгальд ээлтэй бусад арга хэмжээг авч болох ч үр дүн гарахад нь урт хугацаа шаардагдана. Харин ургамал хүнсэнд шилжих нь үр дүнгээ богино хугацаанд өгч, амь таслах муу үйлийн үрийг ч багасгадаг учраас хамгийн чухал арга хэмжээ юм.

Ургамал хоолонд шилжсэнээр цэвэр усны нөөцийн 70 хувийг, Амазоны ширэнгэн ойн 70 хүртэлх хувийг бэлчээрийн газар болгохоос хамгаална.<sup>12</sup> Улмаар жилд 3.5 сая хүртэлх га газрыг талхлагадахаас сэргийлнэ. Жил бүр дэлхийн үр тарианы үйлдвэрлэлийн тэн хагастай тэнцэх 760 сая хүртэлх тонн үр тариаг

хэмнэх болно, та үүнийг төсөөлж байна уу?<sup>13</sup> Махны үйлдвэрлэлд зарцуулдгаас 2/3-оор бага шатах ашигт малтмал зарцуулж, малын ялгадаснаас үүдэлтэй бохирдол багасч, агаар цэвэршин, АНУ-ын нэг өрхөд жилд ногдох хорт хийн ялгарал 4.5 тонноор буурна. Ингэснээр дэлхийн дулаарлын 80%-ийг зогсооно.<sup>14</sup>

Нидерланд улсын эрдэмтдийн тооцоолсноор веган хүнсэнд шилжсэнээр зөвхөн санхүүгийн хэмнэлтийн тал дээр л гэхэд дэлхийн дулаарлыг зогсооход шаардагдах 40 орчим их наяд америк долларын 80%-ийг хэмнэх боломжтой юм байна! Энэ нь махан хүнснээс ургамалд суурилсан хүнсэнд шилжих энгийн алхмыг хийхэд л 32 их наяд америк долларыг хэмнэнэ гэсэн үг ажээ.<sup>15</sup>

Эх дэлхий маань өөрийгөө сэлбэж сэргээх зүй тогтолтой байдаг. Бид л гараг дэлхийгээ хэт их ачааллаж байдаг. Бид хэтэрхий их бохирдуулж, хэтэрхий их аллагын үйлийн үрийг тарьж байна. Оршин суугчдынхаа тарьсан муу үйлийн үрээс болж Дэлхий өөрийгөө засаж сэлбэх боломжгүй байна. Бид энэ аллагын үр нөлөөнөөс үүссэн муу үйл үрийн шийтгэлийг арилгамагц л Дэлхий өөрчлөгдөн, өөрийгөө засаж сэлбэх, нөхөн төлжих, амьдралыг дахин тэтгэх боломжтой болно. Бүх асуудал муу үйлийн үрээс үүдэлтэй. Бид Дэлхийгээ даацаас нь хэтрүүлж ачаалсан тул бид өөрсдийн үйлээ өөрчлөх ёстой. Гол зангилаа үүнд л байгаа юм.

Тэгвэл бид Дэлхийгээ аварна, өөрийн болон хүүхдүүдийнхээ, бас амьтдын ч амь амьдралыг аврах болно. Дэлхий маань диваажин болно. Хэн ч, юугаар ч, хэзээ ч гачигдахгүй. Хэн ч өлсөхгүй. Дайн дажин, өвчин эмгэг, байгалийн гамшиг, дэлхийн дулаарлын асуудал бүгд үгүй болж, баяр хөөр, элбэг дэлбэг, энх тайван амьдрал л тогтнох болно. Би Буддагийн нэрээр амлаж; ийм л байх болно.

## **АМЬТНЫ АМИЙГ ХӨНӨӨХ НЬ МУУ ҮЙЛИЙН ҮР МӨН**

“Юу тарина, түүнийгээ хураана”. “Ижил нь, ижлээ татдаг.” Шинжлэх ухааны үүднээс ч, сүнслэг утгаар ч бидэнд ийнхүү сэрэмжлүүлсээр байна. Дэлхийн эргэн тойронд болж буй бүх гай гамшиг нь хүмүүс зэрэгцэн оршиж буй бусад төрөлтөнд найрсаг бус хандсантай холбоотой. Тэд ямар ч гэм зэмгүй, ялгаагүй л Бурханы хүүхдүүд бөгөөд бидэнд тусалж, бидний амьдралыг чимж байг гэж Дэлхий рүү илгээгдсэн тэдэнд зүй бусаар хандсаны төлөөсөнд бид энэ бүх гамшгийг туулж байна.

Энэ нь техникийн холбогдолтой асуудал биш; бидний анхаарлаа төвлөрүүлэх ёстой зүйл нь техникийн засвар биш. Бидний анхаарах ёстой зүйл бол төлөөс, шалтгаан ба төлөөс юм. Аллага, хүчирхийллийн төлөөс нь ямар ч машин техник, наран дээрх эсвэл далайн гүн дэх дэлбэрэлтийг нийлүүлснээс хэд дахин их, яагаад гэвэл бид энэ

үйлдлийнхээ хариуцлагыг үүрэх ёстой. Үйлдэл бүр хариу үйлдлийг өдөөдөг. Тиймээс, бид аллагыг л зогсоох хэрэгтэй. Бид хүнийг, бас амьтдыг ч алж хөнөөдгөө зогсоох хэрэгтэй.

Бид үүнийг зогсоох ёстой. Тэгвэл бусад бүх зүйл тов тодорхой болно.

Тэгснээр бид уур амьсгалын асуудлыг шийдэх илүү сайн технологийг нээх болно. Наран дээрх дэлбэрэлтүүд ч зогсож магадгүй. Далайн гүн дэх дэлбэрэлтүүд ч зогсож магад. Тайфун, циклон зэрэг хар салхи ч дарагдана. Газар хөдлөлт гэж байхаа болино. Бид энх тайвныг цогцлоож, улмаар хүмүүс өөр хоорондоо төдийгүй бусад төрөлтөнтэй эв найрамдалтай зэрэгцэн амьдрах учраас бусад бүх зүйл амар тайван байдалд шилжих болно. Ийм л учраас би ургамлын хоолыг онцолсоор байгаа юм. Энэ бол хүн байхын ёс суртахууны гол учиг. Энэ бол аугаа их хүнийг илтгэх шинж.

## **ЭНЭРЭНГҮЙ ЭНЕРГИ БҮХНИЙГ ӨӨРЧИЛЖ ЧАДНА**

Ургамлын хоол нь энэрэнгүй хүнс учраас танд баяр хөөрийг авч ирнэ, улмаар аз жаргалыг тэтгэж, улам их аз завшааныг тань уруу татах болно. Та жаргалтай байвал бусад бүх зүйл сайжирна. Та илүү сайн сэтгэнэ; илүү сайн үйл хийнэ; таны амьдрал улам сайжирна. Хүүхдүүд тань дээрдэнэ, бүх зүйл өөдөлж дэвшинэ.

Бүх дэлхийн хүчирхэг, хамтын, эерэг бөгөөд хайрын энерги биднийг зүглэн ирж буй, одоогоор бидэнд нүүрлээд байгаа харанхуйг элдэн хөөх болно. Энэ бол надад байгаа цорын ганц шийдэл юм.

Та ойлгож байна уу, бидэнд бүхнийг өөрчлөх эрч хүч, эргэн тойрондоо болох зүйлсийг удирдан зохицуулах хүч байдаг, гэхдээ бид үүнийг хэргийг гаргах ёстой. Бүхий л төрөлтний төлөө бид үүнийг хэрэглэх ёстой. Дэлхий дээрх төрөлтөн бүрийн тусын тулд бид үүнийг хэрэглэх ёстой. Илүү сайхан гараг дэлхийг, илүү аюулгүй амьдралыг, гараг дэлхийгээ аврахыг хүсэж байгаагаа бид бодол, үйлдлээрээ илэрхийлэн орчлон ертөнцийн эрчим хүч рүү илгээх ёстой. Ингэсэн тохиолдолд орчлон ертөнцийн энерги үүнийг хийх болно.

Гэхдээ бидний үйлдэл энэхүү аугаа их хүчний хэмнэлтэй нийцэж байх хэрэгтэй, ойлгож байна уу? Хэрэв бид сайн зүйлийг хүсэж байвал сайныг л үйлдэх учиртай. Хэрвээ бид амьдрахыг хүсэж байгаа бол амь насыг аврах хэрэгтэй. Тиймээс бидний үүсгэсэн сайн энерги эдгээр зүйлийг, бас өөр гайхамшгуудыг ч бүтээж чадна. Бүхий л ертөнц шиг бидний бүтээж буй энэрэнгүй, хайрлагч уур амьсгал маань бидний төлөө гайхалтай ид шидийн гэмээр зүйлсийг бий болгодог, бий болгох ч болно.

Бид орчлонгийн хуулийн дагуу амьдрах аваас хүссэн бүхнээ

бүтээж чадна. Ердөө веган болсноор л энэ бүх хүчийг олж авна. Яагаад гэвэл энэ нь бид амь насыг аварч, амьдралыг, бүтээгч энергийг хүсэж, сүйрлийг хүсдэггүй болохыг илэрхийлдэг. Ийм л учраас хамгийн зөв шийдэл нь веган байх явдал юм.

Хүн төрөлхтний сүнслэг дэвшил ахих тусам дэлхийн дулаарал улам багасна. Хүн төрөлхтөн илүү бурханлаг болж дэвшин бүх хүн, бүх төрөлтөн, бүх нөхцөл байдал, хүрээлэн буй орчноо улам хайрлах тусам дэлхийн дулаарал өдөр өдрөөр намжсаар бүрэн алга болно. Улмаар дэлхийн хүн бүр энх амгалан, аз жаргалтай амьдарч, бие биесээ хайрлах болно. Гэвч хүн бүр үүнийг ухаарч сэрэх ёстой юм.

Манай Дэлхий ухамсрын илүү өндөр түвшинд  
хүрч, Диваажингийн ивээлээр гайхамшгууд  
тохионо гэдэгт би итгэлтэй байна.



## 2

# ХҮН ТӨРӨЛХТНИЙГ СЭРЭЭХ ГЭСЭН АНХААРУУЛАХ ДОХИО

Манай гаргийн байдал ноцтой байгаа учраас хэрвээ бид шуурхай арга хэмжээ авахгүй бол дэлхийгээ хамгаалъя гэж хүссэн ч бидэнд юу ч үлдэхгүй болж болзошгүй. Тэр үед дэндүү оройтсон байх болно. Бид одоогийн хандлагаа хэвээр үргэлжлүүлсээр, гаргаа аврахыг хүсэх үедээ л зогсооно гэж болохгүй. Бидэнд цаг хугацаа маш бага байгааг дуулгахад харамсалтай байна.

## I. БАЙДАЛ ХАМГИЙН МУУГААР ТООЦСОНООС Ч ДОР БАЙНА

Гай гамшиг, үхэл эндэгдэл дагуулж байдаг хар шуурга, үер, ган гачиг, дулаан агаарын давалгаа зэрэг цочир үзэгдлүүд олширсон өнөө үед уур амьсгалын өөрчлөлтийн явц нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний хороо (УАӨЗГМХ/ IPCC<sup>1</sup>)-оос урьдчилан таамагласан хамгийн муу төлөв байдлаас ч дор нөхцөлд байна.

Хүлэмжийн хийн ялгарал буурсан ч агаар мандалд хэдийнээ хуримтлагдсан хийнээс гараг дэлхий ангижирч дахин сэргэхэд нэлээд хугацаа шаардагдана.

Ийм учраас л метан хэмээх богино мөчлөгтэй хийг анхаарах шаардлагатай. 20 жилийн дунджаар авч үзвэл метан нь CO<sub>2</sub>-оос багадаа 72 дахин их дулаан хуримтлуулдаг байна. Метан хийн хамгийн том эх үүсвэр дэлхийн дулаарлын гол шалтгааны нэг бол мал аж ахуйн үйлдвэрлэл тул үүнийг л таслан зогсоох ёстой.

Гэхдээ юуны түрүүнд хүн ба амьтны амь амьдралд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийн талаарх хамгийн сүүлийн үеийн

зарим баримтаас танилцуулахыг минь зөвшөөрнө үү.

## **АРКТИК БА АНТАРКТИДИЙН МӨС ХАЙЛЖ БАЙНА**

### ***Арктикийн мөс хайлж байна***

Арктик буюу Хойд туйлын мөсөн бүрхүүл нь Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний хороо (IPCC)-ноос таамагласан хугацаанаас 70 жилээр урьтаж, 2012 он гэхэд бүрэн хайлж болзошгүй. Нарны тусгалыг буцаан ойлгогч хамгаалалтын мөсөн бүрхүүлгүй болбол нарнаас ирж буй дулааны 90 хувь нь далайн усанд шингэж, улмаар дэлхийн дулаарлыг түргэсгэнэ.<sup>16</sup>


Хойд туйлын мөсөн бүрхүүл их хурдацтай өөрчлөгдөж байна. Цаг уурчдын хэлж буйгаар нийт мөсөн бүрхүүлийн ердөө 10 хувь нь олон жилийн туршид бий болсон зузаан давхарга, харин 90 хувь нь шинээр бий болсон нимгэн давхарга байна.<sup>17</sup>

### ***Эрчээ авсан Дэлхийн дулаарал болон “Хариу үйлдлийн тойрог”***

Далайн усны температур нэмэгдэхэд мөс түргэн хайлна. Нэгэнт мөс хайлсан бол сансрын уудамд дулаан буцаж ойхгүй. Тиймээс дулаан агаарт мөс хурдан хайлж, усны температурыг нэмэгдүүлнэ. Энэхүү хоёр хүчин зүйлсийн нөлөөнд мөс илүү эрчимтэй хайлж, дэлхийн дулаарлыг нэмэгдүүлнэ. Та энэ чөтгөрийн тойргийг ойлгосон байх.

Ийм учраас л эрдэмтэд үүнийг урьд нь маш сайн таамаглаж чадаагүй ч харин одоо маш сонор сэрэмжтэй байна. Тэд нөхцөл байдлыг нүд салгалгүй ажиглаж байна. Бид шуурхай арга хэмжээ авдаггүйд л асуудлын гол байгаа юм.<sup>18</sup>

**Арктикийн тэнгисийн мөсөн хучлагат  
талбайн сарын дундаж хэмжээ  
1979 оны 9 дүгээр сараас 2010 он хүртэл**



Эх сурвалж: Цас мөсний Мэдээллийн Үндэсний төв,  
<http://nsidc.org/arcticseaicenews/index.html>

***Грийнланд болон Антарктидийн мөс хайлж байна***

Грийнланд болон Антарктидийн их хэмжээний мөсөн бүрхүүл хайлсаар байгаа учраас далайн усны түвшин аюултай хэмжээнд хүртэл нэмэгдэж, салхи шуурганы эрч хүч ихсэх төлөвтэй байна. Баруун Антарктидийн мөс бүхэлдээ хайлах тохиолдолд далайн усны дундаж түвшин багадаа 3.3-аас 3.5 метрээр (10.8 - 11.8 фут) нэмэгдэж,<sup>19</sup> далайн эргээс 200 миль радиуст суурьшдаг 3.2 тэрбум хүн буюу дэлхийн нийт хүн амын тал хувь гамшигт нэрвэгдэх аюултай.

АНУ-ын Цас мөсний мэдээллийн Үндэсний төвийн эрдэмтдийн хэлж байгаагаар Антарктидийн мөс бүхэлдээ хайлах тохиолдолд далайн усны түвшин тооцоолж байснаас илүү хэмжээгээр дээшилнэ. Зарим эрдэмтэн 70 хүртэл метрээр (230 фут) нэмэгдэнэ гэж тооцоолж байгаа бөгөөд ингэвэл Дэлхий дээрх бүх амьд оршихуй сөнөх аюултай гэсэн үг.<sup>20</sup>

**Усанд живж буй эх газар ба уур амьсгалын өөрчлөлтөөс болж дүрвэж буй хүмүүс**

Далайн усны түвшин нэмэгдэж байгаагаас арлууд усанд автан




живж байна. Тувалу, Тонга болон бусад 40 арлын үндэстэн нь улсаа бүхэлд нь дүрвэн нүүлгэхээр төлөвлөж байна.

**Шилжилт хөдөлгөөний олон улсын байгууллагын тайланд бидний амьдрах хугацаанд эсвэл 2050 он гэхэд уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаанаар дүрвэгсдийн тоо 200 саяд, эсвэл бүр 1 тэрбумд хүрч болзошгүй гэжээ.**<sup>21</sup> Эд бол далай тэнгисийн усны түвшин нэмэгдсэнээс эсвэл мөнх цэвдэг хайлсны улмаас хот суурингаараа эсвэл улс үндэстнээрээ живэх, сүйрэх аюулаас амиа аврахын тулд арлын, эсвэл эрэг орчмын гэрээ орхих шаардлагатай болсон хүмүүс юм.<sup>22</sup>

(Далайн түвшний өсөлт, түүний дэлхий дахинд үзүүлэх үр нөлөөний талаарх мэдээллийг хавсралт дахь 1-ээс харна уу.)

### Далайн түвшин нэмэгдэх төлөв байдал



Эх сурвалж: НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний хороо, Үнэлгээний 4 дүгээр тайлан, 111, зураг 1.

### Метаны гидрат: Цаг нь явж эхэлсэн тэсрэх бөмбөг

Арктикт гарч буй удаах нэг өөрчлөлт бол газрын хөрсөн доор метаныг [метаны гидрат] хадгалан нөөцлөгч ердийн мөсөн давхарга болох мөнх цэвдгүүд гэсэж байгаа явдал. Сүүлийн жилүүдэд энэ давхарга гэсэж буйн улмаас метан хий чөлөөлөгдөн дэгдэж, агаар мандал дахь түүний хэмжээ 2004 оноос хойш огцом нэмэгдсэн байна.<sup>23</sup>

Дэлхийн дулаарлын түвшин цельсийн 2 хэмээс давж даамжрах тохиолдолд хэдэн тэрбум тонн метан [далайн гүнээс дэгдэн гарах гидрат] чөлөөлөгдөн агаарт дэгдэж, энэ гараг дээрх амьд оршихуй үй олноороо мөхөхөд хүрч болзошгүй.

“Агаарын температур ердөө хэдхэн хэмээр нэмэгдэхэд л эдгээр хий уур болон дэгдэн агаар мандал уруу “цацагдаж” дулаарлыг улам нэмэгдүүлснээр бүр их хэмжээний метан чөлөөлөгдөн, Дэлхий болон далайн усыг тэр хэмжээгээр халаах бөгөөд энэ нь үргэлжлэн давтагдана. Арктикийн хөлдүү тундрын бүсэд 400 гигатон метан хий түгжигдсэн байдаг - энэ нь гинжин урвалыг эхлүүлэхэд хангалттай хүрэлцэнэ... Харин энэ цикл нэг л эхэлбэл дэлхийн дулаарал хяналтаас гарахад хүрнэ.”<sup>24</sup>

— *Геологч Жон Атчесон*

**Бидний санааг зовоож буй зүйл зөвхөн усны түвшин дээшлэх үзэгдэл бус; харин хий: хүхэрт ус төрөгч, метан хий болон далайн усанд байгаа бусад төрлийн хий юм.**<sup>25</sup> Түүнчлэн мөнх цэвдэг, далай тэнгис, мал аж ахуйн салбар зэргээс ялгарах метан нь мөсийг илүү их хэмжээгээр хайлуулна. Ийнхүү хий нэмэгдэн хуримтлагдсаар агаарт удаан хугацаагаар хадгалагдах болно.

Эргэж буцаах боломжгүй хэмжээнд хүрвэл уулын уруу өнхрөхийн адил болно; дахиад ямар ч өөрчлөлт хийх боломжгүй болно. Тэр мөчид бидэнд юу ч туслахгүй. Магадгүй хэн ч эсэн мэнд үлдэхгүй, эсвэл үлдсэн ч маш цөөн байх болов уу.

Манай гараг нэгэнт сүйрвэл Ангараг гараг лугаа адил оршин суурьших боломжгүй болно. Хэрвээ дахиад нөхөн сэргэж болдог юм гэхэд үүнд хэдэн сая, зарим тохиолдолд хэдэн зуун сая жилийн хугацаа шаардагдана.

Бид хурдан өөрчлөгдөх тусмаа л сайн. Тэгвэл бид уур амьсгалын өөрчлөлтийг зогсоож чадна. Бас бид гараг дэлхийгээ нэн даруй, маш хурдан нөхөн сэргээж чадна. Харин өөрчлөлт хийхгүй бол манай гараг дэлхий мөн маш хурдтайгаар сүйрлийн зам уруугаа явна.

## **ТАТАРЧ БУЙ МӨСӨН ГОЛ БА УСНЫ ХОМСДОЛ**

### ***Мөсөн гол татрахын үр нөлөө***

Манай гаргийн мөсөн голын дийлэнх нь хэдхэн арван жилийн дотор хайлж, 2 тэрбум гаруй хүний амь амьдралд аюул учруулах болно. Тэдний 1 тэрбум орчим нь Хималайн уулсын мөсөн бүрхүүл, мөсөн голууд татарч ширгэсний үр нөлөөг шууд амсана. Хималайн мөсөн голууд нь өөр хаана ч байхгүй хурдацтай хайлж ширгэж байгаа бөгөөд тус бүс нутгийн 18000 гаруй мөсөн голын 2/3 нь ширгэсээр байна.<sup>26</sup> Мөсөн бүрхүүл, мөсөн голууд хайлснаас үүдэх эхний үр дагавар бол гамшиг дагуулах үер, хөрсний нуралт юм. Мөсөн голууд хайлах үйл

явц үргэлжлэхийн хэрээр хур тунадасны хэмжээ багасаж, үүний үр дүнд сүйрүүлэх ган гачиг, усны хомсдол үүснэ.<sup>27</sup>

### *Дэлхийн мөсөн голуудын ноцтой нөхцөл байдал*

АНУ-ын Монтана муж дахь Мөсөн голын үндэсний хүрээлэнгийн алдарт мөсөн голууд ердөө арван жилийн дотор хайлж алга болох төлөвтэй байна.<sup>28</sup> Баруун долоон мужийн усан хангамжийн гол эх үүсвэр болдог Колорадо гол [час, мөсний усаар тэжээгддэг] одоо ширгэж байна.<sup>29</sup>

Андын нурууны мөсөн голын 70% нь Перу улсын нутагт оршдог бөгөөд хүн амыг ундны усаар болон усан цахилгаан станцын эрчим хүчээр хангадаг гол эх үүсвэр юм. Энэ бүх мөсөн гол 2015 он гэхэд буюу ердөө хэдхэн жилийн дараа ширгэж болзошгүй байна.<sup>30</sup>

## **ХЭТ ЗАГАСЧЛАЛ, ҮХМЭЛ БҮС, ДАЛАЙН УСНЫ ХҮЧИЛЛЭГШИЛ**

Хэт засгасчлал далайн экосистемд хамгийн их аюул занал учруулж буй хүчин зүйл бөгөөд харин малын ялгадас, малын тэжээл тариалахад хэрэглэдэг бордооны хаягдал нь түүнд нөлөөлөх хоёр дахь хүчин зүйл болохыг АНУ-д байрладаг Пью Коммишн (Pew Commission) байгууллага илрүүлжээ.<sup>31</sup>

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн далай тэнгист үхмэл бүс хэмээн нэрлэгддэг бүс нутаг үүсэж, эдүгээ тоо нь 400 хол давжээ. Бордоо болгон хэрэглэдэг малын ялгадас нь амьдрал тэтгэхэд зайлшгүй шаардлагатай хүчилтөрөгчийн дутагдлыг үүсгэснээс эдгээр [үхмэл бүс] газар нэмэгдэж байна.<sup>32</sup>



*Бразил улсын Рио де Жанейро хотын Копакабана эрэгт үхмэл бүс үүсэхэд нөлөөлсөн улаан түрлэгээр бохирдсон ус*

Сүүлийн 50 жилийн хугацаанд арилжааны зорилготой загас агнуурын улмаас далайн том загасны 90 гаруй хувь нь устсан гэсэн баримжаа тооцоог эрдэмтэд гаргасан байна.<sup>33</sup>

Загас агнуур өнөөгийн хурдаараа үргэлжлэх юм бол 2050 он гэхэд агнуурт өртөж буй бүх төрөл зүйлийн загас устгах юм, тиймээс нөхөн сэргээх арга хэмжээг даруй эхлэх шаардлагатай гэж тэд анхааруулсан байна.<sup>34</sup>

### Дэлхийн далайн төрөл зүйлийн хорогдол: Загас агнуурын уналтын өнөөгийн чиг хандлага



“Далайн төрөл зүйл хурдацтай хорогдох нь хүн төрөлхтний сайн сайхан байдалд аюул учруулдаг,” Science, 11 дүгээр сарын 3, 2006, [http://www.compassionline.org/pdf\\_files/WormEtAlSciencePR.pdf](http://www.compassionline.org/pdf_files/WormEtAlSciencePR.pdf) and B. Worm et al, “Impacts of Хоргодож буй төрөл зүйлийн хувь Loss on Ocean Ecosystem Services.”

Зарим загасны тоо толгой хорогдсон нь далайн усны хүчиллэг орчин нэмэгдэхэд хүргэж, энэ нь эргээд далайн CO<sub>2</sub>-ийг шингээх чадварыг бууруулж байна.

Амьдрах орчны нөхцөл байдал доройтож байгаагаас халим, далайн гахайн амьсгаа нь давчдан, дайжин нүүдэллэж байна. Далайн хордсон усанд байхын аргагүй болсны улмаас заримдаа тэд нэг дор хэдэн зуугаараа далайн эрэг дээр гарч үхэж байна.<sup>35</sup>

## ЦАГ АГААРЫН ЦОЧИР ҮЗЭГДЛҮҮД

Манай Дэлхийн түүхэнд хамгийн өндөр хэмээн бүртгэгдсэн агаарын жилийн дундаж температур өнгөрсөн арван жилийн хугацаанд дор хаяж 2 удаа тохиосон байна. 2003 онд түүхэнд байгаагүйгээр халсан агаарын урсгал Европыг дайрч хэдэн мянган хүний аминд хүрэв. Түүнчлэн халсан агаарын урсгал нь Австралийн түүхэн дэх хамгийн аюулт ой хээрийн түймрийн урьдач нөхцөл болжээ.<sup>36</sup>

Пуэбла Мужид [Мексикт] өнгөрсөн хэдхэн жилийн дотор ойн

түймрийн тоо нэмэгдэж; хур борооны хэмжээ нэг хавтгай дөрвөлжин метр газар тутамд 200 литрээр татарч; агаарын жилийн дундаж температур 17.5 хэм болж өссөн байна. Өвлийн улиралд ч агаарын хэм хэвийн хэмжээнээс өндөр бөрсөн байна.

Сүүлийн таван жилд [2003-2007] Перуд наанадаж гурван удаа хэт халуун тохиосон бөгөөд 500 000 гаруй хүн үерт нэрвэгджээ. Ердөө 30-хан жилийн дотор үер 60 хувиар, хөрсний нүүдэл 400 хувиар нэмэгдсэн байна.<sup>37</sup> 2009 онд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Өмнөд Андын нуруунд хөлдөөхүйц цочир хүйтэрснээс болж 250 орчим хүүхэд амиа алдан, нэлээд хүмүүс өвдсөн тул [Перугийн] Ерөнхийлөгч Гарсиа онц байдал зарласан байдаг.<sup>38</sup>

(Дэлхийн цаг агаарын цочир үзэгдлийн талаарх нэмэлт мэдээллийг хавсралт 3-аас харна уу.)

“Уур амьсгал нь зөвхөн агаарын дундаж температур, хур тунадсаар бус, цаг агаарын үзэгдлийн төрөл, давтамж, идэвхжлээр мөн тодорхойлогддог. Хүний үйл ажиллагаанаас үүдсэн уур амьсгалын өөрчлөлт нь дулааны урсгал, хүйтэн агаарын урсгал, шуурга, үер, ган гачиг зэрэг цочир үзэгдлийн давтамж, тархацад нөлөөлж өөрчлөх боломжтой.”<sup>39</sup>  
— НҮБ-ын Хүрээлэн буй орчныг Хамгаалах Агентлаг

## **БАЙГАЛИЙН ГАМШГИЙН ДАВТАМЖ НЭМЭГДЭЖ БАЙНА**

### ***Ган гачиг, цөлжилт, ой хээрийн түймэр***

НҮБ-ын үзэж байгаагаар, ой модыг их хэмжээгээр огтлох, малын бэлчээрийг талхлах зэргээс үүдэлтэй цөлжилтийн үйл явц нь эрсдэлд буй 100-аад орны 1.2 тэрбум гаруй ард иргэдийн амьдралын сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж байна.<sup>40</sup>

Бээжин, Дели, Бангкок зэрэг томоохон хот, АНУ-ын Баруун мужийн төв хэсэг (Midwestern) гэх мэт хэдэн арван бүс нутгийн цэнгэг усны үнэт нөөц болох газар доорх усны ундаргууд ширгэж байна. Түүнчлэн Ганга, Иордан, Нил, Хөх мөрөн зэрэг гол мөрний усны түвшин жилийн турш доогуур байдаг боллоо.

Хятадад сүүлийн 50 жил тохиож байгаагүй ган [2009 онд] болсноос хойд бүсийн багадаа 12 муж амин чухал ургацаа алдсаны учир хохирол амссан фермерүүдэд тусламж үзүүлэхээр улсаас хэдэн тэрбум америк доллар зарцуулсан байна.<sup>41</sup>

2009 онд Непал болон Австрали улсад гантай байсны улмаас ой

хээрийн түймэр улам идэвхжив.<sup>42</sup> Африк тивийн Сомали, Этиоп, Судан зэрэг улсын иргэд ган гачигт нэрвэгдэн туйлдаж байна.

Уулсын мөнх цасан бүрхүүл хайлан их хэмжээний усны нөөц алдагдаж буйн улмаас АНУ-ын баруун бүс нутагт сүйрэл дагуулах ган гачиг нүүрлэж байгаа талаар судлаачид мэдээлж байна.

(Дэлхийг хамарсан ган гачиг, ой хээрийн түймрийн талаарх нэмэлт мэдээллийг хавсралт 4-өөс харна уу.)

### ***Салхи шуурга, үерийн давтамж нэмэгдэж байна***

Хар салхи, халуун орны хуй салхины хүч, үргэлжлэх хугацаа өнгөрсөн 30 жилд 100% нэмэгдэх хандлагатайг мэдээлж байсныг АНУ-ын Массачусетсийн Техник Технологийн Хүрээлэнгийн (МТТХ) эрдэмтэд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас далайн усны температур дээшилж байгаатай холбоотой хэмээн үзэж байна.

АНУ-ын Жиоржиагийн Технологийн Хүрээлэнгийн судлаачдын үзэж байгаагаар хамгийн их хохирол дагуулсан 4 болон 5 дугаар ангиллын хар салхины тоо хэмжээ сүүлийн 35 жилд дэлхий дахинаа хоёр дахин нэмэгдсэн байна. 5 дугаар ангиллын шуурга том хотуудад маш их хэмжээний сүйрэл авчирчээ. Түүнчлэн тэдгээрийн хүч, үргэлжлэх хугацаа нь 1970-аад оноос хойш 75%-аар өссөн байна.

Эдгээр шуурганы нэг болох 2005 оны Катрина хар салхи нь Нью-Орлеансын газар нутгийг голлон сүйрүүлсэн бөгөөд хар салхины ул мөр одоо ч арилаагүй, нутгийн иргэд өнөөг хүртэл алдсан гэр орон, амьдралаа сэргээж дуусаагүй байна.

АНУ-ын Далай, Агаар мандлын Үндэсний Удирдлагын газраас мэдэгдсэнээр 2008 онд АНУ-ын түүхэнд анх удаа циклон хар салхи 6 удаа дараалан гарч, эх газарт хөрсний нуруулт үүсгэжээ.

Умард Атлантын Далай болон Энэтхэгийн Далай бол хар салхи хамгийн хүчтэй байдаг хоёр бүс юм.

(Дэлхийн томоохон үер усны гамшгийн талаарх нэмэлт мэдээллийг хавсралт дахь 5-аас харна уу.)



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгээс гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлж буй тусламжийн ажил, Пакистан, 2010 он.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгээс гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлж буй тусламжийн ажил, Хаити, 2010 он.

## *Газар хөдлөлт*

Газар хөдлөлт нь дэлхийн дулааралтай холбоотой гэдгийг эрдэмтэд илрүүлжээ. Учир нь хойд туйл болон Грийнлэндийн газар доорх мөс хайлахад Дэлхийн хавтан дээрх даралт өөрчлөгдөж газар хөдлөлтийг өдөөдөг.

Манай орчин цагийн хамгийн эмгэнэлт гамшиг нь 2004 онд дэлхийн хүмүүс, тэр дундаа Индонезийн ард түмэнд асар их уй гашуу авчирсан цунами [газар хөдлөлтөөс үүдсэн] байлаа.

(Дэлхийн газар хөдлөлтийн талаарх нэмэлт мэдээллийг хавсралт дахь 6-аас харна уу.)

## *Хортон шавжийн хөнөөл*

Америкийн Нэгдсэн Улсад Рокки нуруудын 0.4 сая га (нэг сая акр) нарсан ой дэлхийн дулаарлаас дайжин нүүдэллэгч цох хорхойд өртөж сүйрсэн байна. Үүнтэй төстэй нөхцөл байдал Канад улсад ч тохиосон байсан.

## **ОЙН ХОМСДОЛ**

Ширэнгэн ой бол манай гаргийн уушги юм. Ой модыг огтолсноос өвслөг ургамал ил гарч хатахын хэрээр эдгээр нь нүүрсхүчлийн хийг шингээхээс илүүтэйгээр ялгаруулдаг нь бидэнд тулгарч буй өөр нэгэн аюул занал юм.

**Бразил улсад 1970 оноос хойш ой модгүй болсон газар нутгийн 90%-ийг мал бэлчээрлүүлэх, тэжээл тариалах зорилгоор ой модыг нь сүйтгэсэн байна.<sup>43</sup> Минут тутамд 36 хөл бөмбөгийн талбайтай тэнцэх нутаг дэвсгэр дэх өтгөн ойг нүцгэн тал болгодог бөгөөд биднийг ярих зуурт ч ойн модыг огтолсоор байна.<sup>44</sup>**

Нэгэн цагт өмнөд Мексикийн Табаско мужийн бараг хагасыг бүрхдэг байсан халуун бүсийн чийглэг ой мод танагдсаар анхны хэмжээнийхээ 10 хувьд ч хүрэхгүй хэмжээнд хүрсэн байна. Үүнтэй зэрэгцэн малын бэлчээрийн талбай нь мужийн нийт газар нутгийн 60%-д хүрч нэмэгдсэн байна.<sup>45</sup>

Түүнчлэн Аргентин, Парагвай зэрэг улс оронд малын бэлчээр, малын тэжээлийн буурцаг тарих зориулалтаар ой модыг огтолж сүйтгэсээр байна. Аргентин улс байгалийн ой модныхоо 70%-ийг устгасан байна.<sup>46</sup>

Индонез улс нь Амазон, Конгогийн дараа ордог дэлхийн хамгийн том ширэнгэн ойтой гуравдагч улс. Гэвч Индонезийн ширэнгэн ой нь харанга дэлдэх хурдаар буюу минут тутамд нэг хөл бөмбөгийн талбайтай



тэнцэх хэмжээний газар нутагт устаж байна. Дэлхийн ойн 98% нь 15-хан жилийн дотор устаж болзошгүйг НҮБ-аас мэдээлж байна.<sup>47</sup>

Амазоны ширэнгэн ой дангаараа хүн төрөлхтний 10 жил үйлдвэрлэсэн хүлэмжийн хийнээс илүү их хэмжээний нүүрсхүчлийн давхар ислийг агуулж байдаг. Түүгээр зогсохгүй ойг шатаахад ялгарах хөө тортог угаа нь мөн хэмжээний CO<sub>2</sub>-оос 680 дахин их дулаан хураадаг байна.<sup>48</sup>

## БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН АЛДАГДАЛ

Байгаль дахь (зэрлэг) амьтан, ургамлын төрөл зүйл орчин үед харьцуулах ямар ч боломжгүйгээр хурдацтай багасаж байгааг тэргүүлэх экологичид мэдэгдэж байна. Мөн Дэлхийн 16000 гаруй ховордсон амьтан, ургамлын төрөл зүйл өмнө тооцоолж байснаас 100 дахин илүү хурдан устаж болзошгүй гэж эрдэмтэд таамаглаж байна.

Харвардын биологич нэрт эрдэмтэн Эдвард Вилсон болон бусад эрдэмтэн дээрх төрөл зүйлүүд үнэндээ хэвийн хэмжээнээсээ 1000-аас 10000 дахин их хурдацтайгаар устаж байгааг баримжаалан тооцоолжээ. Өдөрт 2.7-оос 270 төрөл зүйлийн ургамал, амьтан газрын хөрснөөс арчигдаж байна.<sup>49</sup>

—*Жулиа Витти*

Бусад хүчин зүйлийг оролцуулалгүй тооцвол зөвхөн дэлхийн дулаарлаас улбаалан Дэлхийн амьд организмын төрөл зүйлийн 20-40% энэ зуунд устах магадлалтай байна.<sup>50</sup>

— *Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний хороо*

## УСНЫ ХОМСДОЛ

Усан хангамж багасаж байгаа нь олон түмний тэр дундаа усаар гачигдсан фермерүүдийн бухимдлыг ихээр төрүүлж, зөрчил дэгдэх хэмжээнд хүргээд байна.

Дэлхий даяар хэдэн арван мянгаараа нуур, гол мөрөн хатаж байна. Ган гачгаас болж хүмүүс өөд болж байна. Ундны усгүй болсон иргэд төрсөн хот тосгоноо орхин нүүж байна.<sup>51</sup>

**1 тэрбум хүн цэвэр, аюулгүй ундны усны хангамжгүй байна. Мөн өдөр бүр 1.8 сая хүүхэд бохир уснаас үүдэлтэй өвчнөөр эндэж байна.**<sup>52</sup>

## ХҮНСНИЙ ХОМСДОЛ

2009 оны байдлаар Дэлхийн хэмжээнд өлсгөлөнд нэрвэгдсэн хүн амын тоо сүүлийн 40 жилд анх удаа хамгийн их байна гэж НҮБ-аас мэдэгдлээ. Дэлхий дээр хүнсний хомсдолд орсон 1.02 тэрбум хүн байна.<sup>53</sup>

Перуд сүүлийн 12 жилд тохиосон хэт халалт, ган гачгийн улмаас 11 сая хүнийг тэжээхэд хүрэлцэх хэмжээний буюу 140000 га газрын төмс, эрдэнэ шишийн ургац алдагджээ.

[Африкийн] Зимбабе, Сомали, Маврикий, Мозамбик, Судан зэрэг улсад хүнд хэцүү ган гачиг тохиолдож байгаагаас газар тариаланд хүндрэл учирч, улмаар хүнсний бүтээгдэхүүний үнэ өртөг нэмэгдэж, хүнсний хомсдол даамжирч байна.

Үүнээс гадна цөлжилт, ойн устгал нь газрын үржил шимийг улам доройтуулж байна. Агаарын хэм нэмэгдэх нь бороо хур хэт бага, эсвэл хэт их орох зэргээр хэлбэлзэхэд хүргэдэг байна. Үүний улмаас ургац аюулт үерт автаж, ойн түймэр газар авч байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн эдгээр үр дагавар нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, хүнсний хямралд хүргэж байна.

(Уур амьсгалын өөрчлөлт болон дэлхийн хоол хүнсний хомсдолын талаарх нэмэлт мэдээллийг хавсралт дахь 7-оос харна уу.)

## ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД

### *Уур амьсгалын өөрчлөлтөөс хүмүүс зовж байна*

Швейцарт хийсэн судалгаа уур амьсгалын өөрчлөлт нь жилд хэдийнээ 315000 орчим хүнийг эндэхэд хүргэж 325 сая хүнд ноцтой нөлөөлж байна.<sup>54</sup> Үүнээс гадна эдийн засагт жил бүр 125 тэрбум ам.долларын алдагдал учруулж байна.<sup>55</sup> Энэ нь Африкийн хөгжиж буй улс орнуудад хамгийн хүндээр тусаж, Өмнөд Ази болон арлын зарим жижиг улсад ч аюул учруулж байна.

Түүнчлэн, байгалийн гамшгаас болж амь үрэгдэгсдийн 99% нь Ази тивд байна.

### *Өвчин эмгэг шавжаар дамжин тархаж байна*

Уур амьсгалын өөрчлөлтөөс болж халуун хумхаа өвчин шумуулаар тээгдэн шинэ газар нутагт тархсанаас Пиура [Перу]-д анх удаа энэ өвчин илрэв.<sup>56</sup>

Шумуул улам ихээр тархаж байгаагаас хумхаа зэрэг өвчний эрсдэл нэмэгдэж байна. Африкийн хэдэн зуун сая хүн өвчний эрсдэлд байгаад НҮБ санаа зовниж байна.<sup>57</sup>

(Марк Линасын Зургаан хэм: Халуун гараг дээрх бидний ирээдүй хэмээх өгүүллийн эшлэлийг хавсралт дахь 8-аас сонирхоно уу.)

## II. БИДЭНД МАШ БАГА ХУГАЦАА ҮЛДСЭН

Өнөөг хүртэлх шинжлэх ухааны болон бодит бүхий л баримт нотолгоо бидэнд цаг хугацаа маш бага үлдсэнийг харуулж байна. Бага зэрэг хойшлуулбал бидэнд гараг дэлхийгээ аврах хүсэл байгаад ч амжилт олохгүй.

**Дэлхийн дулаарлын аюул хэдийнээ хаяанд тулж ирчихээд байна, үүний нотолгоо нь дэлхийн эргэн тойронд болж буй олон онцгой үзэгдэл, гамшиг, уур амьсгалын шалтгаанаар дүрвэгсэд, үймээн самуун юм.**

**Агаарын температур маш огцом өсөж байгаа энэ үед бидэнд өөрчлөлт хийх багахан цаг үлдсэн гэж шинжээч эрдэмтэд үзэж байна.**

“Бид хэдийнээ эргэлт буцалтгүй цэгт хүрээд өнгөрч байна. Харин буцах замгүй болох цэгийг хараахан дайрч өнгөрөөгүй байна. Бидэнд нөхцөл байдлыг эргүүлэх боломж бий. Гэхдээ үүний тулд хандлагаа нэн даруй өөрчлөх шаардлагатай.”<sup>58</sup>

— Др. Жэймс Хансен, НАСА-гийн Сансар судлалын Годдард Хүрээлэнгийн тэргүүн

Олон улс орны тэргүүн, эрдэмтэд энэ талаар санаа зовниж байна. Дэлхийн дулаарал хэдийнээ туйлын дээд цэгтээ хүрсэн бүс нутагт бид нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээ авч чадахгүй болсон нь үнэн.

Зарим улс орны хүмүүс ган гачгийн улмаас хүндэрч буй нөхцөл байдлыг даван туулах ёстой болоод байна. Тариалангийн усалгаанд төдийгүй унданд хэрэглэх ус нь хүрэлцэхгүй байна. Нуур, гол мөрөн татарч, зарим нь бүрмөсөн хатаж байна. Олон газарт мөнх цэвдэг, мөсөн голууд хурдацтайгаар хайлж байгаа нь нэг дор их хэмжээний үер буух, удалгүй ган болоход хүргэж байна.

Тэгээд цөлжилт, далайн усны түвшин нэмэгдэх, тариан талбайгаа бүрмөсөн алдах зэргээс болж бөөн бөөнөөрөө дүрвэн нүүж буй хэдэн арван сая хүнийг бид бүгдийг нь нэг дор хэрхэн зохицуулах вэ? Энэ нь маш хэцүү, бүр боломжгүй ч байж мэднэ.

Бид ер бэлэн биш байна. Бид хангалттай бэлтгэгдээгүй байна.

Юуны өмнө бид өөрсдөө амьд үлдэхийн тулд гараг дэлхийгээ аврах хэрэгтэй. Учир нь мөс, туйлын мөс бүхэлдээ хайлбал, тэгээд далайн ус халбал, далайгаас их хэмжээний метан хий гарч агаарт дэгдсэнээр бид бүгд хордож болзошгүй. Энэ нь маш их хэмжээний хий.

Сингапурт зохион байгуулсан лекцэнд [1994 оны 9 дүгээр сар], бид амьдралын хэв маягаа өөрчлөх хэрэгтэй; эс тэгвээс дэндүү оройтох болно гэдгийг хэдийнээ анхааруулсан. Энэ нь 10, 15 жилийн өмнөх явдал. Түүнээс ч өмнө хүмүүс бид ой модоо огтлох, махан хүнсээр хооллох зэргээр гараг Дэлхийдээ их хор хохирол учруулж байгаа талаар

би байнга л ярьж байсан.

Эрдэмтэд олон зүйлийг хэлж байна. Тэд одоо л сонсож байна, тэд түргэн арга хэмжээ авна байх гэж би найдаж байна. Гол нь бодит арга хэмжээ авах хэрэгтэй байна. Дэлхийн бүх улсын Засгийн газар одоо л үүнд үнэхээр нухацтай хандаж байна. Гол нь арга хэмжээг яаралтай авалгүй хэт цалгардах вий хэмээн би зовниж байна. Яагаад гэвэл дэлхийн мөсөн бүрхүүл нарны туяаг сансрын уудамд ойлгож буцаадаг, гэвч одоо мөсөн бүрхүүл маш хурдацтай хайлж байгаагаас хангалттай буцааж ойлгохгүй байгаа бөгөөд нэгэнт бүлээссэн далайн ус нь мөсийг хайлуулдаг. Тэгээд мөс хайлснаар далай тэнгисийн ус улам бүлээсэж байна. Миний хэлээд байгаа энэ эргэх мөчлөгийг та ойлгож байна уу?

Одоогийн энэ байдлыг засаж залруулахгүй бол дөрөв юм уу таван жилийн дараа гэхэд бүх зүйл дуусна. Юу ч үлдэхгүй. Ийм л тулгамдуу болчихоод байна.

### III. ОДОО АСУУДЛЫН ГОЛ ШАЛТГААНЫГ АРИЛГАЯ

#### ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ДОРОЙТЛЫН ХАМГИЙН ТОМ ШАЛТГААНЫГ ТАСЛАН ЗОГСООЁ

“Мал аж ахуй бол өнөөгийн хүрээлэн буй орчны нэн ноцтой асуудал үүсэхэд хамгийн ихээр нөлөөлөгч хүчин зүйлийн нэг юм. Энэ нөхцөл байдлыг эргүүлэхэд яаралтай арга хэмжээг авах хэрэгтэй байна.”<sup>59</sup>

— Др. Хеннинг Штайнфелд, Мал аж ахуйн мэдээлэл бодлогын салбарын ахлагч, Хүнс ХАА-н байгууллага, НҮБ

“Мал аж ахуй бол ой модыг сүйтгэж буй гол шалтгаан. Мал аж ахуй бол усыг бохирдуулдаг хамгийн том, ганц эх үүсвэр. Мал аж ахуй нь дэлхийн бүх тээврийн хэрэгслийг нийлүүлснээс илүү их хүлэмжийн хийг ялгаруулдаг.”

— Мал аж ахуйн холч тусгал, НҮБ-ын Хүнс Хөдөө аж ахуйн байгууллага

Дэлхийн дулаарлын асуудал бүрд СО<sub>2</sub>-ийг буруутгахаа больё. Бид өөрсдийгөө буруутгавал зохино. Махны үйлдвэрлэлийг буруутгах хэрэгтэй. Махны үйлдвэрлэл бол бидний анхаарлаа хандуулж, таслан зогсоовол зохих тэр зүйл мөн. Уур амьсгалын

**өөрчлөлтийг болон ой мод, газар нутгаа үй олноор сүйтгэх явдлыг зогсоохын тулд гол асуудлаа тойрч ярихаа зогсооё. Гол асуудлаа ярья: Махны үйлдвэрлэлийг зогсоох ёстой.**

Улам дордож буй дэлхийн дулаарлыг зогсоох хамгийн ухаалаг шийдэл бол веган болох явдал. Энэ нь тун энгийн сонсогдох ч хамгийн шилдэг, хамгийн үр нөлөөтэй шийдэл бөгөөд үр дүнг бараг тэр даруйдаа мэдрэх болно. Хамгийн богино хугацаанд үр дүнгээ өгөх энэ арга замыг хэрэгжүүлэхгүйгээр бидний ямар ч зүтгэл, оролдлого нэгэнт бий болсон аймшигт гэж болох үр дагавруудыг үлдэн хөөж дийлэхгүй.

Түүнчлэн, бидэнд яг одоо нүүрлээд буй – агаарын хэт халалт, дулаарал, усны хомсдол, хүнсний хомсдол, цөлжилт зэрэг асуудлыг бид махны үйлдвэрлэлийг зогсоосноор түргэн гэгч нь шийдэж чадна. Үүнийг хойшлуулалгүй, одоо л зогсооё!

“Мах бүү ид. Энэ нь Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжлийн хорооны урьд нь хэлэхээсээ айдаг байсан зүйл ч одоо бид хэлээд байна: Мах бага иднэ үү — мах бол нүүрстөрөгчийн хийг маш ихээр үүсгэдэг бүтээгдэхүүн юм.”<sup>60</sup>

— *ДОКТОР. РАЖЕНДРА К. ПАЧАУРИ*

## **ҮНДСЭН АСУУДАЛ УГТАА СҮНСЛЭГ УТГА УЧИРТАЙ**

“Цагаан хоолноос өөр ямар ч хувьсал хүн төрөлтний эрүүл мэнд болоод дэлхий дээр эсэн мэнд аж төрөх боломжийг нэмэгдүүлэхэд ач тустай байж чадахгүй.”<sup>61</sup>

— *АЛЬБЕРТ ЭЙНШТЕЙН*

Өмнө дурдсанчлан бид асуудлын үндсэн шалтгааныг арилгах хэрэгтэй. Асуудлын үндэс суурь нь дэлхийг дулаарахад хүргэж буй тэр шалтгаан. Мөн энэ нь хүмүүс дэлхий дээр зэрэгцэн оршиж буй бусад амьд оршихуйд энэрэл нигүүлсэлгүй, зүй бус харилцаж байгаа явдал юм.

**Үйлдэл бүр хариу үйлдлийг өдөөдөг, энэ нь ч шинжлэх ухааны үндэслэлтэй.**

Хэрвээ бид алимын үр таривал алимын модтой болж, хэсэг хугацааны дараа тэрхүү мод бидэнд алимаа хүртгээх болно, үүнийг та ойлгож байна уу. Энэ бол амьдралын тойрог юм. Хэрэв бид амь хөнөөвөл түүнийгээ л төлнө. Үйлдэл бүр яг түүнтэй ижил үр дагаврыг дагуулна. Энэ шашны тухай яриа биш, энэ бол шинжлэх ухаанч ойлголт.

Тиймээс бидний асуудлын уг шалтгаан нь энэ дэлхий дээр бидэнтэй зэрэгцэн оршиж амьдардаг, мэдэрдэг, алхдаг, үйлддэг, хайрладаг, амьтан шиг бүхий л төрөл хэлбэр, хэмжээтэй төрөлтнүүдэд бид өрөвдөх сэтгэлгүйгээр зүй бус, харгис ханддаг оршино. Үүний зэрэгцээ бид хүрээлэн буй орчиндоо найрсаг бус хандаж байна. Ингэж л бид зэрэгцэн орших амьтдыг үй олноор нь хөнөөж, ой модыг огтлох, ус, агаар мандлыг бохирдуулах зэргээр хүрээлэн буй орчноо сүйтгэж ирсэн байна. Бид энэ бүх үйлдлээсээ сайн үр дүнг хүлээгээд ч нэмэргүй.

Давчуу, бохир заваан торонд хэзээ ч нар харахгүй, бөглүү харанхуйд амьдарч, алуулахын өмнө бас дараа нь ч туйлдталаа амьтэмцэн зовдог амьтдын гашуудалтай уйлаан майлаан, хэтэрхий ахадсан зовуурь шаналгаа Тэнгэр Газрыг донсолгон цуурайтаж байна.

Тийм учраас амьтдад тохиосонтой адил зовлонгоос ангид, гэрэлтэй, аз жаргалтай ирээдүйтэй золгохын тулд сайн тал уруугаа өөрчлөгдөх хэрэгтэйг хүн төрөлхтөнд анхааруулж, муу үйлийн үрийг нь угаан зайлуулах үүднээс энэ олон байгалийн гамшиг, ган гачиг тохиож байгаа юм.

“Бид юу тарина, түүнийгээ хурааж авна.” гэдгийг бидэнд аль ч ариун судар сургадаг, тиймээс хүн төрөлхтөн сэхээрэх хэрэгтэй байна; эс бөгөөс бид үр дагаврыг нь үүрэх л болно.

Тэгэхээр бид өдгөө тулгараад буй асуудлаа шийдье гэвэл бид үйлдлүүдээ сайн тал уруу өөрчлөх хэрэгтэй. Бидэнтэй зэрэгцэн орших амьтдад нигүүлсэнгүй сэтгэлээр хандах хэрэгтэй. Тэднийг золиосолж, хөнөөж, хүйс тэмтрэхийн оронд элэгсэг нигүүлсэнгүй хандаж, халамж анхаарал тавивал зохино. Ойн модыг огтлохын оронд мод таривал зохилтой. Биднийг хүрээлэн буй ямар ч орчинг анхаарч халамжил. Гараг дэлхийгээ, агаар мандлаа бохирдуулахын оронд бид байгальд ээлтэй эрчим хүчний хэрэглээнд шилжих хэрэгтэй. Ердөө л хийж байсан буруу үйлдлүүдээ буцааж залруулах шаардлагатай.

Бид орчлон ертөнцийн энергитэй, байгалийн хайрын хуульд зохицол нийцэлтэй амьдрах хэрэгтэй. Хүн төрөлхтөн бусад хэлбэрийн амьд оршихуйг хүндлэхгүй байх аваас хүмүүний амьдрал ч мөхнө, яагаад гэвэл бид бүгдээрээ хоорондоо шүтэн барилдлагатай оршдог.

Эсэн мэнд байхын тулд бид бүгдээрээ бие биеэсээ, хөрс шороог сийрэгжүүлж өгдөг жижигхэн өтнөөс ч хүртэл хамааралтай оршдог. Хэрвээ хүмүүс амь хөнөөхөөс татгалзаж, амьтны гаралтай бүтээгдэхүүнээс-ангид аж төрөхүйг сонговол энх тайван болон нинжин сэтгэлийн үрийг хураана.

Бидэнд бага цаг үлдсэн тул олон хүн зөв зохистой үйлдлийг хурдан хийхийн төлөө бид залбирдаг.

## **ХАЙРЛАН ЭНЭРЭГЧ МӨН ЧАНАРАА ЭРГЭН ОЛЖ, ГАРАГ ДЭЛХИЙГЭЭ АВАРЬЯ**

Байгалийн гамшиг бол бидний агаар мандал дахь сөрөг энергийн үр дагавар гэдгийг бид ухаарах ёстой. Агаар мандал дахь энэ сөрөг энерги нь бидний бодол санаа, мэдрэмж, бас бидний үзэн ядалт, хүчирхийлэл болон үй олон хүн, гэм зэмгүй амьтдын амийг егүүтгэсэн үйлдлээс үүсдэг. Бид гамшигийг тэтгэж, өдөөж байдаг арга үйлдлээ өөрчлөхгүй аваас гамшиг хэзээ ч төгсөхгүй.

Бид бодол сэтгэхүй болон амьдралынхаа хэв маягийг илүү өндөр, илүү энэрэнгүй, эрхэм ариун түвшинд хүргэх өөрчлөлтийг хийх ёстой. Бид бүхий л амьд оршихуйг нандигнан хамгаалж, нэн үнэ цэнэтэй, үзэсгэлэнтэй гараг дэлхийгээ аврахад туслах веган хоолонд даруй шилжсэнээр өөрийнхөө жинхэнэ хайрлагч би-дээ буцаж орох ёстой. Веган (ургамал хоолтон), цагаан хоолтон байх нь хамгийн шилдэг, үр дүнгээ хамгийн түргэн өгөх шийдэл юм.

Веган байх нь аль ч төрлийн сүнслэг дэвшилд ач тусаа өгдөг. Чухамдаа бол өнө эртнээс авхуулаад бүхий л гэгээнтэн мэргэд ургамалд суурилсан энэрэнгүй хүнсний ач тусыг онцлон сургасан байдаг билээ. Энэ бол сүнслэг бясалгагчид тавих үндсэн шаардлага.

**Амьтны гаралтай бүтээгдэхүүнээс татгалзахын цаад ухагдахуун нь ахимса буюу үл хүчирхийлэхүй юм. Веган хүнсийг сонгосноороо бид бас аллагын муу үйлийн үрээс зайлсхийж, улмаар сүнслэг аялалдаа дарамт, саад учруулахгүй байх болно.**

Веган байх нь энгийн утгаараа бид бүх амьтныг хамгаалж байна гэсэн үг. Хүн төрөлхтөн өндөр соёл иргэншил өөд дэвшин хөгжихийн тулд бусад төрөлтний амийг хөнөөдөг үйлдлээ зогсоох ёстой. Үүнийг хийсний ач тус их олон. Бидний эрүүл мэнд сэргэхээс гадна биологийн олон янз байдал цэцэглэн хөгжиж, гараг дэлхийн маань тэнцвэр сэргэн, оюун санаа, ухамсрын ачаа дарамт хөнгөрч, дээш хурдан дэвших болно.

Энэ бүхэн бүгд энэрэнгүй хүнсний үр шим юм. Бүхнийг хайрлагч ийм чиг хандлага нь энх амгалан уур амьсгалыг бүрдүүлж, хамаг төрөлтний ая тухыг хангах болно. Ахан дүүс болох амьтдад зовлон шаналал учруулаагүй гэдгээ мэдэж өөрөө амар амгалан байснаараа хүмүүс сүнслэг дэвшлийн төлөө чин сэтгэлээсээ зүтгэхэд хэрэгтэй дотоодын амар амгаланг олж авах болно.

Өргөн утгаараа гараг дэлхий маань ч илааршиж эдгэнэ. Яг л хувь хүн энэрэнгүй хүнсэнд шилжсэнээрээ эдгэрдэг шиг л – ижил нь ижлээ татна. Асрал энэрэл, хайрлахуй, энэрэхүй энерги нь бидэнд заналхийлж буй, яг одоо дэргэд ирчихээд байгаа харанхуй сөрөг хүчийг хөөн зайлуулах болно. Товчоор хэлбэл, бид Дэлхийгээ диваажин болгоно.

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найраг*

## **СЭРЖ СЭХЭЭРЭГТҮН!**

Хан ертөнц минь, сэрэхтүн, сэхээрэгтүн !  
Уул толгод, ус мөрөн үймрэн хямралдаж  
Уугин шатсан ой, угаагдсан толгод, ширгэсэн гол л үлджээ  
Хамаг мөрөөдөл нь сүйрсний дараа хөөрхий сүнснүүд хаашаа одох вэ?

Аугаа сайхан Дэлхий минь, зовлон чинь шөнөдөө нимгэрсээр  
Асгарах нулимсандаа угаагдан арилах болтугай,  
Амьтан хүн бүхэнд маргаашийн найдварыг өгөгч  
Аялгуу дуугаа бүү зогсоо, тэнгис далайнууд минь...

Хамаг амьтад та мину, эцсийн үг өчиггүй эндээс явсан ч гэлээ  
Холын чанад ертөнцөд жаахан амсхий дээ  
Хүмүүсийг цагаа олж наманчлахыг нь хүлээх зуур  
Халуун зүрх минь түгшин аюуж бүү цохилог.

Аглагхан ой мод минь, уг чанараа хадгалж  
Алдах цагт нь хүмүүн төрөлтнийг хамгаал  
Авч үз, чин үнэн сэтгэлийн минь нулимсыг  
Аугаа сүрлэг модод, навч, үндсэнд тань тэжээл болог.

Өр зүрх минь, уйлан хайлахаа аяд  
Өнө урт шөнөөр сэтгэлийг минь амирлуул.  
Уй зовлонд шаналагсдыг өрөвдөн энэрсээр  
Урсах нулимс эгшиж, урсгах үг цөөрч ээ!



Харанхуй түнэр шөнө минь, гэрэл гэгээгээ асаа  
Хэсүүчлэн тэнэх сүнснүүдэд хүрэх замыг нь заа  
Хосгүй гайхамшигт тэнгэрлэг аялгуунд умбан  
Хоосон чанарт нэвтрэхийн төлөө ухаан бодол минь амарлиж үз.

Алагхан зүрхийг минь амирлуулахын төлөө  
Аюулт дайн дажныг намжаахын төлөө  
Аугаа жинхэнэ БИ минь алдаршин гийхийн төлөө  
Аяа, гэгээн өдөр минь, гэнэт бүү догдлон үймэр!

Аяа зүрх сэтгэл минь ээ, тэсгим өвлийн жаварт  
Аюун тарчлагч шавьж хорхой мэт ахин бүү гунь.  
Тэнгэрлэг гэрлээр ертөнц адислуулан гангарах өдрийг,  
Төгс төгөлдөр маргаашийг айван тайванхан хүлээ.

Аяа, тэнцэшгүй их Будда, Бурхад хийгээд Тэнгэр Элчис мину!  
Аврал эрэн уйлан хайлнам, залбирч, гуйнам, би.  
Үнэний Замаас төөрөн элчилгүй тамын тойрогт тэнүүчлэх  
Үйлт хөөрхий сүнснүүдийг энэрэн чөлөөлж хайрла!

Аяа, ах минь, үтэр түргэн сэрэхтүн!  
Аугаа тэнгис далай, мөрөн голын мандлаар бардамхан алх.  
Асан дүрэлзэх наран өөд эгцлэн хар,  
Алтан дэлхийг аварна аа гэж, амлан тангарагла.

Аяа, эгч минь ээ, яг одоо сэрэхтүн!  
Алдарч сүйрсэн сууринаасаа өндийн бос  
Эвийн дуугаа цэнгэлтэйеэ дуулахын төлөө  
Эх дэлхийгээ хамтаараа сэргээн мандуулсу.

# 3

## ГАРАГ ДЭЛХИЙГ ИЛААРШУУЛАХ ОРГАНИК ВЕГАНИЗМ

Веганизм дэлхийг аварна. Ургамалд-суурилсан хүнсэнд шилжих нь дэлхийн дулаарлыг 80%-аар бууруулж, дэлхийд өлсгөлөн үгүй болж, дайн дажин эцэслэж, энх тайван дэлгэрч, ус болон бусад олон үнэт нөөцийг устахаас хамгаалан, гараг дэлхий болон хүн төрөлхтний авралын зам болно. Товчхондоо, үүгээр яг одоо дэлхий даяар бидэнд нүүрлээд байгаа маш олон бэрхшээлийг нэн хурдан шийднэ.

Хойд туйлын мөс хайлах, эх газар усанд автах, мөсөн голууд дундарч, хатаж эхэлснээр усны хомсдол үүсэх, салхи шуурга улам их нэмэгдэх зэрэг бидний нүдэнд харагдаж буй уур амьсгалын өөрчлөлтийн ихэнх сөрөг үр дагавар нь Дэлхийн агаарын хэм өсөж байгаатай холбоотой. Тиймээс бид нэн түрүүнд эх дэлхийгээ буцааж сэрүүцүүлэх хэрэгтэй. Дэлхийн дулаарлыг зогсоох хамгийн сайн арга бол дулааныг үүсгэгч хүлэмжийн хийн ялгаралтыг зогсоох явдал юм.

Аж үйлдвэр, тээврийн салбараас ялгарч буй хийг багасгах хүчин зүтгэлийн талаар бид хэдийнээ мэдэж байгаа. Гэхдээ эдгээр салбар дахь өөрчлөлт нь энэ цаг мөчид, энэ л эрчээрээ бидний хийж чадахаас илүү их цаг авч байна. **Агаар дахь дулааныг багасгах хамгийн үр нөлөөтэй, түргэн аргуудын нэг нь метаны үйлдвэрлэлийг халах асуудал юм.**

Метан хий нь нүүрсхүчлийн давхар ислээс 72 дахин их дулааныг хуримтлуулдагаас гадна агаар мандалд  $\text{CO}_2$ -оос илүү хурдан задардаг. Иймд бид нүүрсхүчлийн давхар ислийг бус харин метаны үйлдвэрлэлийг л зогсоовол агаар мандал харьцангуй түргэн сэрүүснэ.

**Органик веган хүнс нь бидэнд хамгийн хор хөнөөлтэй метан болон бусад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах учраас үр ашигтай ба агаарыг сэрүүцүүлэх нөлөөтэй.**

Органик гэсний учир бол химийн хорт бодисууд хаа сайгүй тарж, далайн усанд нэвчиж, гол мөрөн, хөрс, амьд организмуудыг хордуулан, хүмүүсийг өвчлүүлэх явдлыг бид хүсдэггүйтэй холбоотой. Мөн органик веган тариалалт агаарт хуримтлагдсан CO<sub>2</sub>-ийг их хэмжээгээр шингээх бөгөөд улмаар дэлхийг сэрүүцүүлнэ.

## **I. ГАРАГ ДЭЛХИЙГЭЭ СЭРҮҮЦҮҮЛЖ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭЕ**

### **МЕТАН ХИЙ, ХАР НҮҮРСТӨРӨГЧ, БУСАД ХҮЛЭМЖИЙН ХИЙГ ХАЛЪЯ**

*Мал аж ахуй бол метаныг хамгийн их хэмжээгээр ялгаруулагч*

Хамгийн аюултай хий бол нүүрсхүчлийн давхар исэл бус; харин метан юм. Метаны эх үүсвэр нь мал аж ахуй, мал үржүүлгийн ажил юм.

Бид дэлхий дээрх метаны хамгийн гол эх үүсвэр болох мал үржүүлгийг багасгахаас эхэлж болно шүү дээ. Тиймээс Дэлхийг үтэр түргэн сэрүүцүүлэхийн тулд бид махны хэрэглээгээ зогсоох хэрэгтэй, ингэвэл мал үржүүлэг зогсож, улмаар мал аж ахуйгаас үүдэлтэй хүлэмжийн хий, метан, бусад хорт хийн ялгаралт зогсох болно.

## Хүлэмжийн хий болон түүний дэлхийн дулааралд үзүүлэх нөлөө

Хүлэмжийн хий	CO <sub>2</sub> (нүүрс хүчлийн хий)	CH <sub>4</sub> (метан)	N <sub>2</sub> O (азотын хүчил)
Дэлхийн дулааралд үзүүлэх нөлөө (GWP)*	1	25*	298*
Аж үйлдвэржилтийн- өмнөх үеийн агаар дахь агуулга	280 ppm	0.715 ppm	0.270 ppm
Агаар дахь агуулга, 2005 онд	379 ppm	1.774 ppm	0.319 ppm
Мал аж ахуйн салбараас үүсдэг хэмжээ, хувиар **	9%	37%	65%

\* 100 жилийн дундаж утгыг авч үзвэл, метан болон азотын хүчил дэлхий дулааралд үзүүлэх нөлөө нь нүүрсхүчлийн хийнээс 25 болон 298 дахин их байна. 20 жилийн дундаж утгыг авч үзвэл, метан нь нүүрсхүчлийн хийнээс 72 дахин их байна. (Сая хуваасны нэг (ppm) гэдэг нь 1000000 хэсгийн нэг хэсэг гэдгийг илтгэнэ) (НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний хороо, Жилийн үнэлгээний 4 дэх тайлан, 2007, Хүснэгт 2.14)

\*\* (Штайнфелд ба бусад., Мал аж ахуйн урт сүүдэр, 2006)

Хүн бүр ургамлын (амьтны бус) гаралтай хүнс хэрэглэх дадлыг хэвшүүлбэл бид нэн даруй дэлхийн дулаарлын үр нөлөөг зогсоож чадна. Тэгснээр бид агаар мандлаас нүүрсхүчлийн хийг зайлуулах, байгальд ээлтэй ногоон технологи нэвтрүүлэхэд шаардлагатай урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой болно.

Үнэндээ, хэрэв бид махны үйлдвэрлэлийг зогсоохгүй бол ногоон технологийг нэвтрүүлэх гэсэн бидний бүхий л хичээл зүтгэл талаар болох буюу биднийг салхи, нарны эрчим хүч, гибрид машин зэрэг ногоон технологийг нэвтрүүлэхээс урьтан дэлхий маань сүйрч болзошгүй байна.

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй метан хийг үүсгэгч хамгийн том эх үүсвэр нь мал аж ахуйн салбар бөгөөд энэхүү хий нь нэг удаадаа нүүрсхүчлийн хийн 5 жилийн хугацаанд хуримтлуулах дулаанаас 100

дахин их дулааныг хуримтлуулдаг гэж АНУ-ын Агаарын нислэг, сансрын уудмыг шинжлэн судлах агентлагийн судлаачид саяхан мэдэгджээ.

“20 жилийн хугацаанд метан хий нь Дэлхийн дулааны хэмжээг  $\text{CO}_2$ -оос 72 дахин нэмэгдүүлдэг.”<sup>62</sup>

— Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний хороо

“5 жилийн хугацаанд метан нь дэлхийн дулааныг  $\text{CO}_2$ -оос 100 дахин ихээр нэмэгдүүлдэг.”

“Эдүгээ нэг өдөр ялгарсан 1 тонн метанаас ганцхан жилийн дотор хуримтлагдах дулааны хэмжээ нь мөн өдөр ялгарсан 1 тонн  $\text{CO}_2$ -оос 2075 он хүртэл хуримтлагдах дулааны хэмжээнээс их байх болно.”<sup>63</sup>

— Др Кирк Смит, Дэлхийн Хүрээлэн буй орчны Эрүүл мэндийн Профессор, Калифорнийн Их Сургууль, Беркелэй

Хэдийгээр мал аж ахуй нь дэлхийн нийт хүлэмжийн хийн 18%-ийг буюу дэлхийн бүх тээврийн хэрэгслийн үзүүлж буй нөлөөг нийлүүлснээс ч их хийг ялгаруулдаг гэж тайлагнасан байдаг нь үнэндээ бууруулж гаргасан тооцоо юм. Учир нь саяхан хийсэн шинэ тооцоогоор мал аж ахуйн салбар нь нийт хорт хийн ялгарлын 50 гаруй хувийг үүсгэдэг байж болзошгүй гэжээ. Энэ бүхнийг та анхаарч үзнэ үү. **Би давтан хэлье: Шинэчилсэн тооцооллоор мал аж ахуй нь дэлхийн нийт хүлэмжийн хийн 50-иас ч илүү хувийг ялгаруулдаг байж болзошгүй, энэхүү 50-иас илүү хувь нь мал аж ахуйн үйлдвэрлэлээс үүсэж байна. Тийм учраас маань үйлдвэрлэлийг зогсоох нь нэн тэргүүний шийдэл юм.**<sup>64</sup>

### *Метаны гидрат болон хүхэрт устөрөгчийн хор хөнөөл*

Хүйтэн сэрүүн нөхцөлд метаны гидрат [methane hydrate] нь далайн ёроолд хөдөлшгүй, хал балгүй хадгалагдаж байдаг. Гэвч өнөөгийн уур амьсгалын дулаарлаас үүдэн энэхүү хий чөлөөлөгдөж болзошгүй байна. Тэдгээр нь хэдийнээ агаар мандалд нэвчээд эхэлчихсэн гэдгийг та шинжлэх ухааны тайлангуудаас мэдсэн байх. Мөнх цэвдэг давхарга өдөр бүр хайлж байна.<sup>65</sup>

Дэлхийн мөсөн бүрхүүл дор аюулгүй хадгалагдаж байсан метан хий хаа нэгтээ бургилж эхэлж байгааг болон далай тэнгисийн байдлыг ажихад аюулт цаг мөч айсуын шинж тэмдгүүд хэдийнэ ил үзэгдэж эхэлж байна.<sup>66</sup> Асар их хэмжээгээр хяналтгүй ялгарч, дулаарлыг хяналтгүйгээр хурдасгах хэмжээнд температурыг огцом өсгөх тэр нэг өдөр хэзээ вэ? гэдгийг хэн ч мэдэхгүй. Энэ нь бидэнд их хэмжээний аюул сүйтгэл авч ирнэ.

“Мөнх цэвдэг нь яг л дэлбэрэхэд бэлэн болсон бөмбөг мэт — мөнх цэвдэг хайлахын хэрээр хэдэн мянган тераграмм метан хий чөлөөлөгдөн гарч агаар мандалд нэвчиж, уур амьсгалын дулаарлыг түргэсгэх болно. Шинээр илэрсэн метаны энэхүү үүсгэврийг өдийг хүртэл цаг уурын загварчлалд тусгаж байгаагүй юм.”<sup>67</sup> (нэг тераграмм = нэг сая тонн)

— Др. Кэйти Волтерс, Аляскагийн Их сургуулийн  
Усны Экосистемийн Экологич

Бидний санааг зовоож байгаа нь зөвхөн метан биш юм. Далайгаас дэгдэн гардаг маш олон хий байдаг. [Жишээлбэл:] хүхэрт ус төрөгч нь дэлхийн өнгөрсөн түүхэнд амьд организмын 90 гаруй хувийг газрын хөрснөөс арчиж байжээ.<sup>68</sup>

Концентрацын хэмжээнээс хамаараад хүхэрт ус төрөгч дангаараа биеийн эд эрхтнүүд гэмтэхэд хүргэнэ, тухайлбал: нүд, хамар, хоолой, амьсгалын замын хүндрэл, үр зулбах, биеийн үйл ажиллагааны доройтол, толгойн өвчин, толгой эргэх, дотор муухайрч бөөлжис хүрэх, ханиалгах, амьсгалахад хэцүү болох, нүд гэмтэх, цочирдох, ухаан алдах, үхэх гэх мэт.

Дэлхийн дулаарлаас биш юмаа гэхэд зөвхөн эдгээр хийн нөлөөнөөс болоод бид эндэж болзошгүй. Эдүгээ агаарт маш их хэмжээний метан тархсан байгаа учраас хүмүүс олноороо сэтгэцийн болон бие махбодийн өвчнөөр зовуурилж байгааг эрдэмтдийн судалгаанууд харуулж байна.

Метан хий нь толгойн өвчин, амьсгалын замын тогтолцоо болон зүрхний хэм алдагдах эмгэгийг үүсгэдэг бөгөөд илүү өндөр тунтай метан хий нь амьсгал боогдон эндэх аюулд хүргэнэ. Энэ нь нүүрстөрөгчийн дутуу исэлтэй (carbon monoxide) адил хоруу нөлөөтэй бөгөөд CO<sub>2</sub> (нүүрстөрөгчийн хийнээс) 23 дахин илүү үхлийн аюултай.

### ***Мал аж ахуйгаас үүсдэг үхлийн аюултай бусад хий***

Мал аж ахуйн үйлдвэрлэл нь үхлийн аюултай бусад төрлийн хорт хийг ч бас үүсгэдэг. Мал аж ахуй нь дулаарлыг CO<sub>2</sub>-оос ойролцоогоор 300 дахин ихэсгэх нөлөөтэй хүлэмжийн хий болох дэлхийн азотын хүчлийн 65%-ийг үүсгэдэг хамгийн том эх сурвалж юм. Түүнчлэн хүчиллэг бороо, хүхэрт устөрөгчийн уг шалтгаан болдог шивтрийн хийн 64%-ийг ялгаруулдаг. Тиймээс мал аж үйлдвэрлэлийг гэдэг нь эндээс ялгардаг үхлийн аюулт энэ бүх хорт хий болон метаныг ч зогсооно гэсэн үг.<sup>69</sup>

## ***Хар нүүрстөрөгчийн гамшигт үр нөлөө***

Хар нүүрстөрөгч (Black carbon) нь нүүрстөрөгчийн давхар ислээс 680 дахин их дулаан хураах чадалтай хүлэмжийн хий бөгөөд дэлхийн мөсөн бүрхэвч, мөсөн голууд их хурдацтай хайлахад түлхэц болж байна. Хар нүүрстөрөгчийн 40 хүртэлх хувь нь мал аж ахуйн зориулалтаар ой модыг шатааснаас үүсэж байна.

Антарктидийн хар нүүрстөрөгчийн 60% нь Өмнөд Америкт мал аж ахуйн үйлдвэрлэл явуулах газрыг чөлөөлөхийн тулд дэгдээсэн ойн түймрээс салхинд туугдан ирсэн болохыг эрдэмтэд илрүүлсэн байна.<sup>70</sup>

## ***Дэлхийг маш түргэн сэрүүцүүлэхийн тулд махны үйлдвэрлэлийг зогсооё***

**Ирэх арав, хорин жилийн дотор гараг дэлхийгээ хөргөж, хэвийн байдалд оруулахын тулд эхлээд метан хийн ялгаралтыг багасгах нь хамгийн үр нөлөөтэй. Метан хийн хамгийн том үүсгэгч нь мал аж ахуй учраас веган болох нь метаны ялгаралтыг багасгаж, улмаар гараг дэлхийгээ сэрүүцүүлэх хамгийн түргэн бөгөөд амжилттай арга зам юм.**

Метан хий нь агаар мандалд урвалд орж,  $\text{CO}_2$ -оос хэд дахин хурдан задардаг бөгөөд арван жилийн хугацаанд бараг бүрэн алга болно, гэтэл  $\text{CO}_2$  хэдэн мянган жилээр агаарт саатдаг талаар АНУ-ын судлаач, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний хорооны гишүүн Др.Кирк Смит танилцуулсан. Тийм учраас, бид дэлхийг хурдан сэрүүцүүлэхийн тулд агаар мандал дахь түргэн задардаг хийнүүдийг хуримтлуулалгүй алга болгох хэрэгтэй байна.<sup>71</sup>

**Өөрөөр хэлбэл, метан хий нь богино хугацаанд хавьгүй илүү хор уршиг тарьдаг учир метан хийг таслан зогсоовол дэлхийн дулаарлын чиг хандлагыг маш түргэн эргүүлэх боломжтой болно.**

**Мах идэх, амьтан алах, мал үржүүлэхээ зогсоох нь хамгийн шилдэг арга зам мөн.** Тэгвэл метан хий, азотын исэл агаар мандалд хуримтлахаа болино! Үүний үр дүнд бид агаар мандлаас бохирдлын ихэнх хэсгийг арилган, дэлхийн дулаарлын явцыг зогсооно. Би өмнө нь хэлсэн шүү дээ, дээрх арга замаар дэлхийн дулаарлыг даруй 80 хувиар багасгаж, ердөө хэдхэн долоо хоногт үр дүнг нь харах болно.

## ДАЛАЙГ ХАМГААЛЪЯ

### *Үхмэл бүс үүсэхийг зогсооё*

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг зогсоосноор бусад томоохон үр ашиг гарна. Жишээлбэл: далайн үхмэл бүс нь голчлон малын тэжээл тарьж ургуулахад хэрэглэдэг химийн бордоо далай уруу урсан орсноос шалтгаалан үүсдэг.

Үхмэл бүсүүд нь далайн экосистемд ноцтой аюул учруулж байна. Гэхдээ хүмүүс мал аж ахуйтай холбоотой үйл ажиллагаагаар далайг бохирдуулахаа зогсоовол үхмэл бүсүүд нөхөн сэргэх боломжтой.

Мексикийн хойгт байрлалтай, Нью Жерси шиг хэмжээтэй, тэр хавийн далайн амьтан ургамлыг боомилж байдаг үхмэл бүс нь АНУ-ын баруун хойд мужийн төв хэсэгт малын тэжээл тариалахад хэрэглэдэг бордоо, малын ялгадаснаас бий болсон азотын хаягдал далайд орсноос шалтгаалан үүссэн. Энэ нь маш их хортой хаягдал бөгөөд антибиотик, даавар, шавж устгагч пестицид болон хүний ялгадастай харьцуулбал 10-аас 100 дахин их концентрацтай E коли, салмонелл зэрэг үхлийн аюултай нян агуулдаг.<sup>72</sup>

1995 онд Хойд Каролинад гахайн ялгадас хуримтлуулах зориулалттай 3.2 га (8 акр) том усан сан задарч 110 сая литр (25 сая галлон) хорт ялгадас усанд асгарсан бөгөөд энэ нь өмнө шуугиан дэгдээсэн Экксон Валдез нөөцлүүрээс асгарсан газрын тосны хэмжээнээс [260000-750000 баррел буюу 41000-аас 119000 м<sup>3</sup> түүхий газрын тос] 2 дахин их байсан. Хаягдал дахь азотоос болж мужийн Нью Ривер мөрний загас хэдэн зуун саяараа тэр дороо үхэж, бохирдол цааш урсан далайд цутгаж маш их хор хохирол дагуулсан.<sup>73</sup>

“Далай дахь хүчилтөрөгч шавхагдсан үхмэл бүсийн тоо 1960-аад онд 49 байсан бол 2008 онд 405 болж нэмэгдсэн байна.”<sup>74</sup>

— Роберт Ж. Диаз, Рутжер Росенбэрг, Тэнгисийн нэрт экологчид

### *Загас агнуурыг зогсоож, далайн амьдралыг сэргээе*

Далай, тэнгис дэх экологийн тэнцвэрийг хангахад загас чухал үүрэгтэй; эс бөгөөс бидний амьдрал ч аюулд орно.

Загас агнуур нь дэлхийн далай тэнгисийн нарийн бүтэцтэй экосистемийн тэнцвэрийг алдагдуулан дэлхийн дулааралд нөлөөлж байна. Дэлхийн гадаргын гуравны хоёроос илүү хэсгийг далай тэнгис



ээздэг учраас далайн экосистем тэнцвэртэй орших нь туйлын чухал үүрэгтэй.

Далай бол амьд оршихуй бүр нь өөрийн гэсэн өвөрмөц үүрэг гүйцэтгэдэг маш нарийн тогтолцоотой эко орчин билээ. Тиймээс хүмүүс хүнсэндээ зориулж тэндээс ганц жижиг загас барих нь хүртэл далайд тэнцвэрт бус байдал үүсгэж байдаг. Чухамдаа, тэнцвэр алдагдаж байгааг далайн хөхтөн амьтдын амьдралд гарч буй сөрөг үр дагавар хэдийнээ харуулж байна.

Загас агнуурыг зогсоовол далайн амьдрал дахин сэргэх болно. Загас агнуурын эрчимжсэн аж ахуй эрхлэх болсны уршгаар Намибийн эргээр нутагладаг мөрөг загас устаж, хорт хийнүүд ялгаран үхмэл бүс үүсжээ. Хэнд ч үл анзаарагдам хэрнээ байгаль экологид амин чухал үүрэг гүйцэтгэдэг энэхүү ганцхан төрөл зүйл устахад л энэ бүс нутгийн эко систем бүхэлдээ сүйрч байна шүү дээ.<sup>75</sup>

Хэт их агнаснаас болж загасны биеийн хэмжээ улам жижгэрч байна. Улмаар загас барих торны хэрээс нь жижгэрч, үүнд нь бусад загас ч өргөн баригдах болжээ. Ийнхүү далайн экосистемийг улам илүү сүйтгэж, олон төрлийн загасыг хөнөөж байна. Барьсан зарим загасыг амьтны хоол гэжээл, бордооны зориулалтаар хэрэглэж, эсвэл үхсэн нэгийг нь далайд буцаан хаяж байна. Жишээлбэл: нэг тонн сам хорхой барихад өөр төрлийн 3 тонн загас хамт баригдан үхэж, буцаад далайд хаягддаг байна.

Гахай, тахианд хүчээр идүүлдэг далайн гаралтай хүнс нь Япон улсын хүн амын энэ төрлийн хүнсний хэрэглээнээс 2 дахин, АНУ-ын хүн амын хэрэглээнээс 6 дахин их байгааг АНУ-д хийсэн судалгаа илрүүлжээ. Өнөөдөр дэлхийн хэмжээнд барьсан загасны наанадаж гуравны нэгийг хүмүүс биднийг бус харин мал амьтныг тэжээхэд зориулж байна.

“Бидний хүлээн авсан төрөл бүрийн баримжаа тооцоонууд үнэн бодит байдалд нийцвээс бид 40 жилийн дараа гэхэд загасгүй болох нөхцөл байдалд байна гэсэн үг.”<sup>76</sup>

— *Паван Сүхдэв, НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн Ногоон Эдийн засгийн Санаачилгын тэргүүн*

Далайн усны хүчиллэгжилт нэртэй өөр нэг нөхцөл байдал үүсэж байна. Зарим төрлийн загас устаж үгүй болсны улмаас далайн усны хүчиллэг нэмэгдэж, CO<sub>2</sub>-ийг шингээх боломж багасдаг байна.

Загасны аж ахуй нь газар дээрх фермийн үйлдвэртэй адилхан. Тэдгээрээс үүсэх байгаль орчны асуудал, үр дагаврууд нь ижил төстэй бөгөөд үүнд усны эх үүсвэр, голын сав газрын бохирдол ч хамаарна. Загасны аж ахуй загасыг далайн эргээс зайдуу тор татсан том талбайд хашдаг бөгөөд усанд нь шингэсэн хоолны шавхруу, загасны ялгадас,

антибиотик, бусад төрлийн эм, химийн бодисууд нь ойр хавийн устай газар уруу урсан орж, улмаар бидний хүрээлэн буй орчин, экосистемд хор хөнөөл учруулж, ундны усны эх үүсвэрийг бохирдуулж байна.

Тиймээс, загас идлээ гээд байгаль орчныг тэгтлээ гэмтээхгүй гэсэн бодолтой хүмүүс үүнийгээ дахин тунгаан бодож үзнэ үү. Амьтны гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ аль ч талаараа далай тэнгис, газар дэлхийд сөрөг нөлөөтэй.

## УСНЫ ХОМСДОЛЫГ ЭЦЭСЛЭЕ

### *Мал аж ахуй: Усыг хамгийн их хэмжээгээр хэрэглэдэг салбар*

“Хөдөө аж ахуй, мал үржүүлэгт цэвэр усны хэрэглээний 70%-ийг зарцуулж, ой модны 80%-ийг устгаж байгааг тооцон хөдөө аж ахуйн үйл ажиллагаа болон усны нөөцийнхөө зохицуулалтыг бид эргэн харах цаг иржээ.”

—*Бан Ги-Мүн*

Ус бол бидний оршнолын үндэс. Бид усыг хэмнэн хамгаалах ёстой, үүний төлөө бид чадах бүхнээ хийх ёстой. Үүнийг эхлэх хамгийн эхний алхам бол веган болох явдал, учир нь мал аж ахуйн салбарт дэлхийн цэнгэг усны 70 гаруй хувийг зарцуулж байна.

Эдүгээ 1.1 тэрбум хүнд ундны цэвэр ус хүрэлцэхгүй байхад жилд 3.8 их наяд тонн үнэт цэвэр усыг мал аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулж байна.

6 тэрбум гаруй хүнтэй манай дэлхийн хүн амын талыг нь тэтгэдэг гүний усны худгийн эх сурвалжууд хагаж, ширгэж байна. Мөн дэлхийн хамгийн том 10 гол мөрний систем хагаж, татарч байна. Гурван тэрбум хүн усны хомсдолд байна.

#### **Бидэнд ус дутагдаж байна уу?**

Нэг таваг ҮХРИЙН махтай хоол хийхэд 4542.5 л (1200 галлон) гаруй ус зарцуулдаг

Нэг таваг ТАХИАНЫ махтай хоол хийхэд 1249.2 л (330 галлон) ус зарцуулдаг

ДҮҮФҮҮ, БУДАА, ХҮНСНИЙ НОГОО бүхий бүрэн ВЕГАН, нэг таваг хоолонд ердөө 371 л (98 галлон) ус зарцуулдаг.<sup>77</sup>

Бид бүр шүршүүрт орохгүй, шүдээ угаахгүйгээр хэмнэх усны хэмжээ нь мах идэхдээ зарцуулдаг усны хэмжээний дэргэд юу ч биш.

Америкчууд усны хомсдолд хэдийнээ санаагаа чилээж байна. АНУ-ын мөсөн голууд их хэмжээгээр хайлж байна. Гол мөрөн улам татарч ердөө хэдхэн жилийн дараа 23 сая хүнд амьдралыг нь тэтгэгч ундны ус хүрэлцэхгүй болж болзошгүй.<sup>78</sup>

### **Органик веган хүнс: Дэлхийн усны 90 гаруй хувийг хэмнэнэ**



Эх сурвалж: Марсиа Крэйт, Калифорнийн Хүнсний үйлдвэрлэлийн Усны зарцуулалт, Усны Боловсролын Сан, 9 дүгээр сар, 1991 (зураг E3 хуудас 28)

Махны үйлдвэрлэлд асар их хэмжээний ус зарцуулж байна. Ердөө л ганц таваг үхрийн махтай хоол бэлтгэхэд 4542.5 л (1200 галлон) цэнгэг, цэвэр ус зарцуулдаг.<sup>79</sup> Үүний эсрэгээр, нэг таваг бүрэн веган хоол бэлтгэхэд ердөө 371 л (98 галлон) ус зарцуулдаг. Энэ нь 90 гаруй хувиар бага гэсэн үг.

Бид усны хомсдолыг зогсоох боломжтой. Ган гачгаас болж зарим хүн туйлдаж байхад бид усыг үргүй зарцуулах эрхгүй. Хэрэв усны хомсдолыг эцэслэж, чандмань эрдэнэ усаа хамгаалж үлдээхийг хүсвэл бид малын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээгээ зогсоох хэрэгтэй.

## **ГАЗАР НУТГАА ХАМГААЛЪЯ**

### **Хөрсний талхлалт, цөлжилтийг зогсооё**

Мал аж ахуйн салбар нь хүмүүсийн газар нутгийн хэрэглээний хамгийн том нь бөгөөд ширэнгэн ой устаж буйн гол шалтгаан юм.

Бид хөрсөө, амьдралаа хамгаалахын тулд газрыг малын бэлчээрт хэрэглэхээ зогсоох хэрэгтэй. Бэлчээрийн даац хэтэрсэн нь цөлжилт болон бусад хор уршгийг дагуулж, хөрсний элэгдлийн 50 гаруй хувийг үүсгэсэн байна.

Дэлхийн гадаргын ердөө 30%-ийг хуурай газар эзэлдэг. Энэхүү 30%-ийн үнэт баялгийнхаа гуравны нэгийг зөв аж төрөхөд бус, харин малын бэлчээрт, эсвэл малын тэжээлийг тонн тонноор тариалахад, энэ бүгдийг ердөө хэдхэн үмх мах бэлдэхийн төлөө хэрэглэж байна.

Жишээлбэл: АНУ-ын хөдөө аж ахуйн газрын 80 хувь буюу 0.4 тэрбум орчим га (1 тэрбум орчим акр) газар, АНУ-ын хуурай газрын бараг тэн хагасыг махны үйлдвэрлэлд хэрэглэж байна. Үүний эсрэгээр, хүнсний ногооны тариалалтад улсын хэмжээнд 1.2 сая га (3 сая акр) хүрэхгүй газар хэрэглэж байна.<sup>80</sup>

Сүүлийн үеийн судалгаагаар Мексик улсад мал аж ахуйн салбараас болж, газар нутгийнх нь 47% нь цөлжсөн байна.<sup>81</sup> Мөн мужийн 50-70% орчим нутаг нь ган гачигт тодорхой хэмжээгээр нэрвэгджээ.

Мал аж ахуйн зориулалтаар ой модыг огтолсноос Мексик улс даяар хөрс тогтворгүй болж доройтон ноцтой хэмжээнд хүрээд байна. Мексикийн хойд бүсийн газар нутгийн бараг гуравны хоёр нь хөрсний элэгдэлд бүрэн орсон буюу хөрсний элэгдэл нь түргэссэн гэсэн ангилалд багтаж байна.<sup>82</sup> Мал олноороо бүх ургамлыг идэж, хөрсийг талхлахад юу ч ургах боломжгүй цемент шиг нягтаршсан хөрс үлдэнэ. Хатаж үхэж буй ургамал, нүцгэн хөрснөөс нүүрстөрөгчийн хий илүү их ялгардаг учраас дэлхийн дулааралд улам ихээр нөлөөлнө.

## ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨНГ ТЭГЛЭЭ

Хэрэв хүн бүр ургамалд суурилсан хүнс хэрэглэвэл 10 тэрбум хүнийг тэжээх хангалттай хүнсний нөөцтэй байх болно.

### *Мал үржүүлэгт зориулж газрыг сүйтгэж байна*

**Бид хүнсний хомсдолд орсон уу?**

Дэлхий дээр хэдэн хүн өлсгөлөн байна вэ?

1.02 тэрбум хүн.

5 секунд тутамд 1 хүүхэд өлсгөлөнгөөр эндэж байна.

Эдүгээ малын тэжээлд зориулж буй үр тариагаар бараг 2 тэрбум хүнийг тэжээх боломжтой.<sup>83</sup>


— Жулиэ Желлатлэй, Тони Хардл

АНУ-д тариалсан бүх шар буурцгийн 90%, эрдэнэ шишийн 80%, үр тарианы 70%-ийг малыг таргалуулахад хэрэглэж байна, гэтэл үүгээр ядаж л 800 сая өлсгөлөн хүнийг хооллох боломжтой.<sup>84</sup> Бид хэтэрхий их ус, хэтэрхий их газар, хэтэрхий их хоол хүнсийг хүнийг биш, харин малыг тэжээхэд зориулж байгаа учраас хүмүүс өлсгөлөнд нэрвэгдэж; хэдэн секунд тутамд хүүхдүүд хоолны хомсдолоос эндэж байна.

Хэрэв бид мах иддэггүй болбол газар тариалангийн үйлдвэрлэлийн үр тариагаа малыг үржүүлэхэд бус хүмүүсийг тэжээхэд хэрэглэдэг болно. Тэгснээр өлсгөлөн арилж, өлсгөлөнгөөс болж дайн дэгдэхээ болино. Гарах үр нөлөө нь хэмжээлшгүй их юм шүү.

## Газрын үр ашигтай хэрэглээ

0.4 га газар тутам дахь төрөл бүрийн хүнсний ашигт уураг, кг-аар



Эх сурвалж: АНУ-ын Хөдөө аж ахуйн яам; НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага/, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага/, НҮБ-ын Хүүхдийн сангийн Уургийн Зөвлөх баг (USDA; FAO/WHO/UNICEF Protein Advisory Group), 2004

“0.45 кг (1 фунт) мах үйлдвэрлэхэд 2.7-оос 5.4 кг (6-аас 12 фунт) ургамлын уураг зарцуулдаг.

Мах үйлдвэрлэхэд төмс, үр тариа үйлдвэрлэхээс 1000 дахин их ус хэрэглэдэг.

Нэг махан идэштнийг тэжээхэд 2 га газар шаардагддаг.

20 веган хоолтонг тэтгэхэд 1.2 га газар шаардагддаг.

**Тиймээс махан хоолтны амьдралын хэв маягийг тэтгэхийн тулд веган хүнийхээс үндсэндээ 80 дахин их газар хэрэглэдэг байна.**<sup>85</sup>

— Гэри Л.Франсион, Эрх зүйн Профессор, Рутжэрс Их сургуулийн Хуулийн сургууль, АНУ, Веган

Нэмж хэлэхэд, бид органик, байгалийн, органик газар тариаланг түлхүү хэрэглэхийн хэрээр хоол хүнс элбэг, бид өөрсдөө улам эрүүл, хөрс шороо маань ч эрүүл болно. Тэгснээр хөрс нөхөн сэргэж, бид улам элбэг дэлбэг хүнстэй байх болно.

## ОЙ МОД ОГТЛОХЫГ ЗОГСООЁ

Бид ой мод огтлох үйл ажиллагаанд хориг тавьж, мэдээж улам их мод тарих хэрэгтэй. Хаана л элэгдсэн, хоосон газар байна тэнд бид мод тарих хэрэгтэй.

**Ой модыг дийлэнхдээ махны үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор устгаж байна. Хүлэмжийн хийн ялгарлын 20 орчим хувь нь ой мод огтолсноос үүсдэг, ойн хомсдол бараг бүхэлдээ махны үйлдвэрлэлээс улбаатай гэж НҮБ тооцоолжээ.**<sup>86</sup> Амазоны ширэнгэн ой дахь ургаа модгүй болж нүцгэрсэн талбайн 80 хувийг нядалгаанд зориулагдсан мал бэлчээхэд, үлдсэн хувийг бас л голчлон малын тэжээлийн буурцаг тариалахад хэрэглэж байна.

Жил бүр бид мал өсгөж үржүүлэхэд зориулж Англи улсын газар нутгийн дайтай ойг огтолж байна. Тийм учраас л гараг дэлхий маань дулаарч, олон газарт үер ус, ган гачгийн аюул тулгарсаар байна.

**Ердөө 250 гамбургер үйлдвэрлэхийн төлөө секунд бүрд нэг хөл бөмбөгийн талбайн хэмжээтэй тэнцэхүйц ширэнгэн ойг огтолж байна.**<sup>87</sup>

**Нэг зүсэм үхрийн махан гамбургер үйлдвэрлэхэд 55 хавтгай дөрвөлжин метр ширэнгэн ойг устгаж байна.**<sup>88</sup>

Ой хөвч нь  $\text{CO}_2$ -ийг шингээхэд хэмжээлшгүй их үүрэг гүйцэтгэдэг. Жишээлбэл: АНУ-ын Баруун хойд нутгийн ой нь Орегон мужийн бүх хүлэмжийн хийн тэн хагасыг өөртөө шингээх чадалтай.

Хүрээлэн буй орчны Грийнпийс байгууллагын мэдээлснээр Дэлхийн ой модтой холбоотой нүүрстөрөгчийн 8 хувийг Төв Африкийн Конго голын сав газрын асар том ширэнгэн ой хадгалдаг байна. Хэрвээ Конго голын сав газрын ойг үргэлжлүүлэн огтолсоор байвал өнгөрсөн 60 жилд Их Британи улсын ялгаруулсан  $\text{CO}_2$ -той тэнцэх хэмжээний нүүрстөрөгч тэндээс гарна гэсэн таамаглалыг эрдэмтэд дэвшүүлсэн байна!<sup>89</sup> Тэгэхээр, боломж байгаа дээр нь бид ой модоо хамгаалан авч үлдэх нь чухал болоод байна.

Мод нь борооны усыг шингээн авч, хөрсийг бэхжүүлж, хөрсний эвдрэлийг зогсоодог. Бас сүүдэр, хүчилтөрөгчөөр хангаж, ойн амьтдын орон гэр болж, улмаар гараг дэлхийн экологийн тэнцвэрт байдлыг нөхцөлдүүлж байдаг.

[Ой модыг устгах] нь ой модыг зохицуулж байдаг дэлхийн агаарын хэм, хур бороо, цаг уурын төлөв байдалд гарах эргэлт буцалтгүй өөрчлөлтийн талаарх асуудал биш юм. Ойгоос амь амьдралаа залгуулж

байдаг хэдэн сая хүний амьжиргаа алдагдахаар хязгаарлагдах асуудал ч биш. Үүнээс ч илүү зүйл бий. Ойн амьтан, ургамлын төрөл зүйл байгалийн жамаасаа 100 дахин түргэн устан үгүй болж, энэ нь дэлхийн экосистемийг бүхэлд нь сүйрүүлнэ.

Аз болоход бидэнд гарах гарц бэлэн байна, энэ бол органик веган шийдэл юм. Органик веган шийдэл бол дэлхийг яг энэ мөчид аврах цор ганц арга зам учраас бид үүнийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Тэгвээс малын бэлчээр, тэжээл тариалахад хэрэглэж буй газрыг дэлхийн дулаарлыг сааруулахад нөлөөлөх ойн мод болгох боломжтой. Түүнчлэн хагалж боловсруулах боломжтой бүх газрыг органик хүнсний ногооны тариаланд зориулбал, бүх хүнийг тэжээгээд зогсохгүй агаар мандал дахь хүлэмжийн хийн 40 хүртэлх хувийг өөртөө шингээнэ. Энэ нь мал үржүүлгийн ажиллагаанаас үүссэн хийн ялгарлын 50 гаруй хувийг бууруулснаас гадуурх нэмэлт үр дүн юм.<sup>90</sup>

Тийм учраас, ердөө л амьтны бус гаралтай, веган, органик аж төрөхүйн хэв маягийг сонгосноор хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн дийлэнхийг арилгах болно хэмээн дүгнэж байна.





## **ЭРЧИМ ХҮЧИЙГ ХЭМНЭЭ**

### *Махны үйлдвэрлэлийн эрчим хүчний өртөг*

Махны үйлдвэрлэл нь эрчим хүчний зарцуулалт өндөртэй төдийгүй эрчим хүчийг маш үр ашиггүй зарцуулдаг. Нэг килограмм үхрийн мах үйлдвэрлэхэд 169 мегажоул (169-сая ватт) буюу Европын дундаж машинаар 250 километр давхихад хүрэлцэх хэмжээний эрчим хүч зарцуулдаг!

**170 г (6 унц) нэг ширхэг үхрийн махан стэйк хийхэд будаа, гурван төрлийн хүнсний ногооны орцтой нэг веган хоолноос 16 дахин их шатах ашигт малтмалын эрчим хүч зарцуулж байх жишээтэй.**

## Махны үйлдвэрлэлийн эрчим хүчний зарцуулалт

ХООЛНЫ ТӨРӨЛ	Таваг хоол үйлдвэрлэхэд шаардагдах малтмал түлшний эрчим хүч	
	=	
1 аяга брокколи, 1 аяга хаш, 113.4 г (4 унц) цэцэгт байцаа, 226.8 г (8 унц) будаа	0.04 л (0.0098 галлон) шатахуун	
	=	
170.1 г (6 унц) үхрийн мах	0.6 л (0.1587 галлон) шатахуун, 16 дахин их	
		0.18 кг (0.4 фунт) CO <sub>2</sub> -той тэнцүү
		4.5 кг (10 фунт) CO <sub>2</sub> -той тэнцүү, 25 дахин их

Эх сурвалж: Гидон Эшел, Памела Э.Мартин, “Хоол хүнс, Эрчим хүч, Дэлхийн дулаарал”, Дэлхийн харилцан нөлөөлөл, Боть 10 (2006), өгүүлэл №9

НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийг судлах Засгийн газар хоорондын комиссын тэргүүн Др.Ражендра Пачаур: “Махыг хэрэглэснээр малын тэжээлийг тариалж тээвэрлэх, махыг байнгын хөргөлттэй саванд хадгалах, зөөвөрлөх, өндөр хэмд удаан хугацаагаар чанаж болгох, их хэмжээний баглаа боодол хэрэглэх, түүнчлэн энэ бүхнээс гарсан мал, амьтны их хэмжээний хаягдал бүтээгдэхүүнийг боловсруулах, зайлуулах шаардлагатай болдог.”-ийг онцолсон. Махны үйлдвэрлэл маш өндөр өртөгтэй, үр ашиггүй, байгальд тогтворгүй байдал үүсгэдэг тул мах үйлдвэрлэх бизнес нь муу юм.<sup>91</sup>

### ***Махны жинхэнэ өртөг***

0.45 кг (1 фунт) мах үйлдвэрлэхэд 9463.5 л (2500 галлон) ус, 5.4 кг (12 фунт) үр тариа, 15.9 кг (35 фунт) өнгөн хөрс болон 3.8 л (1 галлон) шатахуунаас гарах хэмжээний эрчим хүч шаардагддаг. Хэрвээ ямар ч татаасгүйгээр, эдгээр бүх зардлыг бүтээгдэхүүний өртөгт оруулж тооцвол АНУ-д хамгийн хямд гамбургер 35 америк долларын үнэтэй байх болно.<sup>92</sup>


— *Жонн Роббинс*



# БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ НӨХӨН СЭРГЭЭ

Энэ гараг дээр биднийг оролцуулаад бүх юмс өөр хоорондоо харилцан шүтэлцээтэй оршдог бөгөөд бид энд амьдралаа нийцтэй, ая тухтай болгохын төлөө бие биедээ тусалдаг байх ёстой. Харин бид үүнийг мэдэхгүйн улмаас өөрсдийгөө хөнөөж байна. Мод, эсвэл амьтныг хөнөөх бүртээ бид өөрсдийнхөө нэгэн жижиг хэсгийг хөнөөж байдаг.

## Ангилал зүйн бүлгийн бүрэн үнэлгээн дэх төрөл зүйлд учирч буй аюул занал



Эх сурвалж: Биологийн олон янз байдлын конвенцийн тамгын газар, Дэлхийн биологийн олон янз байдлын төлөв байдал 3, 2010, <http://www.cbd.int/gbo/gbo3/images/GBO3-Figure4-ThreatStatusAssessedGroups.pdf>

Тор тавих, тэслэж дэлбэлэх зэрэг аргаар загасчилснаас болж далай болон цэвэр усны сав газруудад аль хэдийн олон төрлийн загас, үүний хамтаар бүхэл бүтэн усан орчин, тухайлбал, шүрэн хад устаж байна. Эх газар дээр махны хэрэглээнээс болж их хэмжээний талбайг чөлөөлж малын тэжээл тариалж байна.

Эдгээр үйл ажиллагааны улмаас чухамдаа биологийн олон төрөл зүйл устаж байгаагаас амьтан, ургамал цочирдом хурдтай үгүй болж байна.<sup>93</sup>

## **ГОЛ МӨРӨН, ХӨРС ШОРООГ БОХИРДЛООС АВАРЪЯ**

Хэрэв бид өөрсдийн болон үр хүүхдүүдийнхээ төлөө аюулгүй цэнгэг усаа авч үлдэхийг үнэхээр хүсэж байвал мал аж ахуйн үйлдвэрлэлийг зогсоож, ургамалд суурилсан хүнсэнд шилжих ёстой.

АНУ-ын Хүрээлэн буй орчныг хамгаалах газрын тооцоолсноор тус улсын усны бохирдлын бараг дөрөвний гурав нь хөдөө аж ахуйн салбарын махны үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй ажээ.<sup>94</sup> 500000 гахайтай энгийн нэг гахайн фермээс нэг жилд гарах хаягдал нь Нью Йорк хотын Манхэттений 1.5 сая оршин суугчийн гаргадаг хаягдлаас их байдаг. Вержиниа мужийн шувууны аж ахуйнууд хүртэл нутгийн бүх оршин суугчийн гаргадгаас 1.5 дахин их азотын хаягдал үүсгэдэг. Гэтэл үүнийг зохицуулдаг хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Ирландад 1.8 сая гахайн үүсгэдэг хаягдал нь тус улсын нийт хүн ам буюу 4.2 сая хүний бохир хаягдлаас давж гардаг!

Ийнхүү их хэмжээний хаягдлыг хуурай газар шингээж дийлэхгүй учраас илүүдэл нь гол мөрөн, хөрсөнд шингэдэг байна. Бид цочирдмоор их хэмжээний хорт бодисын талаар ярьж байна, эдгээр нь хүхэрт устөрөгч, шивтрийн хий гэх мэт хорт хий, пестицидийн үлдэгдэл, даавар, антибиотик, мөн хоолны хордлого, үхэлд ч хүргэж чадах E коли мэт бактери зэрэг аймшигт үр дагаврыг бий болгодог.

Хог хаягдлаас гадна малын тэжээл тариалахад хэрэглэдэг химийн бордооны урсац нь үхмэл бүс үүсэхэд, түүнчлэн усанд ургадаг ногоон хагд өвс нь хорт замаг болж тархахад нөлөөлдөг болохыг эрдэмтэд баримтаар олж тогтоосон байна.

Францын мал сүргийн дийлэнх хэсэг, сүүний аж ахуйн гуравны нэг нь оршдог Бриттани мужид малын ялгадас, химийн бодисын хаягдал нь тэнгисийн усанд урсан орсны улмаас үхэлд хүргэдэг хүхэрт устөрөгчийн хий ялгаруулдаг хорт замаг ургаж дэлгэрсэн байна. Ийм учраас л сүүлийн үеийн хэвлэл мэдээллээр хорт замаг дээр гишгэсэн морь хагас

минутын дотор үхсэн, мөнхүү шалтгаанаар тухайн орчны 300 гаруй хүний эрүүл мэндийн байдлыг хяналтад авсан тухай мэдээлсэн билээ.

Мал аж ахуйн ялгадас хаягдал ихэнхдээ хяналт зохицуулалтгүй байдаг нь энэ бүхнийг улам дордуулдаг. Өөрөөр хэлбэл, хүн, малыг олноор нь өвчлүүлж, тэр бүү хэл эндэхэд хүргэж болзошгүй хэмжээнд бохирдуулах үйл явцыг зогсоох ямар ч арга хэмжээ байхгүй байгаа явдал юм.

(Малын хаягдал ялгадаснаас үүсдэг бохирдлын талаарх нэмэлт жишээг хавсралт 9-өөс үзнэ үү.)

## **САНХҮҮ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫГ БУУРУУЛЬЯ**

### ***Уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох зардлыг хэдэн их наядаар хэмнэе***

Төр засгийн удирдагчид уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зардалд их санаа зовнидог. Хэрвээ дэлхийн хүн ам амьтны гаралтай бус хүнсэнд шилжвэл уг зардлыг тэн хагас буюу түүнээс ч илүү хэмжээгээр бууруулах боломжтой гэсэн сайн мэдээ байна. Энэ бол бид хэдэн арван их наяд ам.доллар хэмнэнэ гэсэн үг.

- **Уур амьсгалын өөрчлөлтийн өртөг**

“Европын Комиссын судалгаагаар уур амьсгалын өөрчлөлтийн өртөг зардал 74 их наяд америк долларт хүрч магадгүй гэж тооцоолсон. Далайн усны түвшин 1 метрээр нэмэгдэхэд далайн давалгаанд өртөх эд хөрөнгийн хохирол 1.5 их наяд америк доллараар нэмэгдэнэ.”<sup>95</sup>

— *Хүрээлэн буй орчны судлаач Ф. Акерман, Э.Стэнтон*

“Ямар ч арга хэмжээ аваагүй тохиолдолд 2100 гэхэд Японд улсаас гарах зардал нь жилдээ 176 тэрбум америк доллар болно.”<sup>96</sup>

— *Проф. Нобуо Мимура ба хамтран зүтгэгчид*

- **Веган хүнснээс үүсэх хэмнэлт**

Дэлхий нийтээрээ веган хүнсэнд шилжвэл 2050 он гэхэд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад зарцуулахаар тооцоолсон 40 их наяд америк долларын хөрөнгийн 80% (32 их наяд америк доллар)-ийг хэмнэх болно.<sup>97</sup>

— *Элке Стехфэст, Нидерландын Хүрээлэн буй орчны үнэлгээний нийгэмлэг*

## *Эрүүл мэндийн зардлыг багасгая*

Эдүгээ мах идсэнээс эрүүл мэндэд учирдаг эрсдэлүүд улам тод томруун харагдах боллоо. Малд байнга хэтэрсэн хэмжээгээр хийдэг антибиотик, даавар нь махаар дамжин эргээд хүний эрүүл мэндэд аюул учруулж байна.

Түүнчлэн нядалгааны газруудад шивтэр, хүхэрт устөрөгч зэрэг хорт бодисууд ялгарч байдаг. Эдгээр хэт хортой бодис ажилчдыг хордуулан нас барахад хүргэдэг байна.

Бидний хоол гэж нэрлээд байгаа мах нь хүний ходоодондоо хийдэг хамгийн эрүүл бус, хортой, эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй бүтээгдэхүүн. Бид эрүүл мэндээ, амь насаа эрхэмлэн хайрладаг л юм бол махыг огт идэх ёсгүй. Бид махгүйгээр илүү урт насалж, эрүүл энх, ухаан саруул амьдарч чадна.

Шинжлэх ухааны судалгаагаар мах бол бүх төрлийн хавдар, зүрхний өвчин, цусны даралт ихсэх, цус харвах, таргалах зэрэг өвчний шалтгаан болдог нь нотлогдсон. Энэ жагсаалт дахь өвчний тоо нэмэгдсээр л байна. Эдгээр бүх өвчин жилд хэдэн сая хүнийг хөнөөж, махнаас үүдэлтэй өвчнөөр хэдэн сая хүн нас барж, өөр хэдэн сая хүнийг хүнд өвчтэй, тахир дутуу болгож байна. Махан хүнснээс үүсдэг аюул эмгэнэлд эцэс төгсгөл гэж үгүй. Шинжлэх ухаан болон анагаах ухааны энэ бүх баримт нотолгоо байхад өдийд бид үүнийг мэддэг болсон байх ёстой шүү дээ.

Малыг нядалгаанд орох хүртэл хашдаг бохир заваан, гахайн ханиадны вирус зэрэг өвчнийг тархах нөхцөл бүрдүүлдэг давчуу орчны талаар бид энд дурдаа ч үгүй байна. Үнэн хэрэгтээ, үхрийн галзуу өвчин гэх мэт махаар дамждаг зарим өвчний хүнд туссан хэлбэр нь тохиолдол бүрт ямагт үхлийн аюултай байдаг. Үхрийн галзуу өвчин туссан хэн ч бай харамсалтайгаар үхэх тавилантай байдаг. Е коли, салмонелла гэх мэт бусад нян ч мөн л эрүүл мэндэд ноцтой аюул учруулж, урт хугацаагаар хүний эд эрхтнийг гэмтээж, зарим тохиолдолд бүр үхэлд ч хүргэдэг байна.

Веган ертөнцөд, ихэвчлэн фермийн амьтдаас гаралтай үхлийн аюултай бактери болох Е коли нянгаас болж хэн нэгний хүүхэд тархины гэмтэл, саа өвчнөөр нас барсан тухай харамсалтай мэдээ байхгүй болно. Гахайн ханиадны тахал, үхрийн галзуу өвчин, хавдар, чихрийн шижин, цус харвалт, салмонелла, Эбола гэх мэт нянгаас болж сэтгэл түгших зүйлгүй болно. Биднийг маш их айлгадаг хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ) хүртэл анх хүнсэнд хэрэглэх гэж ан агнаснаас улбаалж үүссэн байдаг. Мал аж ахуйн бохир заваан, ой гутам орчин нөхцөлөөс үүссэн өвчнүүд хүмүүсийн дунд тарж буй нийт халдварт өвчний 75%-ийг эзэлж байна.

Бидний биед сайн гэж албан ёсоор хэлдэг сүү хүртэл хортой бөгөөд өвчин үүсэх (мэдээж бас санхүүгийн алдагдал) шалтгаан болдог.

Заримаас нь дурдъя л даа: малын гэдэсний нугалаанд орших бохир нян, шавжийн хор (пестицид), энзим нь бяслагаас илэрсэн байна; хөх, түрүү булчирхайн хорт хавдар нь сүүнд байдаг гормоноос үүдэлтэй; нарийн гэдэс ба Кроны өвчин; гормон, биед шингэдэггүй өөх тос нь ясны сийрэгжилт, хэт таргалалт, чихрийн шижин, зүрхний өвчин үүсгэдэг.

- **Мах, сүүн бүтээгдэхүүнээс үүдэлтэй эрүүл мэндийн зардал**

2010 онд АНУ-д зүрх судасны өвчинд 503.2 тэрбум америк долларыг зарцуулсан байна.<sup>98</sup>  
АНУ-ын хорт хавдрын эмчилгээний зардал жилд 6.5 тэрбум америк долларт хүрдэг.

АНУ-ын чихрийн шижин өвчний эмчилгээнд жилд 174 тэрбум америк долларыг зарцуулдаг.  
АНУ-д хэт таргалалтын эмчилгээнд жилд 93 тэрбум америк долларыг зарцуулдаг.<sup>99</sup>

## **НОГООН ТЕХНОЛОГИ ХӨГЖҮҮЛЭХ ЦАГИЙГ ХОЖЬЁ**

Өнөөгийн технологийг орлуулах дэвшилтэт технологийг одоохондоо нээгээгүй байгаа учраас бид CO<sub>2</sub>-ийг тийм хурдан багасгаж чадахгүй. АНУ-ын гудамжуудаар одоогоор хэчнээн цахилгаан машин явж харагдана вэ? Тэдгээр нь CO<sub>2</sub>-ийг хэр их багасгаж чадах вэ? Тийм ч их биш. Харин метан хий нь мал үржүүлгийн үйл ажиллагаанаас үүссэн тул үүнийг л зогсоохвол дэлхийн дулаарал байхгүй болно!

CO<sub>2</sub>-ийг шингээж аваад далайн устай хольж цемент үйлдвэрлэх шинжлэх ухааны зарим дэвшилтэт арга хэдийнээ бий болжээ. Энэ нь цемент үйлдвэрлэдэг бусад төрлийн аргад хэрэглэдэг CO<sub>2</sub>-ийг ч, мөн агаарт дэгдэх CO<sub>2</sub>-ийг багасгах ажээ. Тэгсэн ч гэсэн ямарваа шинэ технологийг хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэхэд маш их хугацаа шаардана.

НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн үзэж байгаагаар нүүрстөрөгчийг шингээх технологийг бодвол байгалийн унаган төрхөөрөө байгаа тал газар, ой мод нь CO<sub>2</sub>-ийг илүү сайн шингээдэг ажээ. Ер нь шинэ технологиуд туршигдаагүй учраас эрсдэлтэй гэж бодож байна. Нүүрстөрөгч алдагдаж, өндөр нягтралтайгаар агаар мандалд эргэн орвол юу болох вэ? Бид жилээс жилд нүүрстөрөгчийг шингээж авах гэж хичээн зүтгэж байтал ямар нэгэн асуудал гарч буцаад тархвал бид юу хийх болж байна?

Тиймээс веган хоолны дэглэмд шилжсэнээр бид эрүүл мэнд, амьтад, хүрээлэн буй орчиндоо хамгийн сайн нөлөөлөх хүнс хэрэглэж, харин бусдыг нь байгаль өөрөө тэнцвэрээ сэргээх замаар зохицуулж, Дэлхийг аврах болно.<sup>100</sup>

## II. ХАМГИЙН ДӨТ, НОГООН ШИЙДЭЛ

### ДЭЛХИЙГ НЭН ДАРУЙ СЭРҮҮЦҮҮЛЬЕ


Нидерландын Амьтны төлөө Намыг үндэслэгч Марианне Тэймэ махан хүнсийг багасгах нь хүрээлэн буй орчинд ямар ашиг тустай байх тухай тодорхой тайлбарласан. Жишээлбэл: хэрвээ бүх Англи хүн 7 хоногийн бүх өдөр махнаас татгалзвал энэ нь тус улсын 25 сая айл өрхийн хагасыг хорт хий огт ялгаруулдаггүй болгосонтой дүйцэх ажээ. Долоо хоногийн 6 өдөр нь махнаас татгалзахад улсын хэмжээнд буй 29 сая автомашиныг замаас бүрмөсөн зайлуулсантай дүйцэх үр дүн өгнө гэжээ.

- **Уламжлалт махан хооллолттой харьцуулах нь**
  - Органик [маханд-суурилсан] хүнс хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг 8% багасгана.
  - Амьтны бус гаралтай веган хүнс нь махан хоолны ХХЯ-ын 1/7-ээс бага хэмжээний хийг ялгаруулна – ХХЯ-ыг 86% багасгана.
  - Органик веган хүнс нь ХХЯ-ыг 94% багасгана.<sup>101</sup>

— Германы уламжлалт, органик фермийн хүлэмжийн хийн үр нөлөөний тухай Foodwatch байгууллагын тайлан

### Органик веган хооллолтоор бууруулах хүлэмжийн хийн хэмжээ

Хүлэмжийн хийд үзүүлэх хооллолтын төрлийн нөлөө, жилд, нэг хүнд ногдох хэмжээ, машины туулах километрээр\*



\*BMW 118d машины CO<sub>2</sub>-той ялгаралтыг (119 г CO<sub>2</sub>/км) дүйцүүлж авав  
Эх сурвалж: Фүүдвотч Органик: Уур амьсгал сэргэх үү? Герман улсын органик ба уламжлалт аж ахуйн хүлэмжийн хийд үзүүлэх нөлөөллийн талаарх Фүүдвотчийн тайлан. 2009 оны 5 дугаар сар, хуудас X

[Тийм учраас,] бүхий л ногоон бодлогоос хамгийн ногоон нь, бүхий л ногоон арга хэмжээнээс хамгийн ногоон нь, хамгийн энэрэнгүй, хамгийн баатарлаг, амьдралаа аврах хамгийн зөв үйлдэл бол веган хооллолт юм.

Үүний шалтгаан нь бид органик веган хооллолтод шилжвэл агаар мандлаас метан хий сарнин алга болж дэлхийн уур амьсгал сэрүүсэхээр дорвитой үр нөлөө гарахтай холбоотой юм. Хортой метан хийн ялгаралт арилахын зэрэгцээ органик тариалалтын аргууд нь чухамдаа нүүрстөрөгчийн 40%-ийг хөрсөнд буцааж шингээн хадгална. Тийм учраас веган байх нь чухал нөлөөтэй хорт хийн ялгарлыг арилгах төдийгүй түүнээс ч их хэмжээний нүүрсхүчлийн хийг агаар мандлаас мод ургамалд шингээх арга зам билээ.

Ийм л аргаар бид дэлхийгээ аврахын төлөө ажиллаж байна. Яагаад гэвэл амьтны бус гаралтай хоол хүнсэнд шилжих нь мал амьтанд зүй хусаар хандахыг ч дурдалтгүй, метан хийн гол эх үүсвэр, тэдгээртэй холбоотой бохирдуулагчдыг үгүй болгож, цунами, үер, шуурга, хар салхи, хөрсний нуралт зэрэг дэлхийн олон гамшгийг зогсооход тусална.

Үнэндээ, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенцийн тэргүүн Ноён Яво де Боэр хэдийнээ 2008 оны 6 дугаар сард “Бид бүгдээрээ цагаан хоолтон болох нь бидний хувьд хамгийн сайн шийдэл” гэж хэлсэн байдаг. Тэрээр веган гэх утгаар хэлжээ.

## **ВЕГАН БАЙХ: БАЙГАЛЬД ХАМГИЙН ЭЭЛТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ**

[Махны үйлдвэрлэлийг зогссоноор] дэлхийн дулаарлыг зогсооход зарцуулах нийт 40 их наяд америк долларын зардлын 80%-ийг хэмнэнэ; хүнс тариалахад 4.5 дахин бага газар хэрэглэнэ; цэвэр усны 70%-ийг хамгаалж үлдэнэ; Амазоны ширэнгэн ойн 80%-ийг малын хөлд талхлагдахаас хамгаална. Дэлхийг өлсгөлөнгөөс аврах шийдэл: 3.4 тэрбум хүртэлх га газрыг чөлөөлнө; жил бүр 760 сая хүртэлх тонн буудайг хэмнэнэ (энэ бол дэлхийн хэрэгцээт үр тарианы тэн хагас). Махны үйлдвэрлэлд зарцуулдаг байсан шатах ашигт малтмалын нөөцийн 1/3-ийг хэмнэнэ; малын ялгас хаягдлын бохирдол багасна; агаарыг илүү цэвэр байлгана; жил тутам АНУ-ын нэг өрхөд ногдох хорт хийн ялгарлыг 4.5 тонноор багасгана; дэлхийн дулаарлын 80% буюу түүнээс ч илүү хувийг зогсооно. Энэ мэтчилэнгээр жагсаалтыг үргэлжлүүлж болно.

Органик газар тариалан нь өнгөн хөрсийг элэгдэлд оруулахгүй, усны ай сав газруудыг цэвэр байлгах бөгөөд хэрвээ дэлхий даяар нэвтрүүлбэл өдгөө ялгараад байгаа CO<sub>2</sub>-ийн 40 орчим хувийг жил бүр шингээх боломжтой гэдгийг АНУ-д хийсэн судалгаагаар илрүүлсэн байна. Энэ нь Дэлхийн хүртэх шууд ач тус юм.

Органик веган газар тариалангийн үр өгөөжтэй бусад тал гэвэл

ургамал сэлгэн тариалах, хучих, байгалийн бордоо хэрэглэх зэрэг болно. Сэлгэн тариалах гэдэг нь талбайд улирал бүр өөр өөр ургамал тариалахыг хэлнэ. Энэ арга нь ургамлыг эрүүл байлгаж, хөрсний тэжээл, үржил шимийг алдагдуулахгүй хадгалдаг. Хучилт зэрэг бусад арга, тэр байтугай газрыг хагалахгүйгээр органик газар тариалан эрхлэх шинэ аргууд ч хөрсний чийгийг хадгалж, элэгдлийг багасгах ач тустай билээ.

Тиймээс органик веган аж ахуй нь үндсэндээ байгальтайгаа эв зохицолтой аж төрөн, дэлхий болон хамаг төрөлтнийг хайрлан хамгаалах гүн ухааны үзлийг баримталдаг. Хэрэглэдэг эдгээр арга нь хүрээлэн буй орчин ба газар тариалан эрхлэлтийн хоорондын байгалийн тэнцвэрт байдлыг дэмждэг юм. Яваандаа эдүгээ бидэнд буй хамгаалах, тариалах эдгээр арга техникийг хослуулан өнгөрсөн хугацаанд үүссэн байж болзошгүй асуудлуудыг шийдвэрлэх, тэнцвэрт байдлыг сэргээхийн тулд удаан хугацаанд хэрэгжүүлж болно.

## **ОРОН НУТГИЙН ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ОРГАНИК МАХНЫ АЛИЙГ ИДЭХ ВЭ?**

Сонирхолтой нь, дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн хэрэглэх нь веган хоол идэхийн дайтай сайн үр нөлөө үзүүлж чадахгүй болохыг судалгаанууд харуулсан байна. Жишээлбэл: Карнэйги Меллон Их сургуулийн эрдэмтэд 100% дотооддоо үйлдвэрлэсэн махан хоолтой харьцуулахад веган хоол нь хорт хийн ялгарлыг 7 дахин их хэмжээгээр багасгана гэсэн тооцоо хийжээ. Тэгэхээр, веган хүнс нь дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн хэрэглэснээс ч илүү нөлөө үзүүлдэг байна.

**Германы Фүүдвотч (Foodwatch) байгууллагын хийсэн өөр нэг судалгаагаар бол ердийн махан хоолноос органик махан хоолонд шилжихэд хорт хийн ялгарах хэмжээ ердөө 8%-аар, харин органик бус веган хооллолтод шилжихэд хорт хийн ялгарал 86%-аар багасаж байгааг тогтоосон байна.<sup>102</sup> Тэгэхээр, бид веган байснаар дэлхийгээ аварна. Бүр органик биш веган ч гэсэн! Ер нь органик бүтээгдэхүүн сайн, дотоодын үйлдвэрийнх бол бүр гайхалтай, гэвч анхны алхам бол органик эсвэл органик бус ч бай ядаж л веган болох явдал.**

Органик аргаар үйлдвэрлэсэн мах ч гэсэн экологид таатай бус бүтээгдэхүүн; энэ нь органик бус аргаар үйлдвэрлэсэн махнаас ч илүү их газар, эрчим хүч шаарддаг. Та үүнд итгэж байна уу? Тиймээс малыг органик аргаар өсгөж үржүүлэх гэж оролдсоны ач тус гарахгүй. “Тогтвортой”, “бэлчээрийн” гэгдэх шувууны органик аж ахуй нь органик бус шувууны фермээс 20% илүү эрчим хүч шаардаж, дэлхийн дулааралд 20%-аар илүү нөлөө үзүүлдэг. Үүний талаар бодож үзээрэй. Тэгэхээр бид үргэлж л төөрөлдөж байжээ.



### III. АМЬ АМЬДРАЛАА АВРАХЫН ТУЛД БУСАД АМЬДРАХ БОЛОМЖ ОЛГОЁ

Арсланг хургатай хамт амгалан тайван оршихыг хүсэхээс урьтаж хүмүүс бид үүнийг хийх ёстой.

#### *Мах идэх нь хүн болоод амьтны аль алиныг хөнөөдөг*

Мах идэх нь бусдыг төдийгүй өөрийгөө ч хэрэгт холбогдуулдаг хамгийн хэрцгий үйлдлийн нэг. Бид амьтныг өөрийн гараар алаагүй байсан ч тэдний үхлийн төлөө хариуцлага үүрнэ.

Махны төлөө бид [мал амьтныг] хэдэн тэрбумаар нь алж байна. Цочирдмоор тоогоор буюу 55 тэрбум мал амьтныг, өөрөөр хэлбэл, дэлхийн хүн амаас 8 дахин их тооны мал амьтныг бид жил бүр идэшний зориулалтаар хөнөөдөг.<sup>103</sup> Үүнд хэдэн тэрбумаараа үхэж үрэгдэж буй загасыг оруулан тооцвол өдөр бүр 155 сая гаруй тоо толгой амьд амьтан үрэгдэж байна.

Махны тухай ярихдаа мөн сүү, сүүн бүтээгдэхүүнийг хамруулж байгаагийн учир нь сүү үйлдвэрлэхийн төлөө хөөрхий амьтад ялгаагүй л харгислал, тамлалыг амсаж, эцэстээ аймшигтайгаар үхдэг. Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ч гэсэн өршөөж энэрэх сэтгэл байхгүй.

Мах, загас, амьтантай холбоотой хүнс хэрэглэснээс хүмүүс өөрсдөө ч жил бүр нас барж байна. Махнаас үүдэлтэй зүрхний өвчин, хорт хавдар болон бусад өвчний улмаас жилд 33 сая орчим, өдөрт 90000 гаруй хүн нас барж байна.

Мөн хүнд хэрэгцээтэй үр тариаг хүнсэнд зориулж нядлах малыг тэжээхэд хэрэглэж байгаагаас олон хүн хоол хүнсний дутагдалд орж байна. Шууд бус өлсгөлөнгөөр 25000 хүн нас бардаг нь бас л махны үйлдвэрлэлтэй холбоотой.<sup>104</sup>

Жил бүр хэдэн зуун мянган хүн махны үйлдвэрлэлээс үүдэлтэй дэлхийн дулааралд өртөн нас барж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс болж хүмүүс хэдэн арван саяараа орон гэргүй болж байна. Бид тэднийг уур амьсгалын дүрвэгсэд гэж нэрлэдэг, ийм нэр томьёо байна уу үгүй юу; үнэндээ бол тэд нийгэмд эзлэх ямар ч байр суурьгүй байна шүү дээ.

Үүнд махны үйлдвэрлэлтэй холбоотой асуудлаас болж зовж буй гэм зэмгүй байгалийн (зэрлэг) болон гэрийн тэжээвэр олон амьтныг оролцуулалгүй хэлэхэд л энэ шүү дээ.

**Махан хүнс дэлхийн дулаарал болон аллагад нөлөөлж, амь хөнөөхөд хүргэж, хөнөөсөөр л байна. Тийм учраас МАХны хэрэглээ нь таслан зогсоох ёстой аллага, гэмт хэрэг мөн.**

## МАЛ НЯДАЛГАА: ДЭЛХИЙГ ХАМАРСАН ГЭМТ ХЭРЭГ

Бидэнд өөр сонголт байсаар байтал ямар ч гэм зэмгүй, хөөрхий амьтдыг өөрсдийнхөө таашаал шуналыг хангахын төлөө хоморголон алах нь зан суртахууны хамгийн том доройтол мөнөөс мөн. Ийнхүү бөөнөөр нядлах аллага бол дэлхийн цараатай гэмт хэрэг юм. Мөн энэхүү алж хөнөөх үйлдлийн энерги нь эргээд бусад сөргүү энергийг тэтгэж, хүчийг нь нэмснээр манай нийгмийг доройтуулж, дэлхийг сүйтгэдэг.

Мянга мянган жилийн турш шууд болон шууд бусаар гэм зэмгүй хэдэн тэрбум амьтныг, тэр бүү хэл өөрийн адил хүн төрөлтнүүдээ хэдэн саяар нь алж хөнөөснөөр маш их, тун их сөрөг энерги үүсгэсэн байна. Шууд гэдэгт дайн хамаарна. Шууд бус гэдэгт хүний үйл ажиллагаанаас шалтгаалан үүссэн булчирхайн тахал, тарваган тахал, одоо болохоор гахайн томуу, шувууны томуу зэрэг өвчин хамаарна.

Дэлхийн дулаарлын гол шалтгаан нь махан хооллолт болж буй нь тохиолдлын хэрэг биш. Манай дэлхий дээрх эрүүл мэндийн голлох асуудлын олонх нь мөн л мах хэрэглэснээс улбаатай. Тиймээс мах идэх нь амьтанд зүй бус хэрцгий хандаж байна гэсэн үг. Мах идэх нь өөрсдийнхөө сайн сайхан байдлыг баллаж байна гэсэн үг. Мах идэх нь үр хүүхдүүдийнхээ сайн сайхан байдлыг баллаж байна гэсэн үг. Мах идэх нь эх дэлхийдээ харгис хэрцгий хандаж байна гэсэн үг. Веган болцгооё, тэгвэл бид эдгээр сөрөг үр дагавраар хэзээ ч дахин зовохгүй.

Бид хүнийг болон мал амьтныг алж хөнөөхийг зогсоох ёстой. Бид амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг зогсоох ёстой. Бид эдгээрийг хэрэглэдгээ зогсоох хэрэгтэй. **Зогсоох гурван зүйл: аллагыг зогсооё, үйлдвэрлэхийг зогсооё, хэрэглэхийг зогсооё. Бас идэхийг, мэдээж мах идэхийг зогсооё.**

Хүмүүс мал амьтны аж ахуйн цаана буй аймшигт үнэнийг болон амиа зольж буй бүхий л амьтан гэм зэмгүй болохыг ойлгосон цагт өөр нэгэн төрөлтний цогцсыг идэх нь шаардлагатай бус төдийгүй бидэнд цусан ул мөр үлдээж буйг амархан ухамсарлах болно.

## БАЙГАЛЬТАЙ ЭВ ЗОХИЦЛОО СЭРГЭЭЕ

Бид бүгдээрээ эх дэлхийнхээ газрыг, усыг, агаарыг, нөөц баялгийг, хүнсийг хуваалцаж хүртдэг гэдгээ санах хэрэгтэй; байгалийн бүх юмыг бид бусадтайгаа зөвхөн хуваалцдаг. Веган болж, байгалиа хамгаалан, амьтдын ч амьдрах эх дэлхийг аварцгаая. Энэ бол хүрээлэн буй орчноо сэргээж, энх амгаланг дээд зэргээр баталгаажуулах хамгийн шилдэг арга яах аргагүй мөн билээ.

“Бид Дэлхийн нэг хэсэг, тэр ч мөн бидний нэг хэсэг. Анхилам цэцгүүд бол бидний эгч нар; буга, морь, аугаа бүргэд бол ах нар маань юм. Амьтадгүйгээр хүн юу юм бэ?”

“Бүх амьтан алга болчихвол хүн төрөлхтөн хэмжээлшгүй их сүнслэг ганцаардлаас болж үхэх болно. Хадан хошуу, хөдөө нутгийн чийглэг, хагалсан газар, морь хүн хоёрын элгэмсүү холбоо – энэ бүхэн цөмөөрөө л нэг гэр бүлд багтдаг. Дэлхий хүний өмч биш; хүн өөрөө Дэлхийн өмч юм.”

— *Ахлагч Сэлт, Америкийн уугуул Дувамиш омгийн ахлагч, АНУ-ын Вашингтон мужийн Сиатл хотыг түүний нэрээр нэрлэжээ*

Гараг дэлхийгээ огт амьтангүйгээр төсөөлөөд үз дээ. Бүх нохой, муур, шувуу, загас, одос үхэр, заан байхгүй; амьтдын аль нь ч амьд үлдээгүй гэж төсөөлөөд үз дээ, ийм үед бид яаж амьдрах билээ? Бидний амьдрал хэрхэн ийм элбэг дэлбэг дүүрэн санагдах билээ? Маш зэврүүн, утга учиргүй санагдах болно.

Тэгэхээр, хэрвээ бид бүх амьд оршихуйг хүндэтгэж байгаа бол тэдний амийг зүй бусаар булаах ёсгүй. Дэлхий маань баялаг үр шимээ хүн, амьтны аль алинд нь хангалттай хүрэлцэхээр өгдөг. Бид бусад төрөлтнөө зовоож эсвэл гэмтээж байж өөрийн хувийг авах хэрэггүй. Дахин дахин хэлэхэд энэ нь амьтны бус гаралтай хоол хүнсийг хэрэглэ гэсэн үг.

**Хэрвээ хүн төрөлхтөн бүхэлдээ бусдын амь нас болон байгаль дэлхийгээ хүндэтгэж, амьтны бус гаралтай хүнсээр хооллон амьдарвал Дэлхий маань Диваажин байх болно.** Бүх зүйл өршөөгдөнө. Бүх зүйл сайн сайхан байх болно. Эх дэлхий маань нөхөн сэргэж, амьтад бидэнд талархаж, хүмүүс эрүүл байж, бүгдээрээ аз жаргалтай, адислалаар дүүрэн болно. Хийх хэрэгтэй зүйл нь ердөө л веган болох явдал.

## **АМЬТАД ХОРВООД ХАЙРЫГ АВЧИРДАГ**

Амьтад үнэхээр хүн төрөлхтөнд туслахаар ирдэг. Библи сударт “Тэднийг та нарын найз, бас туслагч байг гэж би бүтээсэн” хэмээн сургасан. Энэ үнэхээр тийм юм. Гэвч хүн болгон үүнийг хүлээн авч чадахгүй байгаа бөгөөд энэ нь харамсалтай. Үүний оронд тэднийг алж хөнөөж байна.

Эзэн Бурханы маань Дэлхий дээр бүтээсэн болгон зорилготой. Бид юуг ч алж устгах ёсгүй. Би ургамлын хүнснээс өөр бусад юуг ч идэх учиргүй.

Амьтад энэ дэлхийд тусгай зорилготой ирдэг. Тэдний олонх нь ердөө л энд оршин байгаа гэдгээрээ Диваажингаас тэнгэрлэг хүчийг

буюу хайрыг буулгаж ирэх чадвартай. Морь, туулай гэх мэт зарим амьтан халамжлагч хүнээ сөрөг энергиэс хамгаалж, эсвэл тэдний эрүүл энх, аз хийморь, бүр материаллаг аз жаргал, баяр хөөр, эсвэл сүнслэг дэвшлийг нь нэмэгдүүлэхэд тусалдаг. Тэд биднийг чимээгүйхэн ажиглаж, бидний замыг даруухнаар адисалж байдаг. Тэдний зарим нь ухамсрын дээд түвшнээс ирсэн байдаг; тэд зөвхөн хүн төрөлхтөнд эсвэл Дэлхийн бусад төрөлтөнд туслах гэж л амьтны дүр төрхөөр бууж ирдэг юм.

Мөн амьтад энэ бодит ертөнцөд маш эрхэм ариун, чухал үүрэг гүйцэтгэдэг. Зарим амьтан, жишээлбэл: алаг тахь, сармагчин, байгаль дахь тогь үр түгээхэд, зөгий болон бусад шавж тариа, ургамлын тоосыг хүртээхэд тусалдаг бол бусад нь ой хөвч, далайг эрүүл байлгахад анхаардаг. Амьтад хүмүүст шууд аргаар ч бас тусалдаг.

Маш олон эрхэм амьтан хүний амь аварсан тухай би сониноос уншиж, радиогоор сонсож, зурагтаар үзсэн. Тэд өөрийнхөө амийг зөлин байж нэгнээ авардаг. Тиймээс бид алт шиг үнэтэй энэ бүх амьтнаас үлгэр жишээ авч суралцах хэрэгтэй.

(Хүн ба амьтны Хайрын чанар буюу LQ, Эрхэм ариун чанар буюу NQ-ийн талаарх Их Багш Чин Хайн сүнслэг тайлбарыг 10 дугаар хавсралтаас уншаарай.)

## ДЭЛХИЙ ДЭЭР ДИВААЖИНГ БҮТЭЭЕ

Хүн бүр веган болох эрхэм зорилгын хүрээнд органик веган аж төрөхийг хэрэгжүүлбэл, бид хамтын зүтгэлээрээ хүмүүн болон бидэнтэй зэрэгцэн оршигч амьтдын аль алинд аюулгүй, энх тайван дэлхийг цогцлооно.

Дэлхий маань хүн бүр нийгмийн үйлчилгээ, нөөц баялгаас адил тэгш хүртдэг Диваажин шиг л болно. Бүх зүйл тэгш хуваарилагдана. Хүн бүр хүндлэгдэн, хайрлагдаж, дэргэдэх, эхний, эсвэл сүүлийн хүнтэй яг адил халамжийг хүртэнэ.

*Төгс Гэгээрсэн Их Багш шавийн хүүрнэл:*

**Асуулт:** Төгс Гэгээрсэн Их Багш аа, хүмүүс ба амьтад хайрын сэтгэлээр харилцах нь манай гарагт хэрхэн нөлөөлөхийг тайлбарлаж өгөөч.

**Төгс Гэгээрсэн Их Багш:** Аа, тэгвэл Дэлхийд том энх тайван тогтох болно. Том үсгээр ЭНХТАЙВАН гэдэг утгаар би хэлж байна.

# 4

## ВЕГАН ХУУЛЬ, БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Засгийн газрууд амьтдыг хөнөөх болон мал амьтдыг нэмж өсгөн үржүүлэхийг хориглосон хууль гаргах байх гэж би найдаж байна.

Хэрэв удирдагчид ард түмнээ хамгаалж, улс орноо олон талаар сайжруулан хөгжүүлнэ гэж амласан л юм бол энэ нь тэдний хийх ёстой хамгийн эхний алхам.

Махны үйлдвэрлэл, загас агнуур, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг зогсоох хэрэгтэй. Тэгвэл манай гараг дэлхий урьд өмнөх шигээ, бүр түүнээс илүү сайхан болно.

### I. ДЭЛХИЙН УДИРДАГЧИД ӨӨРСДӨӨ ҮЛГЭР ДУУРАЙЛ ҮЗҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ

#### ВЕГАН БАЙЯ

Би тэдэнд [дэлхийн удирдагчдад] дэлхийн хоолны дэглэмийг өөрчлөхөд эрх мэдэл, хүчээ хэрэглээрэй гэж хэлмээр байна. Мөн шинэ технологи, тогтвортой эрчим хүчийг нэн даруй хэрэгжүүлж эхлэхийг зөвлөж байна. Өөрсдөө цагаан хоолтон, эсвэл веган болж бусдадаа үлгэрлээрэй. Хоол хүнсээ өөрчил. Өөрт олгогдсон эрх мэдлээ хэрэглэ. Өөрөө үлгэр дуурайл үзүүлж, дэлхийд цагаан хоол (веган) хоол хүнсний шинэ цаг үеийг эхлүүлээрэй.<sup>105</sup>

**Юуны өмнө тэд өөрсдөө цагаан хоолтон (веган) болох ёстой, тэгсний дараа эрх мэдлээ хэрэглэх хэрэгтэй. Яг л тамхийг**

хориглосонтой адил. Тэд хүн төрөлхтөнд болон гараг дэлхийд махны учруулдаг бүх хор хөнөөлийг хэлж таниулан махыг ч бас хориглож болно шүү дээ. Тэд үүнийг яг тамхийг хориглосонтой адил хийж болно.

## **ХАЙРЫН ЗАРЧИМД НИЙЦҮҮЛЭН ҮЙЛДБЕ**

Удирдагчид өөрсдийгөө ч гэсэн өөрчлөх ёстой, дараа нь манай нийгмийн тогтолцоог илүү эрх чөлөөтэй, сүнслэг, өндөр ёс суртахуунтай болгон хувиргах хэрэгтэй. Учир нь тэд энэ үүрэг хариуцлагыг үүрч явдаг - хэрэв тэд Диваажингийн энэрэнгүй мөн чанар болон дэвшингүй төлөвлөгөөгөөр үйлдэхгүй, орчлонгийн зарчмын дагуу үйлдэхгүй бол энэ үүрэг тэдэнд хүнддэх болно.

Хамгийн эхний бөгөөд хамгийн чухал зарчим бол хайрын зарчим. Энэ зарчмын дагуу хийсэн тэдний үйлдэл болгон сайн байх болно. Бусдад тустай байх болно гэсэн үг. Хүмүүсийн төлөө дэвшил гаргах, хамаг бүхэнд өмөг түшиг болох, бүхий л амьд оршихуйд хүндэтгэлтэй хандах - энэ бол хайрын зарчмаар үйлдэж буйн илэрхийлэл. Үүний эсрэг хийгдэж буй ямар ч үйлдэл өөрсдөдөө, улс орондоо, эсвэл гараг дэлхийд бүхэлд нь гай гамшиг тарих нигууртай.

Хэрэв эдгээр удирдагч жинхэнэ мөн чанараа таних сүнслэг талдаа илүү анхаарч хичээх аваас тэд өөрийгөө ямар их сүр жавхлантай, өгөөмөр, хайрлагч, энэрэнгүй, мэргэн ухаалаг, бас Бурханлаг гэдгээ мэдэх болно. Тэгээд тэд шагналаа ч хүртэнэ. Гэвч энэ нь тэд хүн төрөлхтөн, амьтад, хүрээлэн буй орчиндоо хэр их тус хүргэсэн, хэр чин сэтгэлээсээ ажилласнаас шалтгаална. Хэрэв тэд гараг дэлхийдээ туслахын төлөө бүх чадлаараа хичээж, тэдний тусламжийг хүртсэн хүмүүсийн тоо, өөрийнх нь чин сэтгэл аугаа их байвал сүр жавхлантай Диваажингийн орон тэднийг тэрчлэн угтан хүлээж авах болно. Бурхан бидний зүрх сэтгэл, үйлсийг мэдэж байдаг юм, ойлгож байна уу?

## **II. ТӨР ЗАСАГ НЭН ДАРУЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЁСТОЙ**

Улс үндэстний удирдагчид ямар нэг зүйл хийх ёстой. Бүх улс орны ард түмэн арга хэмжээ авах хэрэгтэй. Бид энд сайхан суугаад ярьж болоод байгаа, бидний амьдарч байгаа нутагт барааны үнэ өсөөгүй, усны хомсдол хараахан гараагүй байна гэдэг нь бидэнд энэ бүхэн хэзээ ч тохиохгүй гэсэн үг биш билээ.

Бусад хэдэн тэрбум хүнд аль хэдийнээ тохиолдоод байгаа эмгэнэлт явдлаас зайлсхийхийн тулд бид ямар нэг зүйл хийх ёстой. Уур амьсгалын өөрчлөлт, ус, хоол хүнсний хомсдолоос болж аль хэдийнээ нэг тэрбум хүн өлсгөлөн байна. Одоо нэн даруй арга хэмжээ авна уу; маш энгийн. Зүгээр л веган болцгооно уу. Одоо энэ цаг үед ердөө л веган байхад үнэндээ хангалттай, мөн ирээдүйд ч хангалттай бэлтгэлтэй байна гэсэн үг.

## УРГАМАЛД СУУРИЛСАН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭЕ

Хүмүүс тавган дээр нь чухам юу байгаа тухай үнэндээ сайн мэдээлэлгүй байдаг. Ихэнхдээ тэдний тавган дээр бөөгнүүлэн тавьсан жаахан мах анхдагч эх сурвалжаасаа огт өөр харагддаг.

Тэгээд өнөөх уламжлал гэгдэгч зүйлс үе дамжиж давтагдсаар л байдаг. Тэгээд бүхий л нийгмээрээ үүнийг амьдрах угийн жам ёс мэт санаж дэмжсээр байна. Харин одоо хүмүүс амьтдад учруулж байгаа зовлон, шаналал, харгислалыг илүү ухаарах болжээ. Тэгэхээр хүмүүс бид илүү энэрэнгүй байж, бүхий л амийг хүндэтгэх цаг болжээ гэж би бодном.

Ихэнх хүн мал аж ахуйн үйлдвэрлэлээс ялгардаг хорт хийн талаар, эсвэл амь хөнөөх нь харуу амийг нэхдэг, мах бол бас нэгэн төрлийн донтуулагч хор гэдгийг ойлгодоггүй. Тэд махны хэрэглээ манай гараг дэлхийг бүхэлд нь устгаж байгааг ухаарахгүй байна.

Одоо төр засаг хүмүүст мах үнэхээр их хор хөнөөлтэй, хүмүүс нэн яаралтай мах идэхээ болих хэрэгтэйг сайтар тайлбарлаж өгөх ёстой. **Энэ одоо хувь хүний сонголт байхаа больсон. Харин манай гаргийн үхэх-сэххийн асуудал болоод байна.**

Гай гамшиг нүүрлэвэл Засгийн газар хүмүүсийг үтэр түргэн нүүлгэн шилжүүлдэг. Мөн дайны үед хүмүүст өөрийгөө хэрхэн аварч хамгаалах талаар хэлж өгдөг. Тэр бүү хэл эх орноо хамгаалуулах буюу тулалдахаар явуулахын тулд армид хүмүүсийг элсүүлдэг.

Харин одоогийн энэ тохиолдол бол дайнаас ч илүү ноцтой. Засгийн газарт шийдэл олдоно гэдэгт би итгэлтэй байна. Хүн арддаа энэ талаар мэдээлнэ гэдэгт би итгэлтэй байна. Засгийн газарт үүнийг хийх эрх мэдэл, хүч чадал олгосон байдаг.

Засгийн газрууд үүнд туслах ёстой. Цагаан хоолтны амьдралын хэв маягийг урамшуулан дэмжсэн мэдээллийг илүү их түгээж, гараг дэлхийг бүхэлд нь хайр, энэрэл нигүүлсэл, эрүүл мэндийн шинэ энергиэр дүүргэвэл хүн бүр үүнд нэгдэнэ. Урамшуулан, дэмжсэн энерги маш чухал.

Үүнийг хаа сайгүй хэвлэн нийтлэх хэрэгтэй. Тэд хүмүүст унших хуудас өгч, үүнийг олон нийтийн ажил болгох хэрэгтэй. Тэд албан ёсны баталгаа өгч, хүн бүрд цагаан хоолны ач тусыг мэдэх боломжийг өгөх хэрэгтэй. Цагаан хоолны цэсэд зориулж вэб хуудас гаргаж, ургамлан хоолны үнэ төлбөргүй сургалт, цагаан хоолны клуб нээх хэрэгтэй. **Үүнийг албан ёсны болговол хүн бүр аз жаргалын чиг хандлагыг дагаж, дэлхийд шинэ өөрчлөлтийг авчрах болно.**

Хамгийн чухал нь хүн төрөлхтөн, дэлхийн бүх иргэн Дэлхийгээ аврахын тулд цагаан хоолтон болохын аугаа ач тусыг мэдэх явдал юм. Тэд бидний одоогийн нөхцөл байдал хэчнээн аюултай, хэчнээн бачим болсныг мэдэх хэрэгтэй. Энэ бол хамгийн чухал зүйл.

Тэд мөн цагаан хоол, аминд хүрээгүй хүнс нь ёс суртахууны талыг тооцохгүйгээр ямар их ач тусыг хүн төрөлхтөнд авч ирэхийг мэдвэл зохино. Эхлээд цагаан хоол нь бидний эрүүл мэнд болоод дэлхийг аврахад хэрхэн ач тус хүргэдийг яривал үр хүүхдүүд маань ирээдүйд амьдрах гэртэй байх болно.

Бидэнд ганцхан л гэр бий: Дэлхий. Хэрэв энэ дэлхий устаж үгүй болбол, өөр нэгийг бий болгох боломжгүй, тэр буцааж барьж болдог байшинтай адилгүй, Дэлхий үгүй болчихвол бид өөр нэгийг барьж босгож чадахгүй. Энэ тийм ч амар биш. Тиймээс Засгийн газрын хийх хамгийн чухал ажил бол олон нийтэд энэ талаарх мэдээллийг түгээх юм.

## **ТАМХИЙГ ХОРИГЛОСОН ШИГЭЭ МАХЫГ ХОРИГЛОЁ**

Цагаан хооллолт нь амьдралын хэв замнал байх ёстой. Үүнийг шүүн хэлэлцэх яриа байх ёсгүй.

Бид маханд хориг тавих ёстой. Бид одоо хүмүүст юу идэхийг, цагаан хоол хэрхэн хийхийг зааж харуулангаа махыг хориглож байна. Бүгдээрээ хөдөлье. Энэ нь үнэхээр эсэн мэнд үлдэхийн төлөө юм шүү дээ. Хүмүүст мах идэхийн аюул хөнөөлийг ойлгуулж, тэдэнд шийдлийг нь зааж харуулахыг амьдралынхаа зорилго болгоё.

Удирдагчид тамхинд хориг тавьсан, тэгээд одоо энэ нь хориотой зүйл болсон. Тэд хар тамхийг хориглосон, тэгээд энэ хориотой зүйл болсон. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлогын хувьд ч энэ ялгаагүй байх болно. Хэрэв удирдагчид сайн гэж мэдэж байгаа зүйлээ зүгээр л хийчих юм бол үр дүн нь маш хурдан гарна. Бид тэр даруйдаа буцаж хэвэндээ орох буюу муу үр нөлөө даруй зогсох болно.

Яагаад гэвэл хэрэв бид малын тоо толгойг нэмж үржүүлэхгүй байвал манай Дэлхий илүү тогтвортой болно: амьтнаас үүдэлтэй хүлэмжийн хий буюу метан хий цаг үргэлж хуримтлагдахаа больж, байхгүй болно. Одоо бид байгаагаа [амьтад] үлдээн мах болоод ашгийн төлөө малыг үй олноор нь нэмж өсгөн үржүүлэхгүй байвал Дэлхий маань буцаад нөхөн сэргэнэ. Хэсэг хугацааны дараа үхрийн тоо толгой байгалийн жамаараа буурна. Бүх газар нутагтаа дахин ой мод, ногоог тарих болно.

Энэ хандлагыг тамхитай харьцуулж үзье. Тамхи бол махтай адил нэг төрлийн хөнөөгч бодис. Дөнгөж 1950 онд, тамхи уушгины хорт хавдар үүсгэдэг гэсэн анхны томоохон судалгааны үр дүнг танилцуулсны дараа засгийн газрууд тамхины хоригийг хэрэгжүүлж эхэлсэн. Ингээд аажим аажмаар өнөөдрийг хүртэл 80 гаруй улс оронд олон нийтийн газар тамхи татахыг ямар нэг байдлаар хориглосон байна.<sup>106</sup>

Тамхи татахыг хориглосон нь хүмүүст тамхи татах муу зуршлаасаа салахад тусалсан бөгөөд тамхинаас гарсан хүмүүс энэ зуршил өөрт нь



муу гэдгийг мэдэж байсан учраас тамхины хоригт талархалтай хандсан гэдгийг судалгаа харуулсан.

Маханд хориг тавих ч үүнтэй төстэй. Мах бол бид бүхнийг болоод үр хүүхдийг маань, хайртай хүмүүсийг маань, гараг дэлхийг маань хөнөөж байгаа маш муу зуршил гэдгийг бид одоо бүгдээрээ судалгаануудаас мэддэг.

Тиймээс, маханд хориг тавих нь веган дэлхий болохыг зорьж буй чиг хандлагаа хадгалан идэвхжүүлэхэд хүчтэй түлхэц үзүүлнэ.

Учир нь сайн удирдагч ард түмэндээ муу нөлөөтэй зүйлийг зогсоож, тэдэнд тустай зүйлсийг хэрэгжүүлэхийг дэмждэг. Удирдагч нар олон нийтийн аян, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сургуулиудаар дамжуулан эрүүл амьдралаа болон гараг дэлхийгээ аврах ач тустай амьдралын хэв маягийг залан дэмжиж болох билээ.

## **БИДЭНД ӨӨР ЯМАР Ч СОНГОЛТ БАЙХГҮЙ**

### *Нэг бол бид өөрчлөгдөнө эсвэл бүгдээрээ устана*

**Юуны өмнө бидэнд өөрчлөгдөхөөс өөр ямар ч сонголт байхгүйг ойлгох хэрэгтэй. Нэг бол бид өөрчлөгдөнө, эсвэл бүгдээрээ үгүй болно. Өөр ямар ч сонголт байхгүй.**

Хэрэв бид мал өсгөн үржүүлэхээ, мах идэхээ зогсоохгүй бол гараг дэлхийгээ, үүнд хамаарах өөрсдийгөө, эрхэлж буй махны бизнесээ ч аварч чадахгүй. Тэгэхээр бид амь нас, ажлын амжилтын аль нэгийг сонгох ёстой гэж бодож байна. Бид эхлээд амьд үлдэх хэрэгтэй. Бид зөвхөн зарим бизнесийг бус, энэ дэлхийн хүмүүсийг бүхэлд нь бодож үзэх хэрэгтэй. Энэ үнэхээр нэн яаралтай зүйл.

Ийм нэн чухал хэрэгцээ шаардлага байгаа учраас эдийн засгийн учир шалтгаанаар махны үйлдвэрлэлд уягдаад байгаа энэ хүмүүст бид зөв зохистой мэдээлэл өгч, амьдралын хэв маяг болон ажил мэргэжлээ өөрчлөх хэчнээн чухал болохыг ойлгуулбал тэд өөрчлөгдөх хүсэл зоригтой болно. Тэднийг хөдөлгөх олон хүчтэй сэдэл бий. Жишээлбэл: эхнийх нь уур амьсгалын гамшгаас дэлхийг, дэлхий дээрх бүх амьдралыг аврах сэдэл юм.

Хэрэв бид үүнийг зогсоохгүй бол үнэмлэхүй гамшиг, үй олноороо мөхөх зүг рүү явсаар л байх болно, энэ нь та махны бизнес эрхэлдэг, түүнийг тээвэрлэдэг зэргээр махны үйлдвэрлэлд хамаатай, хамаагүй ямар ажил хийдэг байхаас тань үл хамааран бүх л хүнд ялгаагүй нөлөөлнө.

*Амьтныг алж хөнөөх болон дайн дажныг зогсоож, улс орноо сэргээн босгоё*

Гол нь улс орны удирдагчид тэргүүн зэргийн чухал асуудлаа мэддэг байх хэрэгтэй. Энэ дэлхий сүйрэхийн ирмэгт байхад дайн, эсвэл албан тушаал, эсвэл өөр зүйлд санаа зовохын хэрэг юу байна? Тэгэхээр яг одоо бүх удирдагч дэлхийгээ аврахад анхаарлаа төвлөрүүлж, илүү буянтай энэрэнгүй амьдралын замналын талаарх мэдээллийг түгээж, шинэ хууль гаргахад анхаарах ёстой.

Уул нь хуультай байх хэрэггүй ч хуультай байвал илүү дээр, илүү бодитой байж магадгүй; түүнээс биш хүмүүс бол бэлэн байна. Зөвхөн Засгийн газрууд шинээр зарим нэг хууль журам гаргаж хэрэгжүүлэх, хүмүүст юу нь сайн, эрхэм буянтай болохыг, амьтдыг хөнөөхгүй, идэхгүй, эсвэл хүн, амьтан, байгаль орчинд халтай зүйл хийхгүйгээр амьдрах тухай хайрын хуулийг дагаж мөрдөхийг сануулах хэрэгтэй.

Илүү бодитой, дэвшингүй арга хэмжээнүүд байх хэрэгтэй. Эхлээд бүх дайн дажныг зогсоох ёстой. Мөнгө, барааг зөвхөн хамаг төрөлтнийг тэжээж тэтгэхэд чиглүүлж, дэлхийн баялаг нөөцийг бүх хүнд хүртээмжтэй түгээх ёстой. Жишээлбэл: бүр дайн дажингүй болбол түүнд холбогдох хөрөнгө мөнгө нь бүх дэлхийг хэдэн арван жил үнэгүй тэжээхэд хүрэлцэнэ.

Амь таслах, хүмүүсийг болон амьтдыг зовоодог бүх үйлдлийг зогсоох ёстой. Ой мод огтлох, байгаль орчинд хор хохирол учруулах, сүйтгэх бүх үйлдлийг зогсоох ёстой. Төр засгийн удирдагчид хуулиндаа зөвхөн ач тустай, энх тайванг эрхэмлэсэн заалтыг л тусгаж, боломжтой бол бүх төрөлтийн сүнслэг дэвшилд хамаарах, тухайлбал: бусдад хал балгүй, харин ч ач тустай, үнэнхүү сүнслэг бүлгийг хамгаалах заалтыг тусгаж болно.

Баялгийг бүгдтэй хуваалц: Гачигдалтай хүн ба амьтдад хангалттай хоол хүнс, хувцас хунар тараая. Бүх амь насыг хамгаалахын тулд бүх хүн, амьтанд зориулсан хамгаалах газар, оромж байруудыг бий болгоё. Ой модыг нөхөн сэргээж, далай, тэнгис, нуур, гол мөрний усыг цэвэрлэе, хамгаалъя; ногоон бүс, амьтдыг хамгаалж буй хамт олныг шагнаж урамшуулъя. Архи, согтууруулах ундаа, хар тамхи, мах, амьтны гаралтай бүтээгдэхүүнүүдээс ангижир. Амьтад дээр харгис туршилт хийдэг лабораторийн туршилтуудыг зогсоох ёстой. Амьтад үржүүлдэг аж ахуйнуудыг хаая. Хоригдлууд эсвэл цэргүүдийг ч мөн адил хүмүүст туслах, ургамал ногоо тарих, үр өгөөжтэй ажил хийхэд дайчилъя. Органик ногооны аж ахуйнуудыг дэмжиж, тусалцаа үзүүлье. Боловсрол, эрүүл мэндийн салбар, үйл ажиллагаанд татаас олгоё.

Мөн зэр зэвсгийн үйлдвэрлэлийн бизнесийг цэглэн үгүй болгох ёстой. Нийгмээ бүхий л сүүдэртэй, хор хөнөөлтэй бүтээгдэхүүн, үйл ажиллагаанаас цэвэрлэе. Бүх хүний аюулгүй байдал, тав тухыг хангаж өг, тэгснээр хэн ч наад захын хэрэгцээ болон эрдэм боловсролоор дутагдсанаасаа болж гэмт хэрэг үйлдэхгүй. Хил хязгаарыг арилгаж, бүх иргэнд ижил зэрэглэл, байр суурьтай байх, адил тэгш, хүндэтгэлтэй хандах нөхцөлийг бүрдүүлье.

Хэрэв [Засгийн газрууд] ямар нэг хүчний байгууллагаа авч үлдэх хэрэгтэй байвал тэднийг гамшигт өртсөн зайлшгүй шаардлагатай хүмүүст туслах, шаардлагатай үед орон гэрийг нь сэргээн барьж өгөх, тусламж хэрэгтэй үед нь очиж туслах дадал олгохоор дахин сургаж бэлтгэе. Энэ бүхнийг, бүр үүнээс ч илүү ихийг хийх хэрэгтэй байна. Бусдад, ард иргэдэд, амьтад болон хүрээлэн буй орчинд туслах ямар л зүйл байна бүгдийг нь хэрэгжүүлэхийн төлөө бүх Засгийн газар, удирдагчид хамаг чадлаараа хичээж арга хэмжээ авах, үүнийг бүр нэн даруй хийх хэрэгтэй байна.

## МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛ АЛДАГДАЛТАЙ БИЗНЕС

*Эрчим хүч болон байгалийн баялгийг үргүй зарцуулдаг салбар*

### Яагаад салат Биг Макаас үнэтэй байдаг вэ?

Хүнсний үйлдвэрлэлд төрөөс олгодог татаас, 1995-2005



Эх сурвалж: Хариуцлагатай Анагаах ухааны төлөөх эмч нарын хороо, “Эрүүл мэнд үү, Гахайн мах уу: Конгресс аж ахуйн зардлын талаар хэлэлцэж байна, “Ээлтэй Анагаах ухаан, Боть XVI, 4, 2007. [www.pcrn.org/magazine/gm07autumn/health\\_pork.html](http://www.pcrn.org/magazine/gm07autumn/health_pork.html)

Махны үйлдвэрлэл бол хамгийн муу бизнес, гараг дэлхий болоод хүн төрөлхтөнд огтхон ч үр өгөөжгүй. Энэ нь ижил хэмжээтэй өөр хүнсээр орлуулах болох “хоол” гэгчийг үйлдвэрлэхэд эрчим хүч, ус, үр тарианы илүү их өртөг зардалтай, хамгийн үр ашиггүй бизнес. Бидэнд махнаас илүү дээр хүнс байна.

## ***Махны үйлдвэрлэл бол татвар ба татааснаас хараат салбар***

Жишээлбэл: хэрэв Засгийн газар аливаа тохиолдолд махны үйлдвэрлэлд ямар ч татаас өгдөггүй байсан бол, Энэтхэгийн ойг үгүй хийн байж үйлдвэрлэсэн зарим хүний иддэг гамбургер нь 200 америк долларын үнэтэй байх байсан!<sup>107</sup>

АНУ-д гахайн фермүүд гахайн ханиад гарахаас бүр өмнө тэрбум тэрбум долларын алдагдалтай ажиллаж байсан. Яагаад? Учир нь тэжээлийн үнэ өртөг өндөр учраас тэд малаа тэжээх үр тариа авч чаддаггүй байсан, одоо ч тэжээлийн үнэ улам л өссөөр байна. Тэгэхээр тэд яаж тэсэж үлдсэн байх вэ? Засгийн газар таны төлсөн татварын мөнгийг тэдэнд татаас болгож өгдөг. Тиймээс энэ нь утгаа алдагдалтай бизнес.

АНУ-аас авхуулаад Хятад гээд хаа сайгүй, Засгийн газар нь жил бүр хамгийн багадаа хэдэн арван тэрбум америк долларыг мал аж ахуй эрхлэгчдэд татаас болгон өгөх хэрэгтэй болдог!<sup>108</sup> Ингээд үзэхээр таны идэж байгаа зүйл бол таны мөнгө юм! Хэрэв та үүнийг идээд, эрүүл, аз жаргалтай байгаа бол байж болох л хэрэг. Гэтэл тийм биш!

## ***Махны үйлдвэрлэл эрүүл мэндэд маш их зардал гаргахад хүргэдэг***

Гамбургер хийхэд мал амьтны бүхий л эд эрхтнийг хэрэглэдэг бөгөөд та бүр аль нь юуных вэ гэдгийг ялгаж ч мэдэхгүй, бас бүх төрлийн өвчин, нянг агуулж байдаг.<sup>109</sup> Хэрэв та эрүүл мэндийн сэтгүүл, анагаах ухааны эрдэмтдээс лавлавал тэд танд үүнийг хэлээд өгнө. Бид их хэмжээний татварын мөнгөө зөвхөн махны үйлдвэрлэлийн татаасанд төлөөд зогсчихдоггүй. Бид бас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд, хайртай хүмүүсээ оршуулахад, тэднийгээ алдсандаа насаараа шаналах сэтгэлийн өвчин зовуурьтаа бүр ч илүү их татварын мөнгө төлдөг.

## ***Махны үйлдвэрлэл амьтдад маш их зовлон учруулдаг***

Бидний эмзэгхэн бие махбод энэ бүх зовлон шаналлыг давж туулах шаардлага уг нь байхгүй. Хэрэв бид махнаас зайлсхийвэл эмнэлэг, эм тарианд мөнгө зарахаас зайлсхийж чадна. Зөвхөн үүгээр зогсохгүй.

Биднийг эм тариа худалдан авахаас өмнө, ердөө л хүнд хэрэглэхэд аюулгүй гэдгийг мэдрэхийн тулд эмийг гаргаж авахдаа олон амьтан дээр туршилт хийж, бие рүү нь химийн бодис тарьж, өвтгөн зовоож, эцэс төгсгөлгүй тамладаг. Ийнхүү гаргаж авсан эмийг хүн хэрэглэхэд эрүүл мэндэд нь аюултай хэвээрээ л байна.

Энэ бүх зовлон шаналал, татварын мөнгө өөр өөр чиглэлд урсаж байна. Үнэндээ танд ямар ч тус болохгүй. Энэ нь ердөө нөөц баялаг, хөрөнгө мөнгө, үндэсний чадавх, хүний эрүүл мэнд, аз жаргалыг үрэн таран болгож байна. Зүгээр дэмий гарздаж байна. Энэ бол ердөө л маш муу, маш муу бизнес.

Махны үйлдвэрлэл хүний санаанд орохуйц бүхий л нөхцөл байдал, бүх талаараа бидэнд аймшигтай хор хөнөөл учруулж байна. Хэрэв тэднийг татаасаар дэмждэггүй байсан бол мал аж ахуй эрхлэгчид энэ бизнесээ үргэлжлүүлж чадахааргүй байдалд хүрнэ. Тэд энэ бизнесийг аль эрт орхих байсан. Тэгэхээр би амьтан үржүүлэх үйлдвэрлэлд ахин татаас өгөхгүй байхыг Засгийн газруудад санал болгож байна. Үүний оронд тэдэнд веган аж ахуй эрхэлж өөрчлөгдөхийг хэлж зааж өгье.

### ***Махны аж үйлдвэрт ажиллагсад байнга аюулд өртдөг***

Үүнээс гадна, махны бизнест ажиллаж буй ихэнх ажилчны хувьд ажлын байр нь маш аюултай байдаг. Энэ бол химийн бодис болон томуу, гахай, шувууны ханиад, үхрийн галзуу өвчин зэрэг ямагт аминд халтай өвчинд нэрвэгдэх, гэмтэх эрсдэл ихтэй ажлуудын нэг.

Одоо бид өөрсдөөсөө асуух хэрэгтэй: Энэ нь ийм их үнэ цэнээр хийх ажил мөн үү? Мах хэрэглэгчдэд нөлөөлдөг хорт хавдар, чихрийн шижин, зүрхний өвчин зэрэг бүхий л өвчний тухай энд ярих нь илүүц биз. Таны мэддэг бараг бүх өвчин махнаас үүдэлтэй эсвэл махтай холбоотой. Аж төрөхөд илүү сайн сонголт байж байхад бусад хүнийг болоод өөрсдийг маань өвчлүүлж, залуугаараа үхэхэд хүргэдэг ажил мэргэжлийн оронд өөртөө болон бусдад эрүүл байхад нь тусалдаг ажлыг бид сонгохгүй юм гэж үү?

“Хүнсний үйлдвэрлэлийн хоол хүнс нь төлж дийлэхүйц хямд гэдэг нь маш том эндүүрэл, учир нь хүнсний үйлдвэрлэлийн өртөгт байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн талын зардлуудыг оруулж тооцоогүй байдаг. Бид бодит үнийг нь тооцож үзвэл өртөг өндөр байх төдийгүй өнөөгийн хүнсний үйлдвэрлэлийн тогтолцоо нь бидний болоод хойч үеийн маань нуруун дээр санхүүгийн цочирдмоор их дарамтыг үүрүүлдэг нь тодорхой болно.”<sup>110</sup>

## ***Маханд хориг тавих нь Эх Дэлхийгээ аврах цорын ганц арга зам***

Энэрэл нигүүлслийн улмаас хийсэн бүх зүйл танд сайн бөгөөд Бурханы таалалд нийцэж байдаг. Энэ нь бас дэлхийг аварна. Энэ нь зөвхөн сайн бизнес байгаад зогсохгүй дэлхийг ч аварна, одоо болон ирээдүйд тоо томшгүй олон төрөлтнийг, махны бизнес эрхлэгчдийг хүртэл аварна. Тийм учраас л Бурхан багш махны бизнесийг хүмүүсийн эрхэлж болохгүй таван бизнесийн нэг гэж айлдсан юм.

Махны бизнес бол муу бизнес. Энэ нь танд маш муу. Бусад дөрвөн муу бизнес бол: зэр зэвсгийн бизнес, хүний наймааны бизнес, согтууруулах болон хортой бодисын бизнес. Эдгээр бүх хор уршигтай бизнес та нарт одоо ч, ирээдүйд ч муу байх болно.

## **ОРГАНИК ГАЗАР ТАРИАЛАНГ УРАМШУУЛЖ, ДЭМЖИЖ, ТАТААС ӨГБЕ**

[Засгийн газар] фермерүүдийг тариалан эрхлэхэд урамшуулж, махны оронд хүнсний ногоо тарьж ургуулахыг нь дэмжиж татаас өгч болно шүү дээ. Тэд илүү их ургац хураах тусам илүү их татаас авдаг байх. Тэгээд фермерүүдэд газар дэлхийнхээ төлөө хамгийн тустай сайн ажлыг хийх болно гэдгийг тайлбарлаж өгөх хэрэгтэй.

Хэрэв амьтдыг зөнгөөр нь орхиод, мал үржүүлэхийн оронд хүмүүсийн хүнсэнд хэрэглэх ногоог тарьж ургуулбал тэд аугаа их үйлстэн, дэлхийг аврагчид болно. Амьтад жам ёсоороо Диваажин луугаа буцах хүртэл нь тэдэнд сайхан сэтгэлээр хандаж байх ёстой гэдгийг Засгийн газар нь фермерүүдэд хэлэх хэрэгтэй.

Одоогийн байдлаар энэ туршлага төдийлөн дэлгэрээгүй, Засгийн газар, хэвлэл мэдээллийн зүгээс дэмжлэг аваагүй байна. Тэгэхээр миний даруухан бодлоор, Засгийн газар нь маханд мөнгөө алдаж буй, эсвэл мах нь өвчин, бас бус зүйлээр хордон муудсанаас болж алдагдал хүлээж байгаа фермерүүдэд татаас өгөхийн оронд тариаланчдад хөл дээрээ зогсох, үйл ажиллагаа нь илүү тогтворжих, зах зээл дээр органик хүнсний эрэлт бий болох хүртэл татаас өгч санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд болно. Тэгвэл фермерүүд хүн төрөлтөн, гараг дэлхийнхээ эрүүл энхийн төлөө ногоон хүнсийг илүү их тарьж нийлүүлэхдээ баяртай байх болно.

Засгийн газар тэднийг хүнсний ногооны үрээр хангаж, химийн бордоо хэрэглэхгүйгээр тариалалтаа эрхлэх шилдэг аргуудаас зааж сургаж болно, учир нь зарим тохиолдолд газар тариалан эрхлэгч нар мал үржүүлэхийн хор хөнөөл, химийн бодис, бордоо, шавж устгагч хорны талаар сайн ойлголт мэдээлэлгүй байдаг.

[Фермерүүд] ногоог илүү үр дүнтэй тарих, илүү их ашиг олох арга замын талаар мэдээлэлгүй байдаг. Засгийн газар тэдэнд хөрсөө хамгаалж,

бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь тусалбал худалдан авагчид тэдэнд илүү итгэнэ. Түүнчлэн Засгийн газар нь органик, веган аж үйлдвэрлэлийг дэмжихийн тулд чанарын стандартын системийг нэвтрүүлж, гэрчилгээжүүлж болно.

## ***Органик газар тариаланг хэрэгжүүлэхэд хялбар***

Яг одоо органик хүнсийг маш их сонирхож байна. Тэгээд энэ нь хүн бүрийн эрүүл мэндэд маш сайн нөлөөтэй. Бас маш өндөр эрэлт хэрэгцээтэй.

Манай Нийгэмлэгийн маш олон гишүүн органик газар тариалан эрхэлдэг. Тэгээд үүнийг хэн ч эрхэлж чадна гэдэг нь батлагдсан. Энэ талаар сонирхсон хэн ч бай манай цахим хуудсанд хандаад, органик газар тариалан эрхлэх тухай бүхий л мэдээллийг авч болно. Энэ нь их хялбар, энгийн, үнэндээ их ус ч шаардахгүй. Тэгээд хүнс нь маш хурдан ургадаг, бүр нэг хоёрхон хүн ч асуудалгүйгээр олон га талбайг тордоод авч явж чадна.

Бид хүмүүст органик газар тариалан эрхэл гээд борооны ус, гүний усыг нөөцлөх, хөрсийг хамгаалах, бороо оруулахын тулд мод тарих зэргийг хэлж өгдөг. Энэтхэгийн Ражастаны Алвар дүүргийн нэгэн тосгоныхон усаа сайн зохицуулснаар ус хэтрүүлэн хэрэглэснээс болж хатсан таван голыг буцааж сэргээсэн байна. Бид тэднээс суралцаж болох юм.

Энэ талаар сонирхсон хүн бүрд мэдээлэл хүргэхэд чиглэсэн [www.SupremeMasterTV.com](http://www.SupremeMasterTV.com) бидэнд байна. Органик хүнс тариалахад тийм их хөрөнгө мөнгө шаардагдахгүй. Хөрөнгө шаардлагатай гэвэл Засгийн газар хор хөнөөлтэй махны үйлдвэрлэлийг дэмжихийн оронд органик ферм эрхлэгчдэд туслан татаас өгвөл зохино. Органик фермийг дэмжиж туслах нь ферм эрхлэгчид төдийгүй хүн бүрд тустай.

## ***Сургуулиудад веган хоол нийлүүлж, орон нутгийн хүнсний компаниудыг дэмжье***

Миний ойлгосноор сургуулийг фермерүүдтэй тогтвортой холбох цогц системийг бий болгосон боловч хараахан бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Анх Европ болон Японд хэрэгжиж байсан энэ хөтөлбөр одоо АНУ-д дэлгэрч байгаа бөгөөд үүнд хүнсний нөхөрлөлүүд буюу бүлэг хүмүүс шинэхэн бүтээгдэхүүн нийлүүлэхийг зөвшөөрсөн фермерүүдтэй холбоо тогтоож тэгээд фермерүүд нь төрөл бүрийн ногоо тарьж, хүмүүс тэднээс олон төрлийн шинэхэн ногоог худалдан авдаг байна.

Энэ санаачилга газар авч, ихэнх газарт хүнсний ногоо худалдан авах хүлээлгийн жагсаалттай болжээ. Тиймдээ ч эдгээр аж ахуй ихэвчлэн

тогтвортой ажиллагаатай органик аж ахуйнууд юм. Хүмүүс итгэж болох эрүүл хүнсээ авахын зэрэгцээ фермерүүдийн амьжиргаа дээшилж, байгаль орчноо ч дэмжиж байгаа тул энэ бол сайн туршлага юм.

Хэрэв Засгийн газрууд органик газар тариаланг дэмжвэл энэ нь хоромхон зуур голлох чиг хандлага болж дэлгэрнэ гэдэгт би итгэлтэй байна.

Засгийн газрууд үүнийг байгаль, эх дэлхийгээ хамгаалах арга зам болохыг ухуулангаа манлайлан залж өгвөл газар тариалан эрхлэгчид баяр хөөртэйгөөр илүү их веган хүнсийг тарьж ургуулах болно.

Органик газар тариалангийн туршлагыг дэлгэрүүлэх нь маш олон талаар ач тустай.

## **ОРГАНИК ВЕГАН АЖ АХУЙН АЧ ТУС**

Хүмүүсийн амьжиргаа, хүн ба амьтдын эрүүл мэнд, байгалийн нөөц, манай дэлхийг хамгаалахад органик фермийн үзүүлэх ач тусыг бид дутуу үнэлж болохгүй, тэр ч бүү хэл бид бүгдийг нь тооцож ч чадахгүй. Органик ферм нь зөвхөн дэлхийг хамгаалаад зогсохгүй, өлсгөлөнг арилгахад ч нөлөөлнө.

Уламжлалт, органик газар тариалан эрхлэх арга туршлагыг сэргээснээр амжилт олох нь Африк болон Америк, Европ, Австралийн зарим бүс нутаг дахь хэрэгжилтийн үр дүнгээр нотлогдсон билээ. Органик веган аж ахуй нь өдгөө маш хурдтай дэлгэрч буй бөгөөд эрэлт хэрэгцээ нь өсөн нэмэгдэж буй тул тун ашигтай байгаа. Хүмүүс махны хор уршиг, ургамлын хоолны ач тусын талаар илүү их мэдээлэл авсан байна. Тэгэхээр органик ногооны ферм нь хүссэн бүхэнд маш их тустай бизнес юм.

Түүнчлэн, органик газар тариаланг Африк тивийн олон оронд амжилттай эрхэлж байгаа түүх олон бий. Жишээлбэл: Өмнөд Африкийн Кейп Таун хотын захаар байрлах жижиг суурингийн оршин суугчид 100 хувь органик тариалан эрхэлж, орон нутгийн зах зээлд худалдаалж байна.<sup>111</sup> Кенид үүнтэй төстэй үйл ажиллагааг эхэлжээ. Угандад саяхан органик бордоог нэвтрүүлсэн нь хөрсөнд сайн, ургац арвин авах нь хэдийнээ илэрхий болсон байна.<sup>112</sup>

Мөн Суприм Мастер Телевиз болон [www.SupremeMasterTV.com](http://www.SupremeMasterTV.com) цахим хуудсаар бид органик аж ахуйн тухай цогц нэвтрүүлгийг цацдаг. Тус цахим хуудсанд бид үнэхээр ашигтай, усанд хэмнэлттэй, ажиллагаа багатай, ажилтнуудад болон манай гараг, бидний эрүүл мэндэд ч тустай органик фермийг хэрхэн эрхлэх тухай арвин мэдээллийг байрлуулан түгээдэг.



Хэрвээ та органик ногоо идвэл эмнэлэгт очих шаардлага бараг гарахгүй. Бид бүх мөнгөө хойч үедээ илүү сайн боловсрол олгох, өндөр настуудаа сайн халамжлах, сайхан зам барих, шинэ тоног төхөөрөмж, нээлт бүтээл гаргах, үүнийгээ хүн бүрд үнэгүй хүртээх сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд зориулж болно. Хүн бүрийг үнэгүй эрчим хүчээр, хүүхэд бүрийг үнэгүй боловсролоор, бүх өндөр настанг үнэгүй халамжаар, нэг-тэрбум хүнийг, ядаж л дэлхий дээрх бүх өлсгөлөн хүнийг үнэгүй хоолоор хангах боломжтой болно. Хэмжээ хязгааргүй ач тустай.

## ***Тогтвортой байдал ба арвин ургац***

**Органик газар тариаланг далайцтай эрхэлж эхэлбэл дэлхийн хүн амыг бүхэлд нь тэжээх боломжтой гэсэн судалгааны үр дүн байдаг. Өмнө нь дутуу ашиглаж байсан газарт органик газар тариалан эрхлэн илүү их ургац авсныг Дани болон бусад оронд хийсэн судалгаа харуулсан байна.<sup>113</sup>**

Үнэндээ уламжлалт газар тариалангаас авсан их ургац нь хөрс, бидний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг тооцвол өндөр өртөгөөр бий болдог. Асар их хэмжээний шар буурцаг гэх мэт ургамлыг хүний хэрэглээнд бус ихэвчлэн махны үйлдвэрлэлд хэрэглэх мал амьтныг тэжээхэд зориулж тариалдаг байна.

НҮБ-ын Хүрээлэн буй орчны Хөтөлбөрөөр Африкт хийсэн судалгаагаар органик тариалангийн арга технологи хэрэглэсэн жижиг фермерүүд хоёр дахин их ургац авч байгааг илрүүлжээ.<sup>114</sup> Энэ тохиолдолд, байгалийн аргаар хөрсийг бордох, сэлгэж тарих зэрэг органик аргууд хөрсийг сайжруулж байгаа учраас органик аж ахуй эрхлэгчид мөнгөө химийн бордоо, пестицид авахад биш харин сайн үр худалдан авахад зориулах боломжтой юм.

АНУ-д хийсэн өөр нэг судалгаагаар ургацыг гурав дахин нэмэхэд органик тариалангийн аргуудыг хэрэглэж болохыг илрүүлжээ. Ийм их ургац авах боломж олгох гол хүчин зүйлсийн нэг нь тариаланчид арвин ургац авахын тулд вандуй, шар буурцаг гэх мэт шошийн төрлийн ургамал тарих, улирал сэлгэх завсарт уриншлах, хучих зэргээр ажиллан хөрсийг байгалийн азотоор баяжуулдагт оршиж байв.<sup>115</sup>

Дэлхийн хүнсний хомсдол улам даамжран, хүмүүс өдөр бүр улам олноороо өлсгөлөн явах болсон энэ үед бид мал үржүүлдгээ зогсоовол, малын тэжээлд эрдэнэ шиш, амуу тариа, ногоог бүгдийг хэрэглэдгээ боливол, яг одоо бидний үйлдвэрлэж байгаа энэ бүх хүнсээр хэдийнээ хоёр тэрбум хүнийг хооллох боломжтой.

## ***Пестицид болон бордооны хэрэглээг бууруулдаг***

[Органик газар тариалан] нь энэ дэлхийн бүх төрөлтөн, амьтан, мод, газар шороонд хүртэл ач тустай. Учир нь АНУ-ын Хүрээлэн буй орчныг Хамгаалах Газар, Европын Холбооны тодорхойлсноор хорт хавдар үүсгэдэг, зөгийг устгадаг, мөн бидний нэрлэж ч мэдэхгүй бусад олон амьтныг хөнөөдөг химийн бордоо, пестицидийг хэрэглэдэггүйтэй зарим талаар холбоотой байна.

АНУ-ын нэгэн судалгаанд хэрэв АНУ-ын аж ахуйн 3 сая га (8 сая акр) газрыг органик болговол хоол хүнсээр дамжуулан пестицидээс хордлого авах эрсдэл 97 хувиар буурна гэжээ. Та төсөөлж байна уу? Химийн бордоо, пестицидийн хаягдал нь мөн далайд үхмэл бүс бий болоход нөлөөлдөг байна. Бид пестицид болон химийн бордоогоор гараг дэлхийгээ хөнөөж байна.<sup>116</sup>

Дэлхий даяар жилд 2.3 тэрбум гаруй кг (5 тэрбум гаруй фунт) пестицидийг хэрэглэж байна! Эдгээр химийн бодисын ердөө 10 хувь нь л зориулалтын газартаа хүрч очдог. Үлдсэн нь агаар, усанд шингэж, хүн ба амьтныг хорт хавдраар өвчлүүлэхэд хүргэхээс авхуулаад далайн үхмэл бүс үүсэхэд хүртэл нөлөөлж байна.

Нэгэн төрлийн пестицид тив даяар зөгийг тэрбумаар нь мөхөлд хүргэх шалтгаан болсныг Европт илрүүлсэн бол пестицидийн бусад төрөл нь шувууны өндөгний хальсыг нимгэрүүлэхэд нөлөөлж, улмаар хальс нь ангаахай мэндлэх цаг болоогүй байхад хагарч цуурч тэднийг эндэхэд хүргэдэг байна.<sup>117</sup>

Түүнчлэн, органик үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нь генетикийн өөрчлөлттэй организмаас ангид, шим тэжээлийн агууламжаараа хэвшмэл аргаар ургуулсан жимс, ногооноос өндөр байдаг.

## ***Хүрээлэн буй орчин болон хөрсийг сайжруулдаг***

**Хэрэв бүх хүн, бүх аж ахуй эрхлэгч, манай дэлхийн тариалан эрхэлж болох талбайд веган аж ахуйн аргыг нэвтрүүлбэл, уг аргаар ургуулсан ногоон ургамал CO<sub>2</sub>-ийн 40 хувийг тэр даруй шингээн авна.**<sup>118</sup>

Органик аж ахуйд шилжих нь уламжлалт тариалан эрхлээд доройтсон хөрсний чанарыг сэргээнэ. Дээд давхаргын өнгөн хөрс нь бэхжиж, үер болон хар салхийг илүү сайн давж гарах чадвартай болно. Онгон байгаль, экосистемд ч эерэг нөлөөтэй. Их Британид органик аж ахуйн талаар хийсэн томоохон судалгаанаас үзэхэд уламжлалт аж ахуйтай харьцуулахад органик тариалангийн талбайд ургадаг ургамлын төрөл зүйл 85 хувиар илүү, шивээ нь 71 хувиар өндөр, бүдүүн, нутгийн бүх төрөл зүйлийн ан амьтад эргэн эрүүлжин нутагшсан байна.<sup>119</sup>

Түүнчлэн, органик веган аж ахуй нь далайн үхмэл бүсийг бий

болгож буй химийн бордооны урсацыг зогсооно.

### ***Эрчим хүч болон байгалийн нөөцийг хэмнэдэг***

Органик, веган аж ахуй нь уламжлалт аж ахуйн аргатай харьцуулахад эрчим хүчийг 37 хувиар, усыг үүнээс ч илүү хэмнэдгээрээ үр бүтээлтэй.<sup>120</sup>

### ***Засгийн газарт мөнгө хэмнэж өгдөг***

Органик хүнсний ногооны аж ахуйд өгөх татаас мал амьтны аж ахуйг тасалдуулахгүй явуулах, дампуурахаас хамгаалахад шаардагддаг татаастай харьцуулбал хавьгүй бага байдаг.

**Органик веган аж ахуй Засгийн газарт маш их хэмжээний мөнгийг, 80 хувийг нь хэмнэж өгч чадна.**<sup>121</sup>

Татварын бүх мөнгийг бидэнд буцаан өгч байна, эсвэл түүнийг хүлэмжийн хийг бууруулах гэх мэт илүү сайн үйл хэрэгт зориулж байна гээд төсөөлөөд үз дээ.

### ***Аж ахуй эрхлэгчдэд ашигтай байх болно***

Латин Америкт органик ногоо тариалж эхэлсэн жижиг фермерүүдийн дунд хийсэн судалгаанаас үзэхэд тэд урьд өмнөхөөсөө илүү орлого олсон байна.<sup>122</sup> Хэрэв дэлхий нийтээрээ веган болбол Засгийн газрууд хэдэн арван их наяд америк доллар хэмнэж чадна хэмээн Голландын нэрт эрдэмтэн хэлжээ.<sup>123</sup>

Мөн АНУ, Энэтхэг, Шинэ Зеландад хийсэн хэд хэдэн судалгаа бидэнд байна. Бүгд л дээрхийг баглан, органик газар тариалангийн их ашиг олж буй гол шалтгаан бол үйлдвэрлэлийн зардал нь уламжлалт газар тариалангаас доогуур байдагт оршино гэжээ.

Эрдэнэ шиш, шар буурцаг, таримал царгас гэх мэт олон янзын үр тариаг ээлжлэн тарих боломжтой. Түүнчлэн, органик тогтолцоо нь уламжлалт тариалангийн тогтолцоог бодвол ган гачигт илүү тэсвэртэй байдаг.

### ***Хүнсний аюулгүй байдал, эрүүл мэнд сайжирна***

Органик хүнс нь хорт бодис агуулаагүй, шим тэжээлээр баялаг, генийн өөрчлөлтгүй, хорт хавдар үүсгэгч пестицид агуулаагүй тул эцэст нь бид бүгд илүү эрүүл саруул байхын ашиг тусыг хүртэнэ. Амьтны гаралтай бүтээгдэхүүн нь хорт хавдар, зүрхний өвчин, чихрийн

шижин, хэт таргалалт гэх мэт өвчнийг үүсгэдэг байхад органик аргаар ургуулсан жимс, ногоо нь орчин үеийн энэ бүх асуудлаас зайлсхийх шим тэжээлээр хангалттай баялаг билээ. Мэдээж органик, веган хүнс нь бидний аюулгүй гэж үзвэл зохих, аюулгүй болохыг нь мэдрэх, цаашдаа ч аюулгүй байх цорын ганц хүнс. Үнэндээ энэ бол бидний үр хүүхдэдээ өгч чадах хамгийн аюулгүй, хамгийн сайн хүнс юм.

[Органик хүнсний] шим тэжээлийн агууламж нь яг үнэндээ уламжлалт аргаар ургуулсан жимс, ногооноос илүү өндөр. Энэ шалтгаанаар л манай бүлгэмийнхэн боломжоороо органик бүтээгдэхүүнийг аль болох илүүхэн хэрэглэдэг.



*Цэцэрлэгч хүүгийн гэртээ тариалж, хураасан органик жимс*

## **МАХНЫ ҮЙЛДВЭРИЙН АЖИЛТНУУДАД ӨӨР АЖИЛД ШИЛЖИХЭД НЬ ТУСАЛЬЯ**

[Махны үйлдвэрийн ажилтнуудад] өөр ажил хий гэж хэлье, тэдэнд хийх өөр шинэ ажил өгье, тэдэнд цоо эрүүл, эрч хүч, амар амгалан, хайр энэрэл, аз жаргалаар дүүрэн шинэ амьдралын ач тусыг тайлбарлаж өгье. Хүн бүр үүнийг хүсэх болно. Тэд ядаж л хийгээд үзэг л дээ. Нэгэнт туршчихвал үр дүнг нь мэдэх болно. Тэгээд хэрэв хүн бүр үүнийг хийж байгааг үзвэл хөршүүд нь мөн дуурайна, тэдний найзууд мөн хийж үзэх болно, тэгээд энэхүү нэг нэгнээ дэмжсэн эерэг эрч хүчээр бүх дэлхий өөрчлөгдөнө.

[Мал] үржүүлгийг бүрмөсөн зогсоох хэрэгтэй. Амьтны амь хөнөөх талаар бүр ч дурдалтгүй, бид энэ бүгдийг зогсоох ёстой. Энэ дэлхийг аварья гэвэл мал өсгөх, үржүүлэх, амь зуухын тулд тэднийг нядлахаа зогсоож байж л тэд үүнийг хийж чадна. Хэрэв засгийн газрууд иргэддээ амьдралаа залгуулах бусад боломжит хувилбаруудыг гаргаж өгөн, тайлбарлахад хүч чадал, эрх мэдлээ бодитоор хэрэглэвэл тэд ойлгох болно. Тэдэнд тайлбарлая, хэрэгтэй татаасыг нь олгоё, өөр ажил төрөл,

эсвэл өөр сонголтыг өгье. Бидэнд сонголтууд байна.

Би тэдэнд [махны үйлдвэрлэл эрхлэгч] гахай, үхрээ гэрийн тэжээмэл амьтнаа болгон үлдээхийг санал болгож байна. Хэрвээ малын тоо толгой үргэлжлэн нэмэгдсээр байвал эргээд яг одооных шиг, эсвэл үүнээс ч дор нөхцөл үүсэж мэдэх тул тоо толгойг хэт олшруулахгүйн тулд [малын] үрийн сувгийг боолгох нь зүйтэй гэж би бодож байна.

Өнөө үед аж ахуй эрхлэгчид, жижиглэнгийн худалдаачид, тээвэрлэгчдэд илүү таатай боломж олноороо байна. Тэд хийдэг ажлаа л хийнэ, гэхдээ гахай тээвэрлэхийн оронд органик ногоо гэх мэт өөр зүйл тээвэрлэнэ. Эсвэл жижиглэнгийн худалдаачин махны бизнесээ органик ногооны аж ахуй болгон өөрчилж болно.

### Ш. МАЛ АМЬТНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧИД ӨӨР АЖИЛ МЭРГЭЖИЛД АМЖИЛТТАЙ ШИЛЖИХ НЬ

#### *Америкийн Нэгдсэн Улсад*

Их олон гахайг бохир заваан үйлдвэрийн орчинд хашдаг нэгэн Америк фермер байсан. Веган чиглэлээр замнахын тулд ааваасаа өв залгамжлан авсан олон сая долларын орлоготой, мөхөөлдөс хийдэг бизнесээ орхиж веган хоолтон болсон алдарт зохиолч Жон Роббинс тэр гахайн аж ахуйд зочилжээ. Түүнийг зочилсны дараа тэр гахайн фермийн эзэн нь гэнэт хүүхэд насандаа нэг гахайг дотно найз шигээ маш их хайрладаг байснаа санасан бөгөөд харин нийгэм болон гэр бүлийн дарамт шахалтаар тэрээр хайрын мэдрэмжээ хүчээр дарж мартахад хүрсэн ажээ.<sup>124</sup>

Тэр үүнийг ухаарсныхаа дараа номхон дөлгөөн гахайнууддаа ахиж нэг секунд ч зүй бус харьцаж чадаагүй байна. Тэрээр энэ ажлаа орхихоор шийдэв. Тэгээд гахай үржүүлэхийн оронд тэр жижигхэн органик аж ахуй худалдаж авч, органик ногоо зардаг болоод, эдүгээ дажгүй сайн байгаа. Тэр одоо ч амьд байгаа. Мөн түүний зүрх сэтгэл нь хэзээ хэзээнээс илүү сайн байгаа.

Өөр бас нэг хүн хуучин фермээсээ үлдсэн 10 гахайг гэршүүлж, хүүхдүүдийг гахайн мах иддэггүй болгохын тулд үе үе сургуулиудаар явж гахай үнэндээ ямар ухаалаг, найрсаг болохыг хүүхдүүдэд харуулдаг. Тэр гахай үржүүлэхээ зогсоосноор барахгүй, харин ч амьтдыг хамгаалж байна.

Үхрийн маш том аж ахуй эзэмшдэг нэгэн байжээ. Гэвч махнаас үүдэн хорт хавдар туссанаас болж гэнэтхэн өөрчлөгдсөн байна. Тэр өөрийгөө [хорт хавдраа] эмчилснийхээ дараа веган хоолтон болсон бөгөөд одоо амьтан хамгаалагчаар ажиллаж байна. Тэр хаа сайгүй явж хүмүүст мал амьтан өсгөн үржүүлэх муу бизнес, харгислалын талаарх

жинхэнэ үнэнийг ярьж, лекц уншдаг. Тэрээр амьтан хамгаалахад тун тууштай зүтгэсээр байна. Түүнийг Ховард Лимен гэдэг. Тэр Суприм Мастер Телевизэд нэг хоёр удаа уригдан ярилцлага өгч байсан билээ.

## ***Ойрх Дорнод***

Саяхан Иранд сүүний чиглэлийн үнээний аж ахуй эрхлэгч нэгэн байсан— тэр бүр бидэнд өөрийнхөө түүхийг бичсэн захидал ирүүлсэн шүү— гараг дэлхийдээ болон дотоод ухамсартаа туслахын тулд ажил мэргэжлээ солих хэрэгтэйгээ ойлгож шийдвэр гаргасан байна. Тэгээд өмчдөө байсан үнээнүүдээ үлдсэн амьдралаа аюулгүй, сайхан өнгөрүүлж чадах айл, орон гэр олж өгч үрчлүүлжээ. Одоо тэр веган хоолны зоогийн газарт ажилладаг.

## ***Азид***

Бас нэг түүх Формосагаас (Тайванаас) ирсэн. Нэгэн гахайн фермер Суприм Мастер ТВ-ийг үзээд, байгаль орчноо хамгаалахыг, мөн өөрийгөө болон гэр бүлийнхнээ муу үйлийн үрийн шийтгэлээс сэргийлэхийг хүсэж байгаагаа ухамсарлан веган болсон байсан. Тэгээд тэр одоо бүх гахайгаа насан туршид нь гэрийнхээ эрх тэжээвэр амьтад болгожээ. Мөн тэр өөр төрлийн аж ахуй эрхлэхээр өөрчлөлт хийж байгаа.

Эдгээр жишээнд дурдсан хүмүүсийн ажил үйлс нь эдүгээ сайн төдийгүй өмнө байснаасаа маш их дээрдсэн. Бүхий л амьдрал ажил мэргэжлээ бүрмөсөн өөрчлөхөд тэднээс эхлээд маш их эр зориг шаардсан, гэвч үүний ашиг тус гарсан бөгөөд илүү зөв шийдэл байсныг тэд бүгд батлан өгүүлнэ. Энэ бүхэн тэдэнд зүрх сэтгэлийн, сүнсний агуу их эрх чөлөө, гэр бүлийн аз жаргал, эрүүл мэндийг бэлэглэсэн билээ.

## **IV. САЙН ЗАСАГЛАЛЫН ЖИШЭЭ**

### ***Европын Холбоо***

Дэлхийн дулаарлын шалтгаан нь махны хэрэглээ гэдгийг Европын Парламент хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд тэд махны үйлдвэрлэлд зарцуулдаг татаасыг зогсоох, оронд нь органик газар тариалан эрхлэгч зэрэгт олгох талаар дахин хэлэлцэхээр болжээ.<sup>125</sup>

Хэдийгээр миний хүссэн хурдаар биш ч дэвшил гарч байгаа болохоор үүнд анхаарсан олон түмний зүгээс ямар нэгэн зүйл хийж буй нь харагдаж байна. Зарим эрэлхэг зоригтой, баатарлаг удирдагч өөрчлөлт хийхэд тусалж байгаа нь үнэхээр сэтгэл хөдөлгөж, урам өгч байна.

Мөн Европын Парламентын гишүүн Женс Холм хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахын тулд махыг багасгахыг санал болгосон арга хэмжээнүүдийг Европын Холбоогоор зөвшөөрүүлэхээр ажиллаж байна.<sup>126</sup>

## ***Герман улс***

Европ уруу экспортлох мах үйлдвэрлэх гэж ой модыг огтолж устгахаас сэргийлэх илүү чанга дүрэм журам тогтооход нь туслахаар Германы Байгаль орчны сайд Бразилд айлчилсан байна.

## ***Ирланд улс***

Яг одоо органик газар тариаланд шилжиж байгаа олон хүн байна. Ирландын Хөдөө аж ахуйн сайд Ирландын аж ахуй эрхлэгчдэд органик ногооны аж ахуй уруу шилжихийг зөвлөж захиа илгээсэн төдийгүй бүр Засгийн газраас тэдэнд татаас олгохоо илэрхийлжээ. Яг одоо тэндхийн аж ахуй эрхлэгчдийн ихэнх нь органик газар тариаланд шилжиж байна.

## ***Бельги улс***

Бельгийн хамгийн том хотуудын нэг Гэнт хотод Пүрэв гаргийг зөвхөн веган хоолны өдөр болгосноо албан ёсоор зарласан бөгөөд энэ хичээлийн жилээс эхлэн хотын бүх сургуульд Пүрэв гараг болгонд ургамлан хоол идэх болжээ.<sup>127</sup>

## ***Их Британид***

Эрхэмсэг Хунтайж Чарльз байгаль орчны төлөө дуу хоолойгоо шударгаар, тод томруун хүргэж байгаа зүрх зориг, эрэлхэг байдалд би талархдаг. Би түүнийг үнэхээр их хүндэтгэн ёсолж байна. Тэр хөдөлмөрч төдийгүй цаг үеэсээ түрүүлэгч нэгэн билээ.

Жишээлбэл: тэр органик бүтээгдэхүүний дэлгүүр нээсэн. Бас дэлхийн ширэнгэн ойг огтлох ажиллагааг зогсоохын төлөө маш шаргуу хичээн зүтгэж байгаа.

Түүнчлэн Хунтайж Чарльз нь тээврийн хэрэгслээр зорчих зэрэгт нүүрстөрөгчийн ул мөрөө багасгахыг хичээж байна. Тэр мөн ой модыг хамгаалах ажилд зориулж 2.8 тэрбум буюу бараг 3 тэрбум америк долларыг хөрөнгөөсөө хандивлажээ.<sup>128</sup>

Манлайлал болон ирээдүйд хүлэмжийн хийн ялгарал багатай улс орон болохын тулд хийж буй бүх төслийнх нь төлөө би Их Британийн Засгийн газрыг даруухнаар магтан сайшаая.

Энэ улсын Засгийн газраас байгальд ээлтэй хүнсний бодлого хэрэгжүүлж байгааг чухалчлан цохон тэмдэглэмээр байна. 2008 оны 7 дугаар сард Ерөнхий сайд Гордон Брауны санаачилгаар Их Британийн хүнсний бодлогод хийсэн үнэлгээний тайланд “эрүүл, сөрөг үр нөлөө багатай хоолны дэглэмд байх мах, сүүн бүтээгдэхүүн нь өнөөдөр бидний хэрэглэж байгаагаас улам багасна.” хэмээн дурдсан байна.<sup>129</sup>

Түүнээс хойш өнөөг хүртэл Уур амьсгалын өөрчлөлтийн хороо болон Үндэсний эрүүл мэндийн үйлчилгээний зөвлөх Профессор Тим Лан шиг хүмүүс мөнхүү үзэл санааг Их Британийн Засгийн газарт дэвшүүлсээр иржээ.<sup>130</sup> Засгийн газар “Сайн газар тариалангийн дүрэм” нэртэй удирдамж гаргах зэргээр аж ахуй эрхлэгч нартаа байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулахад нь тусалж байна.<sup>131</sup>

Түүнчлэн Их Британийн Байгаль орчин, Хүнс, Хөдөө орон нутгийн хэргийг хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга Хилари Бэнн, Парламентын гишүүн Девид Дриу, Европын Холбооны Парламентын Дэд Ерөнхийлөгч Эдвард Мак Миллан зэрэг олон манлайлагч ургамалд суурилсан хүнсэнд шилжсэн буюу байнга сурталчлан дэмждэг. Энэ нь зөв зүгт явж буйн сайн дохио бөгөөд бүх улс орон Их Британийн үлгэр жишээг авч, ашиг тусыг нь хүртэх боломжтой юм.

Засгийн газрууд урьд хожид байгаагүйгээр зоримог байх хэрэгтэй. Их Британийн Засгийн газар гараг дэлхийгээ аврах энэ арга замыг манлайлна гэж би найдаж байна. Их Британи энэ тал дээр дэлхийг тэргүүлнэ гэж найдаж байна. Товчоор хэлбэл, Их Британийн энхийн төлөөх, бүтээн байгуулалтад туслах, ургамалд суурилсан энэрэнгүй амьдралын хэв маягийг дэмжих бодлого, ногоон хөгжлийн төслүүд хамгийн шилдэг нь бөгөөд тус Засгийн газар энэ талаарх олон ажлыг санаачлан хэрэгжүүлж чадна.

## *Америкийн Нэгдсэн Улс*

АНУ-д Хавайн Парламент болон Сенат Хавайн сургуулиудад веган болон цагаан хоолны сонголттой байх шийдвэрийг санал нэгтгэжээ гаргасан байна.<sup>132</sup>

Уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох шинэ төлөвлөгөөнийхөө хүрээнд Цинцинати, Охайо хотууд дэлхийн дулаарлыг зогсоох зорилгоор махны хэрэглээг багасгахыг дэмжсэн АНУ-ын анхны хот боллоо.<sup>133</sup>

Төрийн зүтгэлтнүүд вегетарианзмын ач тусын талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боллоо. Жишээлбэл: энэ зун АНУ-ын конгрессийн гишүүн, веган хоолтон Деннис Кусинич нь Калифорни мужид цагаан хоолтон болон бусад хүмүүст зориулж хамгийн анх удаа Дэлхийн Веган хоолны өдрийг баталсан.<sup>134</sup>

АНУ-ын Мериланд мужид амьдралынхаа туршид махан хоолтон байсан Сенатор Жэйми Раскин байгаль орчиндоо туслахаар [2009 оны] 4



дүгээр сарын эхээр цагаан хоолны долоон хоногийг санаачилсан. Тэрээр тус өдрөөс эхлэн цагаан хоолтон болж, 9 дүгээр сард болох үндэсний Веган Баяр наадамд (VegFest) үг хэлнэ. Сайн мэдээ байгаа биз.<sup>135</sup>

[Балтимор хотын төрийн өмчийн сургуулиудад 2009 онд махгүй Даваа гаргийг зарласан.<sup>136</sup>]

[2010 оны 4 дүгээр сард Сан-Франциско нь веган хоолны өдрийг зарласан АНУ-ын анхны хот болсон. Сан-Франциско хотын хяналтын албаны хүмүүс ресторан, хүнсний дэлгүүр, сургуулиуд Даваа гарагт махгүй бүтээгдэхүүнээр үйлчлэхийг дэмжин урамшуулах шийдвэрийг санал нэгтгэй баталсан.<sup>137</sup>]

[АНУ-ын Боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн хорооноос Сургуулийн Үдийн цайны хөтөлбөрийг баталж, үүнд Органик Веган хоолны туршилтын хөтөлбөрүүдийг оруулсан байна.]

## **Формоса (Тайвань)**

Формосад, ерөнхийлөгч Ма Инг-Жоу хүлэмжийн хийг бууруулахад хүмүүсийн хийж чадах, амьдралын хэв маягийн хамгийн чухал өөрчлөлтийн нэг бол ногоог түлхүү хэрэглэх, махны хэрэглээг багасгах юм гэж мэдэгджээ.

Улс төрийн удирдагчийн хувьд ийм зүйл хэлнэ гэдэг нь үнэхээр зоригтой бөгөөд үнэхээр том алхам билээ. Мөн түүний гэргий Формосагийн Тэргүүн Хатагтай нь дэлхийн дулаарлыг зогсоох, хүлэмжийн хийн ялгарлыг багасгахын тулд махаа бага, ногоо, жимсийг илүү их хэрэглэх тухай өгүүллийг хүүхдүүдэд уншиж, үлгэр жишээ үзүүлсэн байна.

Ерөнхийлөгч Ма Инг-Жоу болон ерөнхийлөгчийн албаныхан бүгдээрээ нүүрсхүчлийн хийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх тунхаглалд гарын үсэг зуржээ. Уг тунхаглалд орон нутгийн ногоог түлхүү хэрэглэж, махыг бага идэх тухай тусгасан байна.

Үүний үр дүнд, Формоса (Тайван)-гийн нэг сая гаруй хүн махны хэрэглээгээ багасгана гэж амлан, өргөх бичигт гарын үсгээ зуржээ.<sup>138</sup>

## **V. ОРГАНИК ВЕГАНИЗМ БОЛ БУРХАНЛАГ ХӨДӨЛГӨӨН**

Жижиг аж ахуй эрхлэгчид ч веганизмд бурханлаг үүрэг гүйцэтгэдэг. Веган хүнс хэрэглэх нь өөрөө бурханлаг хөдөлгөөн, яагаад гэвэл энэ нь хүн төрөлхтөнд энэрэл нигүүлсэл, эрхэм ариун чанар, хайрлах чанараа тэлэх цорын ганц хамгийн үр нөлөөтэй арга зам. Энэ нь харгислал хүчирхийлэл, муу үйлийн үрийн төлөөсийн орчлыг цуцалж чадна: “Та юу тарина түүнийгээ хурааж авна” гэдэг шүү дээ. Тэгээд биднийг материаллаг ертөнцийн ямарваа нэгэн сөрөг үйлээс хамгаалах хайр, өршөөл, хамгааллын хүрдэнд оруулдаг.

Тиймээс органик веган аж ахуй эрхлэгч нь байж болох хамгийн энэрэнгүй, бүр ямар ч харгислал, хүчирхийлэлгүй хоол хүнсээр бусдыг хангаснаараа тоолшгүй олон хүнд аугаа буян хураахад нь тусалдаг бөгөөд үүгээрээ тэд мэдээж өөртөө ч бас маш их сүнслэг буян хураадаг.

## ***Органик веган амьдралын хэв маяг нь Ахимса (Үл-хүчирхийлэх)-д нийцдэг***

Бид амьд байж, бусдыг амьдруулж, бас бүхий л төрөлтийг өөр шигээ хайрлах нь маш өндөр сүнслэг түвшинд буйн илрэл. Мэдээж, энэ нь дэлхийн бүхий л аугаа шашин шүтлэгт нийцнэ. Диваажингийн талархлыг ч маш их хүлээх болно. Ингэвэл бид бүхий л амьд оршихуйд хайр халамж, хүндэтгэлээ бүрэн зориулахад тусална.

Ийм учраас та амар амгаланг илүү мэдэрдэг юм, ойлгож байна уу? Та орчинтойгоо холбоотой гэдгээ илүү сайн мэдэрдэг, яагаад гэвэл тэд бүгд амьдрал, хайраар цохилж байдаг. Газар дэлхий хайр, амьдралаар бялхаж байдаг, мод, өвс ургамал бүгдээрээ л амьдралынхаа турш энэ бүх хайрыг цацруулдаг. Бид модны доор суухаараа модноос нөмөр нөөлөг, хайрыг мэдэрдэг. Бид жимсийг амтархан идэхдээ шим тэжээл, сайхан амтыг өгч буй модны энэ нөхцөл болзолгүй хайртай холбоотойгоо мэдэрдэг.

Хэрвээ та органик веган хандлагатай, эсвэл органик веган аж ахуй эрхлэх бол байгаль, гараг дэлхий, мод, өвс ургамлын навч, цэцгээс ч хайрыг улам л илүү мэдрэх болно. Амьсгалж буй агаараасаа маш их хайрыг мэдэрнэ. Дээр нь гишгэн алхаж буй газар шорооноосоо маш их хайрыг мэдэрнэ. Үүнийг хүний хэлээр тайлбарлахын аргагүй. Бид үүнийг заавал өөрөө мэдрэх хэрэгтэй. Би үүнийг байнга мэдэрдэг, гэвч би энэ бурханлаг илгээмжийг бусад хүнд дамжуулж өгч чадахгүй. Хүн бүр үүнийг өөрсдөө мэдрэх хэрэгтэй.

Бид энэ энэрэнгүй, тэнгэрлэг, веган амьдралын хэв маягт нэгэнт шилжсэн л бол цаг үргэлж хайрыг болон бусадтай холбоотой гэдгээ улам илүү мэдэрнэ. Ахимса нь ямар ч төрөлтөнд гэм хор учруулахгүй гэсэн утгатай бөгөөд энэ нь веган хүнс хэрэглэхээс эхэлдэг. Органик веган хоолны дэглэм бол хамгийн сайн. Бид юу тарина, түүнийгээ л хурааж авдаг. Бид газар дэлхийдээ мөн зүрх сэтгэлдээ эдгээр ариун буянтай үрийг суулган веган хоолтон болсноороо амьтны гаралтай бүхий л бүтээгдэхүүнээс зайлсхийж чадна.

Жишээлбэл: ихэнх сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зовлон шаналлыг бий болгодог, яагаад гэвэл наад зах нь тугалыг төрмөгц эхээс нь салгадаг. Үүнийг тийм ч олон хүн мэддэггүй, би ч мөн адил мэддэггүй байсан. Тэгээд төд удалгүй нялх тугалыг нядалдаг. Эхийнхээ сүү болон хайраас хагацсан тэднийг шууд л нядалдаг. Тэгээд хүмүүс зөвхөн сүүг нь авахын тулд үнээний дэлэнг маш их өвчин зовуурь авчирдаг саалтуур машинд хүчээр холбодог.

Органик веган аж ахуй нь хортон шавж устгах бодис (пестицид) хэрэглэдэггүй, мөн мал үржүүлэх, сүү үйлдвэрлэхтэй адил өөр ямарваа нэгэн хор хөнөөлтэй үйл ажиллагаа явуулдаггүй учраас үүнийг Диваажингийн таалал, сүнслэг олон зам мөр, Буддизм, Күнзийн дагалдагчдын шашны сургаал, судар дахь үнэт зүйлд нийцсэн, энэрэн нигүүлсэхүйн дадал гэж нэрлэж болох юм.

# 5

## УРГАМАЛД СУУРИЛСАН ХООЛНЫ ДЭГЛЭМД ДЭЛХИЙ НИЙТЭЭРЭЭ ШУУД ШИЛЖИХ НЬ

Яг энэ цаг үед, бүхий л төрийн бус байгууллага, Засгийн газар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийт, хувь хүн бүрийн оролцоо, зүтгэл чармайлт шаардагдаж байна. Гараг дэлхий маань гал авалцаж буй байшинтай адил болжээ. Хэрвээ бид энэ галыг унтраахын тулд нэгэн сэтгэлээр хамтдаа ажиллахгүй бол бид орон гэргүй болно. Гараг дэлхийгээ аврахын тулд дэлхийн хүн ам зуун хувь нэн яаралтай веган болох ёстой.

### I. ДЭЛХИЙД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙНХНИЙ ЭРХЭМ ТУСЛАЛЦАА, МАНЛАЙЛАЛ ХЭРЭГТЭЙ

Энэхүү түүхэн цаг мөчид хэвлэл мэдээллийн салбар дэлхийг аврах аугаа их, баатарлаг, эрхэм ариун үүрэгтэй. Тэд бүхий л төрөлтний амийг аврахын зэрэгцээ хүн төрөлхтний зүрх сэтгэл дэх эрхэм ариун, хайрын чанарыг ч бас хадгалан үлдээж чадах билээ.

Хэвлэлийн үгс маш хүчтэй нөлөө үзүүлнэ. Хүмүүс өдөр тутмын ажил амьдралаа залгуулаад дэндүү завгүй байдаг тул тэд өөрт хамаатай үйл явдал, чухал асуудал, амьдралд нь хэрэгцээтэй мэдээллээ хайн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг л хардаг. Тиймээс хэвлэл мэдээлэл нь манай гараг дэлхий, түүн дээрх амьд оршихуйнуудад аюул тулгарч байгаа энэ шийдвэрлэх мөчид бие биеэ сэхээрүүлэхэд чухал арга хэрэгсэл болно.

Дэлхийд тулгамдсан энэ нөхцөл байдлын талаар төдийгүй түүний шийдэл болох веган хоолны тухай радио, телевизийн сувгуудаар

нэвтрүүлж эхэлж байгаад би туйлын их баяртай байгаа. Бид веган хоолны дэглэмд зайлшгүй шилжих ёстой бөгөөд үүний тулд хэрчим махыг ургамлын уургаар солих үнэхээр өчүүхэн төдий өөрчлөлтийг л хийх юм. Тэгээд л боллоо—зүгээр л багахан өөрчлөлт, хүн бүр хийж чадна. Мөн энэ нь илүү хямд, илүү эрүүл сонголт.

**Хэвлэл мэдээллийн хэрэгсэл зөв шийдэлд хүрэх замыг хүмүүст заахад их дэмжлэг болдог. Үнэн хэрэгтээ, одоо хэвлэл мэдээллийнхний нэн яаралтай гүйцэтгэх үүрэг нь тэд өөрсдөө энэрэнгүй, эрхэм ариун, сайн үйл хийгч-веган болж, уг яаралтай арга хэмжээний талаар хүмүүст мэдээллэх явдал. Хэвлэл мэдээллийнхэн өөрсдөө үлгэр дуурайл болох хэрэгтэй байна.**

Хэвлэл мэдээллийн салбар асар том тул хүмүүст өөрсдийг нь дэвшүүлэх замналыг сануулахад агуу тусыг хүргэнэ. Хүн төрөлхтөн, амьтдыг, бас байгаль орчноо аврахын тулд веган болохыг ажил үйлсээрээ хүмүүст дамжуулж, урамшуулан дэмжээрэй. Яагаад гэвэл веган хоол нь хэдий энгийн ч гэлээ биднийг хөгжил хувьслын илүү өндөр түвшинд хүргэх маш том тулгын чулуу юм. Тэрнээс гадна манай дэлхийн хувьд цаг хугацаа маш бага үлдсэн байна. Бид амь амьдралаа аврахын тулд маш түргэн хөдлөх ёстой.

Сонин бүр өдрийн дугаараа гаргахдаа “Веган болж, энх тайвныг цогцлоо” гэсэн ганц өгүүлдэрийг л хэвлэвэл зохино. Энэ нь маш хялбар. Бүх сонин үүнийг хэвлэж чадна. Сонины аль нэг хэсэгт “Веган болж, энх тайвныг цогцлоо” гэсэн ганц гарчгийг бичихэд болно.

Ийнхүү веган сурталчилгааг бүхий л мэдээллийн хэрэгсэл өдөр бүр телевиз, сонин, радио төдийгүй зарлалын самбар, кино, компьютерийн дэлгэцэн дээр ч болов гаргаасай гэж би хүсдэг. Энэ нь хаа сайгүй хамгийн чухал сэдэв байх учиртай юм.

Бүхий л мэдээллийн хэрэгсэл эх дэлхийгээ аврахад туслах учиртай, яагаад гэвэл хэрвээ дэлхий маань байхгүй болчихвол бид бүгдээрээ байхгүй болно. Хүн бүр үүнийг ухаарвал зохино. Мөнгө, байшин, эрх мэдлийн аль аль нь ямар ч хэрэг болохгүй. Тэгэхлээр бид хүмүүст үүнийг ухааруулж чадах бүхнийг хийх хэрэгтэй. Бидэнд байгаа цорын ганц, хамгийн үзэсгэлэнтэй гараг Дэлхийгээ бид аврах ёстой. Энэ бидний мэдэх цорын ганц эх дэлхий маань шүү дээ.

Хүмүүсийн нийгэмд жинхэнэ, шударга нөхөр нь байа: хүн бүрд ямарваа нэгэн хөнөөлтэй нөхцөл байдлын тухай сэрэмжлүүлэн сануулья; мах болон дэлхийн дулаарлын нягт уялдаа холбоо зэргийг ухааруулах шинэ мэдээ, мэдээллийг түгээе; хүмүүст амьдралын илүү дээр хэв маягийг сонгох боломж олгоё; дуу хоолойгоо зоригтой хүргэе, ялангуяа дуу хоолойгоо хүргэх чадваргүй, маш ихээр зовж шаналан тарчилж буй амьтад, бусад төрөлтийн дуу хоолой нь болж өгөөрэй, яагаад гэвэл бид бүгдээрээ харилцан шүтэлцээтэй оршдог бөгөөд бие биедээ нөлөөлдөг.

Дэлхийд хэвлэл мэдээллийн салбарын эрхэм үйлчилгээ, манлайлал шаардагдаж байна. Тиймээс, эрхэм зоригт сэтгүүлчид минь хийж чаддаг

бүхнээ хамгийн сайнаар хийнэ үү: Бид Дэлхийгээ хэрхэн аврах талаарх Үнэнийг хэлж түгээнэ үү.

## II. ШАШНЫ ТЭРГҮҮНҮҮД БУСДЫГ АМЬДРАЛЫН ЗӨВ ЗАМД ХӨТӨЛДӨГ

**Шашны тэргүүнүүд, сүсэгтнүүд энэ сэдвийн талаар илтод ярьж байх хэрэгтэй, бидэнд нүүрлээд байгаа том асуудлыг, дэлхийн дулаарлыг зогсоош шийдлийг ойлгоход нь олон нийтэд туслахад манлайлах байр сууринаас хандвал зохилтой.**

Шашны тэргүүнүүд сүсэгтэн олондоо үлгэр дуурайл үзүүлэх ёстой. Юуны түрүүнд тэд мэдээж сүсэгтнүүдээ ургамлын хоол идэх, нүглийг цээрлэж сайн үйлийг хийх, байгаль орчноо хамгаалахад урамшуулан уриалах ёстой. Хэрвээ шашны тэргүүнүүд сүсэгтнүүддээ үүнийг зарлан мэдээлж чадвал Дэлхийн аюулгүй байдал баталгаатай болж аврагдана, яагаад гэвэл энх тайван бидний таваг хоолноос эхэлдэг. Энх тайван бидний хоолны ширээнээс эхэлдэг.

Шашны тэргүүнүүд дуу хоолойгоо хүргэж, энэрэнгүй, цагаан хоолтой амьдралын хэв маягийг дэмждэг байсан Есүс, Зөнч Мухаммед, Будда, Гүрү Нанак нарын адил үндэслэгч, тэдний эрхэм ариун сургаалын дагуу амьдрах үлгэр жишээг үзүүлэхийг хичээвэл зохилтой. Эдгээр гэгээнтэн мэргэдийн сургаал ном, судруудад бид нэг нэгнээ асран халамжлагч, Дэлхийнхээ сайн харгалзагч нь байх шаардлагатайг онцолсон байдаг.

Христийн Библи сударт “Ходоодонд хийх мах, маханд зориулсан ходоодны аль алиныг Бурхан устгах болно.” гэсэн байдаг. Буддын Махапаринирван Сударт бас “Мах идэх нь энэрэл нигүүлслийн үрийг тасална, мах идэгчдийн биеэс үнэртэх махны үнэрээс болж тэдний бүхий л үйлдэл хамаг төрөлтнийг айлгах болно.” гэж бичсэн байдаг.

**Үнэндээ, Христийн шашин, Буддизм, Хиндүизм, Лалын зэрэг бүхий л шашин бидэнд: Амьтад Бурханы бүтээл тул тэднийг бүү ид гэж сургадаг.**

Цагаан (веган) хоолны бурханлаг тал нь маш тодорхой — энэ бол үл-хүчирхийлэл — “Та амь хөнөөж үл болно.” Бурхан бидэнд “Та амь хөнөөж үл болно” гэж хэлэхдээ Тэр хүн төрөлхтнийг онцлоогүй; Тэр бүх төрөлтийг хамруулан хэлсэн.

Биднийг цагаан (веган) хоолтон байх учиртайг Библид маш тодорхой заасан байдаг. Шинжлэх ухааны үүднээс ч бид цагаан (веган) хоолтон байх учиртай. Эрүүл мэндийн үүднээс ч бид мөн л цагаан (веган) хоолтон байх учиртай. Эдийн засгийн бүхий л шалтгаанаар

бид цагаан (веган) хоолтон байх учиртай. Энэрэл нигүүлслийн бүхий л шалтгаанаар бид цагаан (веган) хоолтон байх учиртай. Мөн дэлхийг аврахын тулд бид цагаан (веган) хоолтон байх учиртай.

Хэрвээ Барууны хүмүүс цагаан (веган) хоолыг долоо хоногт нэг удаа идвэл жилд 60 сая хүнийг аврах боломжтой хэмээн зарим судалгаанд дурдсан байсан. Тиймээс бүхий л шалтгаанаар баатарлаг бай, цагаан (веган) хоолтон байя. Гэвч яагаад цагаан (веган) хоолтон гэж та надаас асуух байх. Бидний дотоодын Бурхан биднээс үүнийг хүсэж байгаа учраас л тэр.

Тиймээс, аливаа шашинд итгэгч нарт хүрээлэн буй орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд бид эдгээр сургаалыг бодит үйл хэрэг болгох шаардлагатайг сануулах хэрэгтэй. Мөн хамгийн үр нөлөөтэй үйлдэл бол иргэн бүрийн нэн даруй хийж чадах зүйл – веган байх. Мэдээж, нөгөө нэг нь бол “веган байх”, энэ нь байгаль орчноо хамгаалж, хэрэглээгээ хэмнэ гэсэн утгатай.

**Веган байх нь бид жинхэнэ шашны итгэл үнэмшлийнхээ дагуу амьдрах хэв маяг юм. Махыг цээрлэж, ургамалд-суурилсан амьдралын хэв маягтай болно гэдэг нь бид энэрэл нигүүлслийн зарчмыг хэрэгжүүлнэ гэсэн үг.**

Үл хүчирхийлэх болон үүн шиг бусад зарчмыг бид уншиж, дадуулдаг; бид үүнийг зайлшгүй чанд баримтлах ёстой. Бид амь хөнөөдөггүй, хулгай хийдэггүй, харин амь насыг аварч, буяны үйл хийдэг. Бид нэг нэгнээ хайрладаг; бид нэг нэгэндээ тусалдаг; мөн бид ёс суртахууны хэм хэмжээг баримталдаг. Бусдын юмыг бид авдаггүй. Үүний оронд бид өөрт байгаа зүйлсээ гачигдаж буй хүмүүст өгдөг. Бүхий л шашин үүнийг бидэнд сургадаг, тиймээс бид үүнийг амьдралдаа дадуулах л хэрэгтэй билээ.

Бид сургаал номлолоо эргэн харж, Их Багш нар бидэнд юу хэлсэн, зөнч мэргэд бидэнд юу заасныг харах хэрэгтэй. Бидний хийх ёстой зүйл бол ердөө л энэ. Өөр ямар нэг зүйл хийх шаардлагагүй. Бид л амьдралдаа дадал хэвшил болгох аваас бидэнд амар тайван амьдрахад суралцах хангалттай олон судар ном байдаг шүү дээ.

### **III. ЭРХЭМ АРИУН БОЛОВСРОЛ НЬ ЭРҮҮЛ НОГООН АЖ ТӨРӨХ ХЭВ МАЯГИЙГ ЗААДАГ**

**Бидний орон гэр галд өртжээ. Гараг дэлхийд аюул нүүрлээд байна. Та [сурган хүмүүжүүлэгч] нар үүнийг хүмүүст ойлгуулах хэрэгтэй байна. Та нэн даруй арга хэмжээ авах хэрэгтэй. Тэдэнд юу хийхийг нь хэлж өгье. Тэднийг илүү сайхан амьдрал уруу хөтөлье. Тэд танд найдан харж байгаа, тэд талархах болно.**

## ХҮҮХДҮҮДЭД МЭДЭЭЛЭЛ ӨГЬЕ

Бид хүүхдүүдэд заавал хэлэх ёстой. Дэлхийн дулааралтай холбоотойгоор манай дэлхийд юу тохиолдоод байгааг бид тэдэнд шударга үнэнээр нь хэлж, чиглүүлж, түүнд бэлтгэх бүхий л аргыг мэдэх боломж олгосноор бид дэлхийн дулаарлыг бууруулж, магадгүй бүрмөсөн зогсоож чадна.

Хүүхдийн зүрх сэтгэл гэнэн цайлган, ариун тунгалаг байдаг учраас тэд ахмад настай хүмүүсийн заавар, зөвлөгөөг тэр дор нь хүлээн авдаг. Тийм учраас, бид тэдэнд манай дэлхийд юу сайн болохыг нухацтай тайлбарлаж өгөх ёстой.

Тайлбарлаад өгөхөд тэд шууд ойлгох болно, тэгээд таны зөвлөсөн тэр үйлдлийг даруй хэрэгжүүлнэ. Яагаад гэвэл хүүхдүүд ахмад настай хүмүүсийг хүндэтгэдэг. Гэхдээ юуны түрүүнд бид өөрсдөө тэдний үлгэр дуурайл нь байх ёстой.



Веган хүүхдүүд жимс, хүнсний ногоо, алимын бялуугаа амтархан идэж байгаа нь

Бид бол ахмадууд; эхлээд өөрсдөө үлгэр дуурайл үзүүлэх ёстой, дараа нь хүүхдүүдийг сурган хүмүүжүүлж чадна, яагаад гэвэл хүүхдүүд үлгэр жишээг л дагаж суралцдаг шүү дээ; тэд ярьж хэлэхээс илүү бодитой үлгэр жишээнээс суралцдаг. Тийм учраас томчуул бид ямагт сайн үлгэр дуурайл байх ёстой; бид чадах бүхнээ хийх ёстой.

**Бид дэлхийдээ сайн зүйлийг л хийнэ, тэгснээр хүүхдүүд маань бидний үлдээх сайхан өв уламжлалыг залгамжлан авч үргэлжлүүлэх болно.** Том золиос гаргасан ч хамаагүй бид шаардлагатай бүхнийг хийх ёстой; гэвч үнэндээ бидэнд юуг ч золиослох шаардлага байхгүй. Бид ердөө л тэр зүсэм махыг орхиод, зүсэм дүүфүүгээр орлуулчих хэрэгтэй.

## ЗАЛУУ ҮЕИЙГ ИДЭВХЖҮҮЛЬЕ

Өсвөр үеийнхэн маань өнөөгийн нэн тулгамдсан нөхцөл байдлаас



илүүтэйгээр сүүлийн үеийн загвар болон бусад зүйлд илүү сонирхолтой байх шиг санагддаг. Гэхдээ тэд мөн л хамгийн чөлөөт сэтгэлгээтэй хүмүүс шүү дээ. Тэд ухаалаг, нөхөрсөг, соргог мэдрэмжтэй, үнэнч сэтгэлтэй хүмүүс. Тэд дэлхийн дулаарлыг амьдралтайгаа холбож ойлгомгоцоо л ямар нэг зүйл хийхээр чин үнэнээсээ шийдэж магадгүй. Ялангуяа өөрсдийнх нь хийх зүйл үнэхээр том өөрчлөлт авч ирнэ гэж ойлговол тэд арга хэмжээг авах хошуучлагчдын нэг болж магадгүй. Үүгээрээ таныг гайхшруулж ч мэднэ. Тэдэнд тань шиг сайн манлайлагч л хэрэгтэй байна.

Саяхан хийсэн хоёр судалгаагаар залуучуудыг сайн дурын үйлс хийх, хийж байгаа зүйлдээ өөрсдийгөө бүрэн зориулах хамгийн их магадлалтай хүмүүсийн нэг болохыг илрүүлсэн байна.<sup>139</sup> Үүгээр ийм насны залуучууд маш их эрч хүчтэй, хамгийн их халамжтай хүмүүс болохыг илэрхийлсэн хэрэг.

Тиймээс та хайр, халамжаа харуулах идэвхтэй арга замыг олоход нь тэдэнд тусалж, тэднийг урамшуулан зоригжуулж болно. Түүнчлэн дэлхийн дулаарал үнэндээ нэн яаралтай шийдвэрлэх асуудал болохыг ойлгоход нь та тэдэнд тусалж болно. Тэдэнд дэлхийн дулааралд хүний үзүүлж буй нөлөө, үүнээс болж зовж шаналж буй хүн, амьтдын бодит түүх, тухайлбал: арлын орнуудад далайн усны түвшин нэмэгдсэнээс байшин нь далайн усанд автах гэж буй, эсвэл зарим тохиолдолд хэдийнээ живснээс болж дүрвэн нүүж байгаа, нүүхээр зэхэж байгаа хүмүүс, өрхүүдийн талаар хэлж өгөөрэй.

Эсвэл мал нядалгааны газар, гоо сайхны бүтээгдэхүүний туршилтад орж буй амьтдад хэрхэн хүний ёсонд баймгүй харгис хатуу хандаж байгааг хэлээрэй. Энэ тухай олон кино байдаг шүү дээ. Суприм Мастер Телевиз Мягмар гараг болгонд “Амьтдыг харгислахаа зогсоо” нэвтрүүлгээрээ энэ тухай үзүүлдэг. Төсөөлөхийн аргагүй харгислал. Энэ бол хүний ёс, ёс суртахууны хэм хэмжээнээс гажсан харгислал. Амьтдад ингэж хандах нь хүмүүн бидний эрхэм ариун чанарт нийцэхгүй. Тиймээс, хэрвээ та хүүхдүүдэд хүмүүсийн таашаалыг хангахын төлөө амьтдад хэрхэн зовж байгаа тухай үнэнийг дэлгэвэл та сурагчдынхаа энэрэнгүй сэтгэлийг сэрээж, тэд ямарваа нэгэн арга хэмжээ авах шийдвэр гаргах болно.

Эсвэл тэдэнд нүүдлийн шувууд үүрээ засахын тулд улам илүү урт удаан, хол газар нисдэг болоод байгааг, мөс ихээр хайлж буйгаас цагаан баавгай улам алс газар уруу сэлдэг болсон, заримдаа эцэж туйлдан живсэн тухай, сүүлийн жилүүдэд хөрш улс оронд нь яагаад ийм их үер, гай гамшиг тохиож буй гэх мэтийг тайлбарлаж өгөөрэй.

Уур амьсгалын өөрчлөлт бодит амьдралд, амьтдад, хүмүүст болон тэдний өөрсдийнх нь амьдралд хэрхэн нөлөөлж байгааг залууст хэлж өгөөрэй. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох нь тэдний хамгийн гол зүйлс, ажил, мөнгө, зугаа цэнгэлээс ч илүү чухал болохыг залуус ухаарах болно. Учир нь тогтвортой орших гараг дэлхий, уур

амьсгал үгүй бол хэн ч хүсдэг зүйлсээ хийж, эдэлж, баясаж чадахгүй шүү дээ.

Гэхдээ залуустаа бидэнд гараг дэлхийгээ аврах боломж найдвар байгааг харуулах нь чухал. Та тэдэнд: веган байж, энэ шийдлийг бусдад түгээх нь тэдний хувьд жинхэнэ баатар болох боломж гэдгийг хэлж өгөөрэй. Тэд өөрсдийн, дэлхий дээрх хүмүүс, тоймгүй олон амьтныг оролцуулан бүхий л амийг аварч чадна.

Хэрвээ та веган байхын бүхий л ач тусыг, өөрийнхөө төлөө, амьтдын төлөө, өлсгөлөн хүмүүс, өлсөж үхэж байгаа хүүхдүүдийн төлөө гэж тайлбарлавал тэдэнд их таалагдах болно. Мөн тэд үнэхээр өөрчлөлт хийж чадна гэдгээ мэдээд сэтгэл нь хөдөлнө.

Залуучууд учир шалтгааныг нь ойлговол амьдралын хэв маягаа өөрчлөхөд бэлэн байдаг хамгийн нээлттэй хүмүүс. Ихэнх тохиолдолд энэ насны залуучууд вегетарианизм зөв болохыг ойлгон харж чаддаг. Тиймээс миний бодлоор, хэрвээ тэдэнд ямар учраас дэлхийн дулаарлыг шийдвэрлэх нь хамгийн чухал үйл хэрэг болохыг зөв тайлбарлавал тэд сэдэлжинэ. Тэд таныг дэмжиж, ямагт таны талд байх болно. Тэд үүнийг хийнэ.

## **СУРГУУЛИУДАД ҮДИЙН ВЕГАН ХООЛ НЭВТРҮҮЛЭХЭД ТУСАЛЬЯ**

Өнөө цагт сургуулийн эрүүл үдийн хоол, зуушны хөтөлбөрийн ашиг тусыг харуулсан маш олон судалгаа байна. Хүүхдүүд ахиухан шинэ жимс, хүнсний ногоо идсэн үедээ илүү төвлөрөл сайтай байдаг нь ч тогтоогджээ.

Америкийн Тэргүүн хаатагтай хүүхдүүдэд шинэ жимс, ногоог байнга таниулах болжээ. Бид сургуулиудад үүний ашиг тусыг ойлгож ухаарахад тусалбал тэд өөрсдөө үүнийг өргөн дэлгэр хэрэгжүүлж магадгүй. Өдгөө олон сургууль, эцэг эхчүүд байрныхаа гаднах цэцэрлэгт хүүхдүүдтэйгээ хамт хүнсний ногоог тарьдаг болсон байна, хүүхдүүд ч ийнхүү хөдөлмөрлөхдөө дуртай төдийгүй тарьсан ногоогоо илүү дуртай иддэг болжээ!

Веган болсноор гараг дэлхийгээ эдгээн аврахад болон эцэг эхчүүддээ, өөртөө, түүгээр ч барахгүй энэ дэлхийн бүх амьд оршихуйд шууд тусалж байгаа гэдгийг бид хүүхдүүддээ хэлэх нь зүйтэй. Хүүхдүүд маш уяхан сэтгэлтэй тул тэд веган болсноор маш олон амь аварна гэдгээ мэдээд үүнийг хийх тун их, бүр маш их хүсэлтэй болно. Бид үр хүүхдүүддээ ногоон, үржил шимт үзэсгэлэн төгөлдөр дэлхийг, хүн амьтан хамтдаа амгалан орших тэр л дэлхийг үлдээх боломжтой байхыг хүсдэг шүү дээ. Хүүхдүүд маань ч үүнийг хийхэд бидэнд туслахдаа дуртай байх болно.

## IV. ТББ-УУД ВЕГАН ХӨДӨЛГӨӨНИЙГ ДЭМЖДЭГ

**Ногоон технологи үр өгөөжөө өгөхийг хүлээх хугацаа бидэнд бараг байхгүй тул төрийн бус байгууллага (ТББ)-ын зүгээс дэлхийн дулаарлыг зогсооход туслах нэн үр дүнтэй арга зам бол хамтдаа идэвхийлэн хамгийн зөв шийдэл болох веган хоолны дэглэмд шилжихийг урамшуулан дэмжих явдал юм. Ногоон технологи үр өгөөжөө өгөхөөр байлаа ч эдгээрийг нэвтрүүлэх хүртэл маш их хугацаа шаардана.**

Тиймээс веган хоолны дэглэм бол эн тэргүүний шийдэл, учир нь мах үйлдвэрлэл дэлхийн агаар мандлыг хамгийн ихээр халаадаг хүлэмжийн хийг ялгаруулж, бохирдлын 50-аас илүү хувийг үүсгэдэг.<sup>140</sup> Хэрэв бид хорт хийн 50-аас илүү хувийг зайлуулчихвал гараг маань тэр даруй 50-аас илүү хувиар сэрүүцнэ гээд төсөөл дөө.

Хэрэв бид органик аж ахуйн аргыг сонгон, дэлхий дээрх бүх газарт үүнийг хэрэгжүүлбэл энэ нь агаар мандал дахь CO<sub>2</sub>-ийн 40%-ийг шингээж авна шүү дээ.<sup>141</sup> Тэгэхээр энэ бүгдийг хослуулснаар бид гараг дэлхийгээ тэр дор нь сэрүүцүүлж чадна. Энэ бол ямар нэгэн учир битүүлэг зүйл ч юм уу эсвэл мухар сүсэг биш. Энэ бол шинжлэх ухааны үндэслэлтэй. Бүгд батлагдсан, бүгд тодорхой юм.

Иймээс Копенгагений уур амьсгалын өөрчлөлтийн уулзалтан дээр улс орнуудын төр засгийн анхаарлыг та, таны зохион байгуулах, мэдээлэх, ярьж ойлгуулах авьяас татна гэж би найдаж байна. Чадах бүхнээ хийнэ үү. Засгийн газар таны мэдээллийг сонсоод энэ шийдлийг цаашид эрчимжүүлэх арга хэмжээ авах болно.

Төрийн бус байгууллагууд дэлхийд бүтээлч хөдөлгөөнийг яаж эхлүүлэхээ сайн мэддэг. Ийм бүтээлч хөдөлгөөн манай гараг дэлхийд туйлын чухал, зайлшгүй шаардлагатай байна. Бүх ТББ нэгэнт хөдлөөд эхэлчих юм бол тэд хүн төрөлхтөнд болоод бидний эсэн мэнд оршихуйд хамгаас чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ цаг мөчид бүхий л хүчин зүтгэлээ зориулан бүх ТББ, төр засаг, мэдээллийн хэрэгсэл, олон нийт, хувь хүн бүр оролцох хэрэгтэй.

**Гараг дэлхий маань гал авалцаж буй байшин юм. Бид галыг унтраахын тулд хамтдаа нэгэн сэтгэлээр ажиллахгүй бол бид орон гэргүй болно. Дэлхийн хүмүүс бүгд эх дэлхийгээ аврахын тулд нэн даруй веган болох ёстой.**

Бид хүлэмжийн хийн ялгарлыг багасгах зорилтуудаа даруй өргөжүүлж, ач холбогдлыг нь ухаалгаар эрэмбэлэх хэрэгтэй байна. Юуны түрүүнд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй, дангаараа метан хийний хамгийн том эх сурвалж болох мал аж ахуйн үйлдвэрлэлийг таслан зогсоох хэрэгтэй. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг зогсоовол дэлхийн дулаарлыг тун хялбархан зогсооно. Яагаад гэвэл дэлхийн дулаарлын ихэнх хувь нь амьтны гаралтай бүтээгдэхүүнээс үүдэлтэй.

Тэгээд л боллоо, маш хялбархан, шулуухан, ямар ч учир битүүлэг зүйл байхгүй, тэгээд ч хэцүү биш.

**Чин үнэнийг хэлэхэд, өнөөгийн төлөвлөгөөгөөр явбал бид эх дэлхийгээ аварч чадахгүй. Бидний одоо хийгээд байгаа арга замаар явбал дэндүү хожимдоно; гараг дэлхийгээ аврахад хэт хожимдсон байх болно. Тэгэхээр бид юуны түүнд веган болох хэрэгтэй, энэ нь бас байгальд хамгийн ээлтэй арга зам байж чадна. Ингэсэн цагт бусад ногоон технологийг хөгжүүлэх, суурилуулах цаг бидэнд гарна.**

Үүгээр ч зогсохгүй бид бүр диваажинлаг дэлхийг бүтээнэ, яагаад гэвэл веган байх нь хүрээлэн буй орчноос эхлээд хүмүүсийн оюун ухааныг хүртэл бүгдийг эрс өөрчилж, дэлхий байх ёстой түвшиндээ хүрч, дэлхийд энх тайван цогцолж, өлсгөлөн арилж, хүн төрөлхтөн жинхэнэ ахан дүүсийн харилцаатай болно.

Агаарын температур тогтворжиж, экосистемийн тэнцвэр сэргэж, амьтад энх амгалан оршиж, хүн төрөлхтөн эрүүл мэнд, аз жаргалаар дүүрэн байх ба гайхамшигтай шинэ нээлтүүд бий болж, бидний амьдрал урьд хэзээ ч төсөөлж байгаагүй, мөрөөдлийн Диваажин болно.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын Нийгэмлэгийн гишүүд COP 15-ын үеэр Веган шийдлийг сурталчилж байгаа нь, Копенгаген, Дани, 2009

## V. ТА ХАРАХЫГ ХҮСЭЖ БҮЙ ӨӨРЧЛӨЛТӨӨ ХИЙГЭЭРЭЙ

### ӨӨРСДИЙГӨӨ ӨӨРЧЛӨН ДЭЛХИЙГ ӨӨРЧИЛЬЕ

Гараг дэлхийгээ аврахад хувь хүн бүрийн зүтгэл хамгийн чухал.

Гараг дэлхийгээ аврах нь чухамхүү та биднээс л эхэлнэ. Эрт дээр

үеэс авхуулаад хувьсал ямагт хувь хүнээс эхэлдэг байсан. Хэрэв бид дэлхийг өөрчлөхийг хүсэж байвал юуны өмнө өөрсдийгөө өөрчлөх хэрэгтэй. Одоо хэдийгээр Засгийн газар архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэхийг хорилоо ч хэрэв хувь хүмүүс өөрсдөө үргэлжлүүлсээр байвал бид тэгтлээ их өөрчлөлт хийж чадахгүй. Тиймээс одоо бид өөрчлөгдөх хэрэгтэй байна.

Хэдий чинээ олон хүн махыг, амьтны гаралтай бүхий л бүтээгдэхүүнийг өөрсдийн хэрэглээнээс хасаж чадна, гараг дэлхийгээ аврах боломж маань төдий чинээ их болоод зогсохгүй бид эх дэлхийгээ онгон, үзэсгэлэнт сайхан төрхөд нь буцааж оруулж, тэр бүү хэл одоог хүртэл бидний мэдэж байснаас ч илүү сайхан, илүү үзэсгэлэн төгөлдөр, илүү элбэг дэлбэг, энх амгалан, баяр жаргалтай болгон сэргээж чадна.

Гараг дэлхий дээрх бүх төрөлтөн зэрэгцэн энх амгалан орших, энэрэл, нигүүлслээр дүүрэн амьдралыг дээдлэх хэмжээнд газар дэлхий маань өөрийгөө сэргээж чадвал олон гайхамшигт нээлт хийгдэх болно.

### *Эерэг энерги дэлхийг аварна*

Хаа байгаа газраа та бүгд хэн боловч хийж байгаагаа үргэлжлүүлээрэй. Хүн болгоны хүчин зүтгэлийг үнэхээр тооцдог учраас оногдсон ажлаа хийгээд л бай. Гараг дэлхийдээ туслахын тулд махан хоолны талаар, цагаан хоолны ашиг тусын тухай ганц мэдээлэл, ганц хуудас тараасан ч тооцогддог. Тэр бүү хэл ганц үг ч тооцогдоно. Өчүүхэн зурвас мэдээ мэдээлэл хүртэл тооцогдоно. Хүн бүр бага багаар тусалсаар байвал эерэг чигт хандсан хамтын ухамсрын нөлөөгөөр бүхэл гараг ертөнц маань өөрчлөгдөнө.

Хүн бүр л ижил зүйлийг хүсдэг; хүн болгон л гараг дэлхийгээ авч үлдэхийг хүсдэг, хүн бүр л бөмбөрцөг дэлхийнхээ тогтвортой байдлыг хангахыг, амьдралын энэхүү хэв маягийг хадгалахыг, буюу үүнээс ч илүү сайхан байлгахыг хүсдэг. Тэгсэн цагт ухамсар аугаа ихээр тэлсэн байх болно. Энерги ч энэрэл хайраар дүүрэн байх болно. Хүн болгон тэр үмх махнаас татгалзчихвал амьдралын хэв маяг тун хялбархан өөрчлөгдөнө.

Эхлээд гараг дэлхийгээ авар, тэгсэн цагт юмс аяндаа өөрчлөгдөнө. Гэхдээ энэ нь та ганцаараа дэлхийг аварч чадна гэсэн үг биш. Ухамсраа өөрчилж буй хүн бүр үүнийг чадна. Хэрвээ тэд веган болж, байгалиа хамгаалж, сайн үйлсийг бүтээж байвал тэд илүү сайн болж өөрчлөгджээ гэсэн үг. Тэдний ухамсар өндөр түвшинд очиж, тэгээд мэдээжийн хэрэг Дэлхийгээ аварч үлдэх буяныг хүртэнэ. Тэд өөрсдөө, бас тэдний үр хүүхдүүд, ач гуч, зээ нар нь дэлхий дээр үргэлжлэн амьдрах боломжтой болно.

Тэр үед хүмүүсийн ухамсар илүү дээд түвшинд очсон байх тул бүх юмс тодорхой болно. Бид энх амгалан, хайрын дунд амьдарна. Та бүхэн дэлхийг гэгээлгээр, таны хүсэж байгаа Газрын Диваажин мэт төсөөлөх хэрэгтэй. Илүү эрхэм ариун, зэрэг, үзэсгэлэнт дэлхийг, Диваажинлаг дэлхийг л төсөөлөх ёстой. Эх дэлхийгээ аврах нь хамгийн энэрэнгүй үйлс. Дэлхий аврагдаагүй байсан ч Та өөрөө энэрэнгүй нинжин сэтгэлээрээ аврагдана. Та бусдыг аврахыг хүссэнээс болоод буян хариулал тань үржиж арвижна.

Хэрэв та дэлхий ертөнцөө аврахыг хүсэж байвал, хэрэв та үүний төлөө юуг ч хийхэд бэлэн байгаа бол та эрхэм ариун сэтгэл, бурханлаг чанараа тэлж буй хэрэг. Та Газар дэлхий дээрх бусад төрөлтнийг аврахыг хүссэний улмаас гараг дэлхийгээ аврах хүсэл эрмэлзлээ түгээж, веган болж, байгалиа хамгаалах сайн үйлсийг бүтээх юм бол та бусдад тусалж байна гэсэн үг. Танд гэгээнтний чанар байна гэсэн үг. Та ариун чанараа сэрээж чаджээ. **Энэ бол зөвхөн гараг дэлхий, амийг аврах төдий асуудал биш. Үүнийг хийх хүсэл эрмэлзэлтэй байж, амьдралыг аврах аянд өөрийн биеэр оролцож буй аугаа хүн таны тухай юм.**

### *Эрх мэдэл хэрэглэгчдийн гарт байна*

Амьдралынхаа төлөө, эх дэлхийнхээ төлөө зөв зүйлийг хийхэд бидэнд хэн ч саад болж чадахгүй. Бид ердөө л амьтны гаралтай бүтээгдэхүүн хэрэглэхээ, идэхээ, худалдаж авахаа больчих юм бол тэр компани, үйлдвэрүүд алга болно. Тиймээс эрх мэдэл бидний гарт байна.

Ердийн хэрэглэгчид бид, мах болон амьтны гаралтай бүх бүтээгдэхүүнийг эсэргүүцэж, веган болсноор хамгийн хүчтэй нөлөөг үзүүлж чадна. Хэрэв бид бүгдээрээ веган болчихвол мал амьтан үржүүлэн амьдралдаа аюул занал учруулдаг үйлдлүүд зогсоно.

АНУ-д байдаг гахайн махны үйлдвэр [2009 оны байдлаар] 2007 оноос хойш 5.4 тэрбум америк долларын алдагдал хүлээсэн ажээ.<sup>142</sup> Эдүгээ гол компани дампуурлаа зарласны дараа компаниуд засгийн газраас тусламж хүссэнээр 2009 онд тэдний борлогдоогүй гахайн махан бүтээгдэхүүнийг 105 тэрбум америк доллараар худалдан авахад хүрсэн байна.<sup>143</sup> Энэ хүчирхэг үйлдвэр дампуурсан шалтгаан нь нэгдүгээрт, тэжээлийн өртөг өндөр, хоёрдугаарт гахайн ханиад гарснаас хойш хэрэглэгчид бүтээгдэхүүнийг нь өмнөх шигээ ихээр худалдаж авахаа больсонтой холбоотой ажээ. Хэрэв хэн ч мах иддэггүй болбол амь зуулгандаа хөөрхий амьтдыг алж нядлах хүн үгүй болно гэж төсөөл дөө. Ингэх нь компаниудын лоббигоос хавьгүй хүчирхэг байж чадна.

Бидэнд эрх мэдэл бий. Бид мал амьтан үржүүлгийн компаниудад эрх мэдэл олгоод байгаа учраас л тэд эрх мэдэлтэй байгаа! Бид эрх мэдлээ тэдэнтэй хуваалцдаг. Гэхдээ бид тэдний бүтээгдэхүүнийг худалдаж авахаа зогсоовол тэдний эрх мэдэл ч үгүй болно.

## *Их Багш Чин Хайн “Хэрхэн веган болох тухай” зөвлөмж*

1. Дэлгүүр очихын өмнө веган хоол идээрэй. Тэгвэл та хүнсний дэлгүүрээр явж байхдаа өлсөхгүй.
2. Дэлгүүрт ороод шууд л веган хүнсний тасгийг чиглэн яваарай.
3. Интернэтээс, найз нөхөд эсвэл веган байгууллагаас веган жор олж аваарай.
4. Таныг дэмждэг веган найзуудтай болоорой.
5. Веган байх ач тусын тухай мэдээлэл аваарай.
6. Веган чиг хандлагыг бусдад таниулаарай.
7. Гэгээнтэн шиг байгаарай.

## **БАЙГАЛЬ ДЭЛХИЙДЭЭ ЭЭЛТЭЙ БАЙЯ**

Байгаль дэлхийдээ ээлтэй байя. Мод тарих, тогтвортой эрчим хүч бий болгох, хибрид унаа унах зэрэг нь бүгдээрээ хүрээлэн буй орчныг хамгаалах үйлдэл. Үүнд мэдээж, ногоон хоол, веган хүнс багтана.<sup>144</sup>

### ***Органик веган аж ахуйг дэмжье***

Органик байхыг хичээе. Органик аж ахуй эрхлэгчдийг дэмжих үүднээс органик хүнс худалдаж авъя. Органик хүнс, хүнсний аж ахуйг дэмжихийн төлөө чадах бүх зүйлээ хийе.

АНУ-аас авхуулаад Иран, Ау Лак (Вьетнам), Формоса (Тайван) зэрэг улс оронд мал аж ахуй эрхлэгчид амьдралд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, газар дэлхий байгаль орчинтой зохиролтой ажиллах жинхэнэ чин сэтгэлтэй фермер байх илүү дээр арга замын талаарх шинэ мэдээллийг өөрсдөө болон бусдаас олж авсны улмаас өөрчлөгдөн олноороо веган буюу органик веган бизнест шилжиж байна. Бид ч мөн, мал аж ахуй эрхлэгч нэг бүрд махны хор уршиг, органик веган хоолны ач тусын талаар ухааруулан ойлгуулж, мэдээлдэг нэгэн байж чадна шүү дээ.

Үүнийг хийхийг хүссэн, эсхүл чадах хэн бүхэн хийгээрэй. Зүгээр л мал аж ахуй эрхлэгчидтэй ярилцаарай. Үүнд цаг гарга. Бидэнд Засгийн газар шиг тийм их эрх мэдэл, байр суурь байхгүй ч бид нэг нэгээр нь ухааруулж чадна шүү дээ. Тэдэнд өнөөгийн дүр зураг, нөхцөл байдлыг хэлж өгөөрэй. Тэднийг ойлготол нь ахин дахин хэлээрэй. Захидал бичээрэй. Тэдэнтэй ярилцаарай. Бид зөвхөн аль чадахаараа хичээж чадна шүү дээ.

## ***Мод, хүнсний ногоо тарья***

Бид органик хүнсний ногоо тариалж, мод тарьж болно. Жимсний мод, самрын мод болон багахан ус шаарддаг хүнсний ногоо, буурцгийн төрлийн шошийг тарих нь илүү дээр.

Бид нэг удаад нэг мод тарихад бид хэзээ ч хүчилтөрөгчийн дутагдалд орохгүй.

Та газартаа эсвэл гэрийнхээ ойролцоо хүнсний ногоо эсвэл мод тарьж болно. Жимс ч бидэнд хангалттай хүнс шүү дээ. Үүгээр би зөвхөн амтат жимсний тухай яриагүй байна. Өргөст хэмх, тарвас, цагаан хулуу, шовх хулуу, папайя гэх мэт төрөл бүрийн жимс байдаг. Аль чадахыгаа л тариарай. Түргэн ургадаг, тэжээллэг, их ус шаарддаггүйг нь тариарай, яагаад гэвэл бид чинь юухнаар ч амьдарчихна шүү дээ.

Газар хашаатай хүмүүс зүлэг эсвэл өөр зүйл ургуулах буюу хэрэглэхгүй сул байлгахын оронд хүнсний ногоо тариарай. Та өөрт хүрэлцэх эсвэл дор хаяж зарим нэг хэрэгцээгээ хангах хэмжээнд тарьж болно. Ийм замаар та чанартай, ногоон хүнстэй болох төдийгүй цаг, мөнгө, тээвэр унаандаа хэрэглэдэг эрчим хүчийг хэмнэх болно.

Үүгээр ч зогсохгүй та байрандаа ч ногоо тарьж ургац авч болно. Хэрэв тагттай бол усан дотор тарьж болно. Өөрийн гэсэн хүнсний ногоотой болохын тулд бид одоо л эхлэх ёстой.

Хэрэв усны хомсдолтой байгаа бол та шош, жимс илүүтэй тарьж болно. Шошийг ургуулахад хялбар. Бас хурдан ургадаг. Бүр усгүй ч ургана. Та Суприм Мастер ТВ-ээр шошийг хэрхэн ургуулах тухай мэдэж авч болно.<sup>145</sup>

## ***Арвич хямгач байя***

Энгийн амьдар, аль болох энгийн, энгийн байх тусмаа сайн.

Хямгач байх гэдэг нь хэрэгцээнээсээ илүү хэрэглэхгүй, байгаа юмандаа сэтгэл хангалуун байх гэсэн үг. Байгалиас бидэнд өгсөн нөөц их үнэ цэнэтэй бөгөөд хязгаартай. Бид түүнийг хэтрүүлэн хэрэглэж болохгүй, ухаалаг хэрэглэж байж л хэвийн хэмжээнд байлгана.

Бид байнга шинэ, загварлаг хувцас худалдаж авах шаардлагагүй. Бид сүүлийн үед нээгдсэн зоогийн газарт очих хэрэггүй. Амьдралд үүнээс илүү сайн сайхан, баяр баясгаланг авчирч чадахуйц, тэгтлээ их мөнгө шаардахгүй олон зүйл байдаг. Бид тавилгагүй ч амьдарч чадна шүү дээ, ингэх нь ч сайн.

Хэмнэлт хийцгээе - халуун ус бага хэрэглэе, шүршүүрт цөөн оръё, шүршүүрт орж байхдаа усаа гоожуулахгүй байя, шүдээ угааж байхдаа усаа хаая, компьютерээ унтраая, хэрэглээгүй үедээ гэрлээ унтраая, хэрэглэхгүй байгаа бол асаалттай болгоныг унтраая, ингэж чадвал та



байр, ус, цахилгааны төлбөрийнхөө магадгүй 10%-ийг даруй хэмнэж чадна.

Энгийн аж төрөх дадлыг бий болгох бас нэгэн арга бол байгалийн амгалан тайванд цагаа өнгөрүүлэх, эсвэл гэртээ амар тайван, нам гүм уур амьсгалыг мэдрэх байгалийн орчныг бүрдүүлэх явдал юм. Түүнчлэн сүнслэг ном судар гэх мэт сэтгэл өргөх ном унших, бясалгал хийх нь аз жаргалтай байхад, сэтгэл хангалуун, эв түнжинтэй амьдрахад бидэнд үнэндээ тийм их зүйл хэрэггүй гэдгийг эргэн санах сайн аргууд юм.

## **САЙН ҮЙЛС БҮТЭЭЕ**

Бид гараг дэлхий дээрээ хайраар бялхсан уур амьсгалыг бий болгох хэрэгтэй. Ингэх нь мөн биднийг хамгаална.

Гараг дэлхийд ээлтэй орчныг бүрдүүлэх хөдөлгөөнийг идэвхжүүлэн хурдасгах бас нэгэн арга зам бол орчин тойрондоо илүү их эерэг энергийг бий болгох: Сайн үйлийг хий, энэрэнгүй, сайхан сэтгэлтэй бай. Хайрлагч чанараа тэл. Энэ нь биднийг, манай гараг дэлхийг хамгаалах дийлдэшгүй бамбайг бий болгоно.

Бид гараг дэлхийнхээ хайр энэрэл, эерэг энергийг улам хүчирхэгжүүлэхийн тулд сайн үйлсийг хийх хэрэгтэй. Дэлхий дээр аз жаргал, хайраар бялхсан уур амьсгалыг бий болгох хэрэгтэй, ингэвэл бид энэ сайхан уур амьсгал дунд амьдарч, хамгаалагдаж, аз жаргалтай байх болно. Энэ нь үнэхээр шинжлэх ухааны үндэслэлтэй. Үүнийг ойлгохын тулд бид ямарваа нэгэн шашинд итгэх шаардлага байхгүй: Бид өөрсдийнхөө амьдрах орчныг бий болгож чадна. Хэрэв хүн болгон эв зохиролтой, эерэг уур амьсгалыг бүрдүүлбэл гараг дэлхий маань энх амгалан, яг л энхжингийн оронд байгаа мэт байх болно.

Хэрэв танд илүү мөнгө байгаа бол, эсвэл Будда болон Бодисадва таны хэрэгцээнээс илүүг хайрлаж өгсөн бол та гачигдалтай эсвэл ядуу нэгэнтэй хуваалцаарай. Та зөвхөн гачигдаж байгаад нь л өг. Харин та хариу ач буян горьдож өгөх ёсгүй юм шүү.

## **ЗАЛБИРЧ НАМАНЧИЛЪЯ**

Залбираарай, чин сэтгэлээсээ залбираарай. Биднийг сэрээхэд тусалж буй Диваажинд, арван зүг, найман зовхисын бүх Будда нарт, Бурханд, бүх Сахиусан тэнгэрт залбираарай. Мах хэрэглэдгээсээ болж шууд болон шууд бусаар амийг нь хороож, тамлан зовоосон бүх амьтанд залбираарай - тэдний өршөөлийг эрж залбираарай. Диваажингийн хамгаалалт, өршөөлд багтаахыг гуйн залбираарай. Орон гэр болсон эх дэлхийгээ амжиж аврахын төлөө ухаарч сэрээхэд маань туслахыг Бурхадаас гуйж залбираарай. Бид чин сэтгэлээсээ залбирч, үйл хэргээ

ч шаламгайлан бүтээх ёстой. Бид үүнийг дангаараа хийж үнэхээр чадахгүй.

Бид Газар дэлхий, түүний оршин суугчдад учруулсан бүхий л гарз хохирол, зовлон, хор хөнөөлөө наманчлан уучлал, өршөөлийг нь дахин дахин гуйх учиртай. Бид бас өөрийн үйлдлээ өөрчлөх ёстой. Нүглээ наманчлах хамгийн сайн арга бол өөрчлөгдөхийг хичээх явдал. Өөрчлөгд, сайн зүйлийг л хий. Муу бүхнийг цээрлээрэй.

**Бид бурхан тэнгэрийн хүч Газар дэлхийд бууж ирээд удирдагчид, хэвлэл мэдээллийнхэн, нөлөө бүхий хүмүүс, дэлхийн бүх иргэнийг гараг дэлхийгээ аврах зөв алхмыг түргэн - хэтэрхий оройтохоос урьтаж хийхэд нь сэхээрүүлээсэй гэж залбирч болно шүү дээ. Учир нь энэ цаг мөчид бидэнд дэлхийгээ аврахад Диваажингийн оролцоо хэрэгтэй байна, тэднээс биднийг хамгаалаач гэж гуйж залбирах бус; веган шийдлийг хүн бүрд ухааруулж өгөөсэй гэж залбираарай, яагаад гэвэл энэ нь гараг дэлхийг аврах цорын ганц гарц юм.**

## **ВЕГАН ЧИГ ХАНДЛАГЫГ ЭХЛҮҮЛЬЕ**

### *Мэдээг түгээе*

Тоо томшгүй олон хүнийг амьдралын илүү дэвшилтэт хэв маягт шилжихэд хүргэхүйцээр бодит байдлыг ухаарахад нь тусалж буй хүмүүс үнэхээр л чиглэл салбар бүрийнхээ анхдагчид, бидний цаг үеийн жинхэнэ баатрууд, зүй ёсны одод нь юм.

Бид мэдээ, мэдээллийг түгээх шаардлагатай, гараг дэлхийдээ санаа зовж яваа хэн боловч мэдээ мэдээллийг түгээх эрхтэй. Тэгсэн цагт хүмүүс бидэнтэй нэгдэнэ.

### *Төр засаг, хэвлэл мэдээллийнхэнд захидал илгээе*

Илүү холч үр дүнд хүрэхийн тулд та төр засгийн удирдлага, мэргэжилтнүүдтэй холбоо тогтоож, манай цахим хуудас [SupremeMasterTV.com] дахь мэдээллээс хэрэглэн тэдэнд манай дэлхийд нүүрлэж буй нөхцөл байдлын талаар бичиж, мэдээлж болно. Уг цахим хуудаст буй бүх мэдээллийг татах, хуулах, илгээх боломжтой.<sup>146</sup>

Төр засаг энэ байдлыг ухамсарлаж ойлгосон байгаа. Магадгүй Засгийн газар өөр асуудлыг тэргүүлэх чиглэлээ болгож байгаа. Тэгэхээр хэрэв та болон бусад иргэд санаа зовниж байвал Засгийн газартайгаа холбоо тогтоож, бидэнд болон бидний хойч үед тулгараад байгаа энэ асуудал нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай түвшинд хүрчихсэн байгааг сануулан, тэдэнд захидал ч атугай бичиж, нөхцөл байдлын талаар мэдээлээрэй.

Төр засгийн удирдагч нарт веган шийдлийн талаар бичиж, хэрэв боломжтой бол очиж тэдэнтэй уулзаарай. Удирдагч нар улс эх орондоо нүүрлээд буй сүйрлийг ухаарч байгаа. Хэрэв одоо иргэд нь тэдэнд дэмжлэг үзүүлээд, уур амьсгалын өөрчлөлтөд санаа зовниж байгаагаар, энэ нь тэдний хэрэгцээ сонирхолд хамгийн ихээр нийцнэ гэдгийг сануулбал тэд уг асуудлыг илүү эрч хүчтэй хөндөх болно. Тэгвэл Дэлхийн дулаарал бол хамгийн чухал сэдэв, энэ нь өөрсдөд нь болон үр хүүхдүүдэд нь бас нөлөөлөх учраас тэд үүнийг мэргэжилтний хувьд төдийгүй хувь хүнийхээ хувьд хүлээх үүрэг гэж үзэх болно.

Заримдаа ерөнхийлөгч дангаараа шийдвэр гаргаж чадахгүй учир зөвхөн ерөнхийлөгчид бус засгийн газрын бүх гишүүнд бүгдэд нь бичээрэй. Төрийн байгууллагын боломжтой бүх газарт захидал бичээрэй. Хүн бүр үүнийг хамтдаа хийе. Тэгээд шийдвэрийг гаргуулахын тулд бичсэнээ олон хувь хувилж, ерөнхийлөгч болон гол байгууллага, газруудад хүргүүлсе.

Олон олноор нь бичээрэй. Мэйлээр, факсаар явуул, захидал илгээ. Сонинд бич. Радиоогоор ярь. Телевизээр ярь. Ярилцлага хий. Мэдэх хүн болгондоо хэл. Хаа чадах газраа ухуулга хий, нөлөө үзүүлэхийг хичээ. Өөрийн мэдэх удирдагч нартай ярилц. Хэрвээ таньж мэдэхгүй бол тэдний найз нөхөд, танилууд, зөөгч, гэрийн үйлчлэгч, цэвэрлэгч, жолооч, гэр бүлийн гишүүд, хүүхдүүд, таны хүүхэдтэй нэг сургуульд явдаг хүүхдүүд, тэдний ажилтнууд, нарийн бичгийн даргатай, ер нь удирдагчийн чихэнд зохистой хэлбэрээр дуулгаж чадах хүн бүртэй ярилцаарай.

Удирдагчид ямар нэгэн нааштай алхам хийвэл тэдэнд баярласнаа илэрхийлэн захидал илгээж урам өгөх хэрэгтэй. Бид тэднийг урамшуулах хэрэгтэй. Бид тэднийг зөв үйл хийхэд нь урам зориг өгч, хөхиүлэн дэмжих хэрэгтэй бөгөөд ингэвэл тэд цаашид ч энэ замаараа замнах буюу бүр сайжран хөгжих болно.

Би Ерөнхийлөгч Обама, Европын парламент, Европын Худалдааны Төлөөлөгч нарт захидал бичсэн бөгөөд тэд ч надад хариу ирүүлсэн. Тэд миний хэлсэн сэрэмжлүүлгийг анхааралдаа авна, миний үг, миний зөвлөгөөг зүрх сэтгэлдээ, ухаан санаандаа хадгалж явах болно гэж хэлсэн. Би сонсож чаддаг удирдагч нарт талархаж байна.

## ***Иргэдийн хөдөлгөөн, веган чиг хандлагыг манлайлъя***

Иргэдэд зориулж семинар, сургалт хийе. Дэлхийн дулаарлаас гарах шийдлийн талаар олон нийтэд мэдээлэл өгч, нотолгоо харуулъя. Бусад цагаан хоолтонтой хамтран зүтгэе. Бүгд хамтран ажилласнаар үр шим арвижиж, гараг дэлхийг аврах болно.

**Хувь хүн, нийгмийн бүлгүүд засгийн газрын гарыг харж, эсвэл технологи хөгжихийг хүлээж суухын оронд өөрсдөө арга хэмжээ авах хэрэгтэй. Энэ тун энгийн. Зөвхөн ганц л шийдэл бий: энэрэнгүй**

**хүнс хэрэглэх, яагаад гэвэл нигүүлсэл нигүүлслийг л төрүүлдэг.** Энэ бол ертөнцийн хамгийн энгийн хууль. Үйлдэл болгон хариу үйлдэлтэй. Тэгэхээр бид Засгийн газрын бодлого батлагдахыг, эсвэл санхүүгийн нөөц бололцоо зэргийг хүлээх хэрэггүй.

Орон нутгийн түвшинд та өөрөө хоолны хичээлийг хариуцан явуулж болно. Ингэх нь амттай, тэжээллэг веган хоолыг өөртөө болон гэр бүлийнхэндээ зориулж хийх ямар хялбар болохыг ойлгоход хүмүүст тус болно.

Түүнчлэн маш шуурхай, амттай, тэжээллэг веган хоолоор үйлчлэх Loving hut (Ловинг Хат буюу Хайрын Өргөө) нэртэй веган хоолны зоогийн газрын сүлжээ бий болгох санаа надад төрж биеллээ олсон. Одоо маш олон болсон. 90 гаруй [шинэчилсэн тоогоор 138] Хайрын Өргөө зоогийн газар Формоса (Тайвань)-гаас авхуулаад Франц, АНУ, Австралид болон олон оронд нээгдсэн.<sup>147</sup> Тэдгээрийг худалдааны төв, зам тээврийн гол уулзвар гэх мэт их хөлийн газруудад нээж байна.



“Хайрын бэлэг” телевизийн шоугаар гаргаж байсан Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн амтат веган хоолнуудын нэг [SupremeMasterTV.com/gol](http://SupremeMasterTV.com/gol); [SupremeMasterTV.com/veg](http://SupremeMasterTV.com/veg)

Бусад хүн ч бас веган хоолны зоогийн газар нээж болно шүү дээ, хүн бүр. Хүмүүс тийшээ заавал веган хоол идэхээр очих албагүй шүү дээ, харин ердийн сайхан хоол гэж бодоод, мөн хөгшин залуу гэлтгүй үйлчлүүлэгчдийн тэмдэглэснээр “Махнаас ч дээр юм гээч!” гэж үнэлээд очдог. Тэгэхээр веган хоол, бүтээгдэхүүнийг хүмүүст хүртээмжтэй элбэг болгочихвол энэ нь жинхэнэ боломжит сонголт болно.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн санаачлан байгуулсан, эрчимтэй хөгжиж байгаа Хайрын өргөө (Loving Hut) олон улсын веган зоогийн газрын сүлжээ нь ВежНьюс сэтгүүлээс дэлхийн Олны таашаалд нийцсэн зоогийн газар ангилалд 2010 Вежжи (Veggie) шагналыг хүртсэн.

Одоо хүмүүс энэ тулгамдсан хямралыг шийдэхийн төлөө нэгдэж байна. Хаа сайгүй байдал дээрдэж, хүлээн зөвшөөрч байгааг би харж байна.

Би бусдын сайн сайхны төлөөх зүтгэлийг, бүх ард түмэн, хувь хүн, хамт олон, байгууллагууд энэрэнгүй өгөөмөр тусламжийн гараа сунгаж буйг харж байна.

Би хайр энэрэл янз бүрийн замаар өргөжин тэлж байгааг харж байна.

Эдгээр шинж тэмдэг одоохондоо дорвитой биш санагдаж магадгүй, гэвч энэ бол нэг их удалгүй өнгөрсөн үеийн мунхаглал, өс хонзонг үнс болтол шатааж, Газар дэлхий дээр илүү эрхэм ариун, гэгээлэг хүн төрөлтний эхлэлийг тавих их галын цучил мөн.

Зөвхөн эерэгээр сэтгэж, хөршүүддээ ойлгуулахын тулд чадах бүхнээ хийгээрэй. Газрын диваажинг амьдралынхаа мөрөөдөл болгож, хойч үедээ дамжуулан залгамжлуулаарай.

Бид хамтдаа. Бид айх айдасгүй. Бид хүчтэй. Бид дэлхийг өөрчлөх хүсэл эрмэлзэлтэй. Бид зоригтой. Бид амар амгалан, аюулгүй, энэрэнгүй дэлхийг хүсдэг бүх хүн төрөлхтөнтэй хамт.

Тэгээд бид бүгд үүнийхээ үр шимийг хүртэнэ! Зүтгээд байгаарай, гуйя.

# 6

## ХҮН ТӨРӨЛХТӨН АЛТАН ЭРИНД ҮСРЭНГҮЙ ШИЛЖИХ НЬ

Дэлхий дээрх Бурханы хүүхдүүд, өгөөмөр захирагч, хамгаалагч, ертөнцийн бүтээлүүдийн үнэнч шударга оргил шиг өсөж дэвжих, хувьсах, өндөрт хүрч өөрчлөгдөх цаг бидэнд ирээд байна. Биднийг хүлээж буй энэрэл, эв зохирол, нинжин сэтгэл, жинхэнэ энх амгалангийн Алтан Эринд хөл тавих гайхамшигт үсрэлтийг бүгдээрээ, хамтдаа хийе. Бид үүнийг хийж чадна гэдгийг би мэдэж байна.

### I. ХҮН ТӨРӨЛХТНИЙ ХӨГЖЛИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГ

Ойлгож байна уу, зөв чиглэлд хүн бүрийн хийх ганц л жижиг алхам нь нийт хүн төрөлхтний хувьсалд томоохон үсрэлт гарахад хүргэнэ. Тэрхүү жижиг алхмыг хийхэд маш энгийн. Энэ нь ердөө л: алж хөнөөхгүй байх. “Амьдрах ба амьдрах боломжийг олгох” хэмээх зарчмыг мөрдөн, бусдад амьдрахыг зөвшөөрснөөр өөрөө аврагдана гэсэн ертөнцийн хуулийг сахих явдал юм. Учир нь, бид бүхний мэддэгчилэн ижил нь ижлээ татна шүү дээ. Үүнд мэдээж, веган хүнс хэрэглэх нь багтана.

Хүмүүс төрөлхийн маш өгөөмөр, зүрх сэтгэлдээ амар амгалан байдаг; бид ердөө л маш урт хугацааны туршид буруу мэдээлэл авч, буруу ойлголттой болсонд гол учир байгаа. Мах идэх, сүү уух, загас, өндөг бидэнд сайн гэж бид бодсон. Энэ бүгд буруу шүү. Харин ч бүгд эсрэгээрээ. Мах, загас, сүү, өндөг зэрэг “бидэнд сайн” гэж хэлдэг байсан амьтны гаралтай бүтээгдэхүүнүүд тийм сайн биш гэдэг нь батлагдчихсан шүү дээ. Энэ нь сайны эсрэг тал юм. Эдгээр зүйл биднийг өвчин зовлонд унагаж, өвчнийг эдгээх болон амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн алдагдлыг нөхөхөд татвар төлөгчдийн мөнгөнөөс маш их хэмжээгээр зарцуулж, алдагдалд оруулж байна.

Бид төөрөлдсөөр их уджээ. Одоо бид судалгаа хийх хэрэгтэй. Бид ухаалаг эмч, эрдэмтдийнхээ үгийг сонсох хэрэгтэй. Мах, амьтны гаралтай бүтээгдэхүүн бидэнд үнэхээр хортой болохыг илрүүлсэн судалгааны үр дүнг бид харж ухаарах хэрэгтэй. Бид одоо, ялангуяа хүүхдүүдийнхээ ач тусын төлөө үүнийг зогсоох ёстой. Бид хүүхдүүдээ үргэлжлүүлэн хордуулж болохгүй; тэд чинь сул дорой. Хөөрхий хүүхдүүд маань бидэнд найддаг, тэд биднийг сайн мэдэж байгаа л гэж боддог, гэвч энэ бидний ч алдаа биш юм. Бид зүгээр л буцаж сайн дадал руугаа шилжих хэрэгтэй.

Yaгаад бидний алдаа биш вэ? гэвэл бидэнд ингэж зааж өсгөсөн. Эмээ өвөө, элэнц хуланц нар маань ч бас ийм арга замаар заалгасан. Өдөр тутмын амин зуулгаа залгуулах гэж маш их завгүй ажилладаг тул бидэнд судалгаа хийх цаг гардаггүй, тиймээс эдгээр зүйл бидэнд үнэхээр хортой гэдгийг бид мэддэггүй байжээ.

Юу юунаас илүү энэ байдал манай дэлхийг идэж устгаж байна. Зөвхөн хүмүүс, амьтдыг устгаад зогсохгүй дэлхийг ч устгаж байна. Дэлхийгээ аврахын тулд бид үүнийг зогсоох ёстой. Бид ердөө буцаад эргэхэд л болно. Зүгээр л эсрэг чиглэлд, дахин ямар нэг зовлонгийн шалтгаан болохгүй зөв замаар алх; бусдын амийг нэмж хөнөөлгүй, бүхий л амьтан, бүтээлийг хайрлаж, хамгаал. Хүн төрөлхтөнд хэрэгтэй байгаа үсрэлт бол энэ л юм.

Энэ үсрэлтийг хийсний дараа бид тэс ондоо байдлыг мэдэрнэ. Бид ухамсрын илүү дээд түвшинд дэвшсэнээ аяндаа мэдэрнэ. Бид хүчтэй, ухаантай, чадварлаг гээд төсөөл дөө. Бид бүх төрлийн хүнсийг тариалж чадна. Бидэнд хэзээ ч ямар ч хор хүргэж байгаагүй эдгээр бяцхан, сул дорой, гэм зэмгүй амьтдыг зовоон хөнөөж, доромжилж, тамлаж, туйлдуулахад бид хүч чадал, чадавх, оюун ухаанаа хэрэглэх ёсгүй. Хуулийн дагуу яривал тэд гэм зэмгүй. Хэрвээ бид гэм зэмгүй амьтныг алж хөнөөвөл, шийтгэл амсах эзэд нь бид өөрсдөө байх болно. Таныг гомдоосон бол уучлаарай, гэхдээ энэ бол үнэн. Та үүнийг ойлгосон гэдэгт би итгэлтэй байна.

Энэхүү хөгжлийн үсрэлтийг хийснээр бид айдас, хүслээ орхиж, энх амгалан, хайр, гэгээрлийн жинхэнэ амьдрал өөд явна — аллага, зовлон шаналал, хүчирхийллийн тойргоос гарч, нинжин сэтгэл, хамгаалал, аз жаргалын тойрогт орж ирнэ.

Хүчгүй нь хүчтэйгээс хэзээ ч айдаггүй, хүчирхийлэлгүй, хол ойрын хөршүүдийн хоорондох тэмцэл үгүй, хором бүр, өдөр бүр өлсөх, цангах, өвдөхийн эрхээр хүүхдүүд энддэггүй, ээж нар нь зовж эндсэн хүүхдэдээ тусалж чадалгүй гаслан харж суух явдалгүй тийм хорвоог бид төсөөлж чадах уу?

Намайг ярьж байх энэ зуурт хаа нэгтээ олон хүүхэд эндэж байна. Хэдэн хором тутамд нэг хүүхэд өлсгөлөнгөөр эндэж байна. Бид цаашид үүнийг үргэлжлүүлж болохгүй. Цаашид удаан хүлээж болохгүй. Бид тэдний амьдралыг аврах ёстой — амьтны төдийгүй хүүхдийнхээ амийг,



өөрийн биш байсан ч хамаагүй, бусдын хүүхдүүдийг аврах хэрэгтэй.

Мах нь өлсгөлөн, дайныг өдөөдөг учраас маш их зовлон тарьдаг. Махны үйлдвэрлэлийг дэмжихэд бид хамаг л үр тариа, будаа, шар буурцаг, хэрэгцээт нөөц, газар нутаг, усаа барж байгаа учраас энэ хорвоо ус, хүнсээр гачигдаж байна. Тиймээс, амьтай бүхнийг аврахын тулд бид махны үйлдвэрлэлийг зогсоох ёстой.

Бидний одоо амьдарч байгаа хэв маяг бол бидний жинхэнэ доройтол. Бид бол хайр, нинжин сэтгэл бүхий Эзэн Бурханы хүүхдүүд. Бид Диваажингийн өв залгамжлагчид. Бид ердөө үүнийгээ мартчихсан. Бурхан дэлхий дээр бууж ирээд нүдэндээ харагдсан болгоныг алж идэж байхыг та төсөөлж чадах уу? Уучлаарай, хэрэв тийм Бурхан байдаг бол би Түүний хүүхэд байхыг хүсэхгүй. Та тийм Бурханы хүүхэд байхыг хүсэх үү?

Тийм ээ, үгүй. Баярлалаа. Баярлалаа. Та нар их сайхан сэтгэлтэй юм. Тэгэхээр Бурхан тэр чигтээ өгөөмөр, нигүүлсэл энэрэнгүй, бүхнийг хайрлагч бөгөөд бид Түүний хүүхэд юм бол бид Дэлхий дээр Бурханы хүүхэд шиг л байх ёстой гэж танд санагдахгүй байна уу?

Бид хайр, энэрлийн замаар явах ёстой. Түүний алдрыг мандуулахыг хүсэж байвал бид Эцгээ төлөөлөх ёстой. Бид өдөр бүр “Тэнгэрт, Газар дээр таны алдар дурсагдах болтугай” гэж залбирдаг билээ. Гэвч Түүний нэрийг алдаршуулах ямар зүйлийг бид хийдэг вэ? Бид Түүнийг төлөөлөх ёстой.

Бурхан нигүүлсэнгүй, энэрэнгүй, хамгаалагч, хайрын сэтгэлтэй гэж итгэдэг учраас бид Түүнд үргэлж залбирдаг. Бурханы хүүхдүүдийн хувиар бид эдгээр чанарын илтгэгч байх ёстой. Бид өөрсдөө эдгээр чанар юм: Бид бол хайр, сайхан сэтгэлийн илрэл. Бид ердөө буруу залагдаж, буруу мэдээлэл авч, бас өөрсдийнхөө мөн чанарыг мартсан байна. Тиймээс ердөө л эргэн саная. Эдгээр чанар бидний дотоод сэтгэлийн гүнд байдаг, тиймээс бид эргэн тойронд маань нүдэнд үзэгдэж байгаа зүйлсээс хавьгүй сайхан ямар нэг зүйл байдаг гэдгийг мэдэрдэг.

Зөвхөн бурханлаг багш нар төдийгүй гүн ухаантан Платон, төрийн зүтгэлтэн Сократ, математикч Пифагор, Америкийн яруу найрагч Ралф Валдо Эмерсон шиг сэтгэлийг ихэд хөдөлгөн сэргээхүйц амьдралаараа дурсагдсаар байгаа хүмүүсийн жишээ хүн төрөлхтний түүхийг өнөөг хүртэл гэрэлтүүлсээр байна. Тэд бүгд цагаан хоолтон байв. Та гайхаж байна уу? Магадгүй та гайхахгүй байх. Надад та гайхсан янзтай харагдахгүй байна. Тэгэхээр бид энэ бүгдийг мэдэж байжээ. Бүх аугаа хүн цагаан хоолтон, эсвэл веган байжээ. Хэрвээ тэдний талаар сайтар судалбал соёл иргэншилт амьдралын үндсэн цөм нь веган хоолны дэглэм хэмээн тэд сургаасан байдгийг олж мэдэх болно.

Веган хоолны дэглэм бол нигүүлсэнгүй, бусдад хор хөнөөлгүй, байгаль орчноо гэмтээхгүй амьдрахын хамгийн том, цорын ганц, эхний алхам. Махны гаралтай бүх хүнс нь веган хоолтой харьцуулахад 14 дахин их ус, 6 дахин их үр тариа, 10 дахин их эрчим хүч, 20 гаруй дахин

их газар нутгийг ашиглаж, нэн үнэ цэнтэй ширэнгэн ойг устгаж байна.

Веган байх нь бидэнд байгаа цорын ганц гэр эх дэлхийг хамгаалахын зэрэгцээ ач буянтай сайн үйл шүү дээ. Бид гараг дэлхийдээ, түүний оршин суугчдад хэдийчинээ бага зовлон, хохирол учруулна төдийчинээ бага үйлийн үрийг нөхөн төлөх хэрэгтэй болно. Гэвч одоо бид илүү их зовлон амсах үрээр төлж байна, хэрвээ бид мах, мал үржүүлгийн үйлдвэрүүдийг зогсоохгүй бол үүнээс ч илүү төлөөс төлөхөд хүрнэ.

Хамаг амьтанд хайр энэрэл, хамгаалах сэтгэлээ хэдийчинээ их үзүүлнэ, бид дэлхий дээр төдийчинээ аугаа байж, зүрх сэтгэлдээ ч, Диваажингийн Хаант улсад ч аугаа мэдрэмжтэй байх болно. Тийм учраас л аугаа Их Багш нар, мөн өнгөрсөн үеийн бусад гэгээлэг сүнснүүд бидэнд дахин дахин захиж сургамжилсан байдаг нэг л ижил зүйл бол хэрвээ бидэнд гэм хор бүү хүргээсэй гэж хүсэж байвал бид өөрсдөө бусдад гэм хор учруулахгүй амьдрах ёстой гэсэн сургаал юм. Та бүх шашныг судалж үзэх юм бол тэнд нэг л зүйлийг дахин дахин хэлдэг, бүгд ижил, нөгөө л өгүүлбэр, энэ л утгыг. Бидэнд сайн байх бүхнийг бусдын төлөө хийх хэрэгтэй; тэгж бид тарьсан бүх зүйлээ алдаа эндэгдэлгүй хурааж авна. Тийм учраас л тэд амьтныг идэлгүй, веган бай гэж бидэнд сургаж байсан.

Хэрвээ бид энэ үсрэлтийг хийвэл хоол хүнсэндээ багахан өөрчлөлт оруулж, махны оронд, амьтны уургийн оронд гэртээ тэргүй ургамалд байдаг нэгдүгээр зэргийн уургийг хэрэглэх болно. Амьтны гаралтай уураг бол хоёрдугаар зэргийнх. Яагаад? Учир нь амьтад нэгдүгээр зэргийн ногоо, жимсийг идсэний дараа нь бид тэдний махыг идэж байна. Тиймээс л хоёрдугаар зэргийнх юм. Хүмүүс бид яагаад хоёрдугаар зэргийн хүнс сонгох гэж? Энэ бидэнд тохирохгүй. Тиймээс бид энэ үсрэлтийг хийх ёстой.

**Ноёд хатагтай нар аа, бид энэ үсрэлтийг хийх ёстой, учир нь бид үүнийг хийж чадвал, амь насны эрсдэлгүй — жил бүр хэдэн арван тэрбумаараа зуурдаар эндэж үрэгдэх явдалгүй энх амгалан цагийг тунхагласан Алтан эрин тэр даруй ирэх болно! Түргэн зуурын таашаал авахын төлөө тамлан зовоож, хөнөөдөг амьтдын махыг бид хэдийд ч орлуулж болно. Мах бол орлуулж болдог зүйл.**

Бидний хараахан нээгээгүй, эдэлж үзээгүй дэлхийн маш олон гайхамшиг байна. Илрүүлж, судалж, зохион, хөгжүүлэх маш олон шинжлэх ухааны мэдлэг, ер бусын технологиуд байна! Илүү сайхан нийгмийн тогтолцоо байна. Эдгээр нь бидний өнөөгийн түвшнээс, тэр бүү хэл бидний төсөөлж чадахаас ч хэтийдсэн зүйлс байдаг, харин бид билэг ухаан, бүтээлч хүчээ нээснээр эдгээр нээлтийг хийж чадна.

Энэ билэг ухааныг нээхийн тулд бид эхлээд түүнийг хааж, далдалж байгаа хортой, саад учруулагч бодистой мах, сүү, загас, шувуу зэрэг бүх төрлийн мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг зайлуулах хэрэгтэй. Эдгээр зүйл бидний оюун ухаанд саад тотгор учруулж, сүнслэг, ёс зүйн төдийгүй техникийн дэвшилд хүртэл саад болдог.

Эцэст нь хэлэхэд, бид алтан эринтэй золгохыг хүсэж байгаа хувийн шалтгаанаас гадна одоо хэзээ мөдгүй алдчихаж магадгүй аюулд өртөөд байгаа эх дэлхийдээ анхаарал хандуулж аврах хэрэгтэй, үүнийг та бүхэн мэдэж байгаа гэдэгт би итгэлтэй байна. Тиймээс ухамсрын түвшинд хийх энэ үсрэлт бидний гараг дэлхийг ч, эв найрамдалтай ертөнцөд амьдрах хувьтай бусад төрөлтнийг ч аварна.

Хэрвээ хүн бүр энэ үсрэлт буюу шилжилтийг хийх юм бол гараг дэлхий маань аврагдах болно. Би өөрийнхөө нэр төрөөр амлая, Бурхан гэрчлэг. Үүнтэй зэрэгцэн бид өнө удаан хугацаанд хүрэхээр хичээл зүтгэл гаргасан тэр дэвшилд өөрсдийгөө хүргэх болно.

## **ХҮМҮҮН ТӨРӨЛТӨН ДЭВШИЛД БЭЛЭН БАЙНА**

Хүмүүн төрөлтөн ухамсрын илүү дээд түвшин рүү дэвших цаг нэгэнт иржээ. Хүмүүс бид эрхэм ариун, сайхан сэтгэлтэй, энэрэнгүй байх ёстой. Веган байх, сайн үйлийн үр тарих, байгалиа хамгаалах нь зөвхөн эх дэлхий гаргийн төлөө хийж байгаа зүйл биш, энэ бол хүн төрөлтнийг бүхэлд нь сүнслэг буян, жинхэнэ мөн чанарын хувьд өөд нь татахын төлөө хийж байгаа зүйл. Эрхэм ариун байхын төлөө тэд үүнийг хийх хэрэгтэй.

Бид зүрх сэтгэлийнхээ дотоод энэрэнгүй, халамж дүүрэн мөн чанартаа буцаж орох хэрэгтэй. Энэ маш энгийн. Бидний уг чанар юм. Бид өгөөмөр, энэрэнгүй, хайр халамжаар дүүрэн хүмүүн.

Хүн, амьтан, байгаль болон Диваажингийн хооронд бий болох жинхэнэ эв зохирлыг харахыг үнэхээр хүсэж байвал бид өөрсдөө эв зохиролд аж төрж, амьдарч, үйлдэх ёстой бөгөөд үүнд ширээний ард суух бүрдээ зохистой байдлаар хооллох ч хамаарна.

Иймд веган сонголт хийх нь хүн төрөлтний сайн сайхан, өөдөө ахих хувьсал хөгжилд гарах жинхэнэ дэвшил мөн. Ижил нь ижлээ, сайн сайхан нь мөн сайн сайхныг тагдаг гэдгийг мэдэж авна. Бид энэрэнгүй үнэнийг бусадтайгаа хуваалцах юм бол хүмүүс бид өөрсдөө төдийгүй дэлхий нийгээрээ ч бас улам өөдлөн дэвжинэ.

## **II. ДЭЛХИЙ САНСАР ОГТОРГУЙН ДЭЭД СОЁЛ ИРГЭНШИЛД ДЭВШИЖ БАЙНА**

Манай гаргийн дэвшлийн тухайд гэвэл, энэ нь манай гарагт зориулсан орчлон ертөнцийн төлөвлөгөө бөгөөд үүний дагуу бид сүнслэг хөгжил өндөртэй гаргуудтай цуг дэвжин дээшлэх ёстой билээ. Ийм л төлөвлөгөө юм. Гэвч хүн төрөлтнүүдэд чөлөөт хүсэл зориг, сонголт хийх эрх олгосон байдгийг тэд ухаалгаар хэрэглэхгүй байна.

## АНГАРАГ БОЛОН СУГАР ГАРГИЙН СУРГАМЖААС СУРАЛЦЬЯ

Дэлхий маань галактикийн бусад гарагтай хөл нийлүүлэх нь бидний алсын хараа. Хэрвээ бид энэ мөчид зөв өөрчлөлт, зөв сонголт эс хийх аваас бидний алсын хараа хий хоосон зүйл болон хувирч, сүйрэлд хүргэж болзошгүйг хөрш Ангараг, Сугар гаргуудын туршлагаас харж ойлгох хэрэгтэй.

Яг одоо бидний амсаж эхэлж байгаатай төстэй уур амьсгалын эрс өөрчлөлтийг өмнө нь Ангараг, Сугар гараг туулсан гэдгийг гараг судлаач эрдэмтэн бүхэн мэддэг. Ангараг, Сугар гаргууд эрт цагт манай гарагтай тун төстэй байсан –устай, бидэнтэй төстэй хүн төрөлтөн, амьдралтай байсан. Гэвч Ангараг, Сугар гаргийн оршин суугчид малын тоо толгойг хэт их өсгөж, Ангараг гарагт л гэхэд ялгарсан хорт хийн хэмжээ нь хүлэмжийн хийн нөлөөг өөрчлөх боломжгүйгээр даамжруулснаас гадна хорт хүхэрт устөрөгч ихээр ялгарснаас болж тэд гаргаа-гэр орноо сүйтгэсэн билээ. Тийм учраас л бид тэртээ нэгэн цагт байсан газрын хэлбэр, далайн ул мөрийг тэнд олж хардаг.

Ойролцоогоор 5 тэрбум гараг сүйрсэн буюу Ангараг, Сугар лугаа хувь зохиолтой болжээ. Өндөр түвшний бус, зөвхөн доогуур түвшний ухамсар бүхий оршин суугчидтай гаргууд сүйрч үгүй болсон.

Сугар гаргийн агаар мандал хэт халж,  $\text{CO}_2$  — нүүрсхүчлийн хийд автсан. Тиймээс ч эрдэмтэд үүнийг “хяналтаас гарсан дэлхийн дулаарал” гэж нэрлэдэг бөгөөд манай Дэлхийн ирээдүй ийм болж магадгүй хэмээн үздэг.

Сугартай адил устаагүй гаргууд нийтээрээ веган болсон тул аврагдсан – би аврагдсан гаргуудыг л хэлж байна. Дөрвөн Сугар гараг байсан тухай би дурдаж байсан. Тэдний зөвхөн хоёр нь нийгмээрээ веган болсны ачаар аврагдсан. Нөгөө хоёр Сугар гаргийнхан веган хоолонд шилжээгүй тул сүйрсэн- нэг нь бүр мөсөн сөнөж, нөгөө нь оршин суух боломжгүй, буцлам халуун болсон.

Веган хоол хүнс шийдэл болохыг Ангарагийн ихэнх оршин суугч тоож сонсоогүй эсвэл мэдээгүй. Ангарагийнхан ийм аюулыг нэгэнтээ туулж, тэр гунигт сургамжаа хэзээ ч мартдаггүй. Тэд сэтгэл гарган Дэлхийн хүмүүст биднээр дамжуулан захиасаа хүргүүлсэн. Захиасандаа: Буянтай бай, дэндүү оройтохоос урьтаж орон гэрээ авар гэсэн байна.

Бид үүнд дөхөж очоод байна; буцах замгүй болох цэгт бид бараг л ирчихээд байна. Тийм учраас л бид яг одоо энэ шийдлийг, веган хүнс хэрэглэх захиасыг эцэж цуцалтгүй түгээх гэж хичээж байна. Үүнд ёс суртахууны хүч чадал агуулагдаж байгаа учраас дэлхийн дулаарлыг таслан зогсоох материаллаг түвшний хүчийг санал болгож байна. Энэ нь “ижил нь ижлээ тагдаг” гэсэн шинжлэх ухааны ойлголттой нийцдэг. Бид аливаа амийг хүндэтгэх ёстой, тэгвэл бидэнд мөн амьдрал хайрлана.

## САНСАР ОРТОРГУЙД ЭРХЭМ НАЙЗ НӨХӨД БИДНИЙГ ХҮЛЭЭЖ БАЙНА

Цагаан хоолтон-бус олон гараг ертөнц байдагчлан, цагаан хоолтон гараг бас олон бий. Энэ нь тоймгүй олон. Зөвхөн манай галактикт л гэхэд хэдийнээ тоолж барамгүй олон бий. Цагаан хоолт нийгэмтэй эдгээр энэрэнгүй гараг хөгжлөөрөө биднээс түрүүлсэн. Тэдэнд бүр нисч аялахад зориулагдсан бүс шиг төхөөрөмж бий. Бидний хэзээ ч мөрөөдөж байгаагүй өчнөөн олон гайхамшигт зүйл тэдэнд бий.

Эдгээр нийгэмд хүмүүс нь зав чөлөөгөөрөө амарч баясах, авьяас, сонирхлоо хөгжүүлэх, нуугдмал чадвараа нээн илрүүлэх цаг ихтэй. Тийм учраас ийм нийгэмд олон гайхамшигтай нээлтийг хийсэн байдаг. Хүмүүс нь амар амгалан бөгөөд хамгийн сайн чаддаг зүйлээ хийдэг учраас олон гайхамшиг тохиодог. Хэн ч материаллаг хэрэгцээний зүйлээр гачигдана гэж санаа зовнидоггүй учраас амьдрал нь эрх чөлөө, аз жаргалаар дүүрэн. Энэ гайхамшигтай сайхан сонсогдохгүй байна гэж үү?

Ийм гаргууд мөн л нийгмээрээ веган байдгийг би хэлсэн. Тэдний амьдралын үзэл баримтлал маш тодорхой – аминч бус, нөхцөл болзолгүй хайр, маш оюунлаг. Ийм хөгжингүй дэвшсэн, аз жаргал, баяр хөөрөөр бялхсан, нийгэм нь веган биш гаргийг би ер үзээгүй.

Бид ийнхүү аллага, хүчирхийллийг зогсоомогц бидний үүсгэх илүү их хайр бүхий найрсаг, урин дуудсан зочломтгой уур амьсгал нь огторгуйн бусад ариун төрөлтнүүдийг бидэнтэй нэгдэх, эсвэл холбоо барихад хүргэж мэднэ.

Хэрвээ золоор бидэнд ийм гараг, эсвэл ийм хөгжилд хүрсэн төрөлтнийг мэдэх завшаан таарах аваас бид тэнд очихын хүслэн болж, энэ дэлхийн ямар ч олз омог, буруутгалыг тэгтлээ их тоохоо болино. Тэдэнтэй нийлэх завшаан гардаг л юм бол бид энэ дэлхийгээс хэдийд ч хамаагүй явна. Гэвч бид сүнслэг талаараа ч, оюун ухаанаараа ч, сэтгэл зүй, ёс суртахууны хувьд ч тэдний дайтай хөгжөөгүй байна, бидний зарим нь тэр түвшинд хүрээгүй байна, тиймээс бид тэдэнд их ойртож нэгдэж чадахгүй, манай гараг тэдэнтэй эн зэрэгцэж чадахгүй байна.

Тиймээс тэд тэсэн ядан хүлээж байна. Тэд биднийг одот ертөнцийн тогтолцоотой мөр зэрэгцэхийн тулд илүү хөгжих хэрэгтэйг, мөн сүнслэг ойлголт, оюун ухааны чадамж, түүнчлэн технологийн түвшинээ дээшлүүлэхэд маань туслахад ямагт бэлэн гэдгээ илэрхийлсэн захиасаа бидэнд дамжуулсаар байна.

Тэд бас хүсэл сонирхлоо бидэнд тулгахгүй. Тэд биднийг бэлэн болохыг хүлээсээр, хүлээсээр л байна. Бид орчлонгийн дээд хэм хэмжээст нийцэн амьдрах сонголтыг хийхгүй удах тусмаа дотоод дахь амар амгаланг олоход бэрхшээл учирч, түүнээс ч илүүтэйгээр орчлонгийн бусад төрөлтөнтэй эвлэлдэн зохицож нийцтэй байж бас чадахгүй. Бид хөрш гаргуудынхаа оршин суугчидтай холбоо тасарч,

тэдний оршдогийг мэдэхгүй болно.

Гэхдээ энэ бүхнийг өөрчлөхөд хэцүү биш. Бид ердөө л өөрсдийнхөө унаган, хайрлагч Би-дээ эргэн орох хэрэгтэй, учир нь энэ бидний уг мөн чанар. Бид бол хайр. Бид бол тэнгэрлэг. Бид бол нигүүлсэл. Бид бол энэ орчлонгийн хамаг сайн сайхан нь. Бид зүгээр л үүнийгээ мартчихаад байна.

### III. ДИВААЖИНГИЙН МӨРӨӨДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Дэлхийн хүмүүс яг одоо 100% веган болбол сайн үр нөлөө нь 60 орчим хоногийн дотор илрэн харагдана. Энэ бол ердөө л 8 долоо хоногийн хугацаа. Бид найман долоо хоногийн дотор л үр өгөөжийг нь харах болно. Мэдээж та ч үүнийг харах болно, нэн даруй үр дүнг харна. Гэхдээ дүр зургийг бүхлээр нь 8 долоо хоног, ердөө 8 долоо хоногийн дотор л ухаарч мэднэ.

Найман долоо хоногийн дотор бүх гамшиг зогсоно. Диваажинг ингэж л бүтээдэг. Та юу гэж бодож байна? Диваажин хаанаас ирдэг вэ? Диваажин бол хамаг төрөлтөн нэгэн ижил чигт үйлдэл хийдэг тэр газар юм. Би гаднах хэлбэрээр ижил гэсэнгүй, харин энэрэнгүй сэтгэл, хайраараа ижил түвшинд, сүнснийхээ мэдлэг, ойлголтоороо ижил түвшинд, эрхэм ариун чанараараа ижил түвшинд байхыг хэлж байна. Диваажин гэдэг энэ л юм.

Хэрэв бид Диваажингийн хэм хэмжээс, шаардлагыг биелүүлэхээр өгсөх аваас Диваажин биднийг угтахаар доош бууж ирдэг. Хэрвээ хүн бүр үүнийг ухаараад, хүүхдийнх шиг багахан алхмыг, ердөө ганц алхмыг, манай гаргийн хувь тавиланг шийдэх чухал алхмыг, веган байх алхмыг хийчихвэл бусад бүх зүйл бидний гуйхыг хүлээлгүй бидэнд ирнэ. Хэрвээ бид өршөөл нигүүлслийг үзүүлэх аваас бидэнд өршөөл нигүүлсэл ирнэ. Орчлонгийн хууль хэзээ ч алдаж байгаагүй.

Сөрөг, алан хядагч, хүчирхийлэл дүүрэн муу энерги өөрчлөгдөж, энэ гаргийн бүхий л оршин суугч, үүний дотор амьтад, мэдээж нэн тэргүүнд хүн төрөлхтөнд өгөөмөр, жаргалтай, тайвшруулахуйц, энэрэнгүй энерги болж хувирна.

Тэгвэл бид ямар янзын Дэлхий дээр амьдрах бол? Буцаад диваажин цогцлох болно. Бид гэнэт л энх амгалан болж, бүхий л үндэстэн, хүмүүс өөр хоорондоо, мөн хүн, амьтад хоорондоо ялгалгүй эрх тэгш гэдгийг гэнэт ухаарна. Ухаарал бидэнд гэнэт ирэх болно. Тайлбарлах ч хэрэг гарахгүй. Хүмүүс бүгдээрээ эрх тэгш гэдгээ гэнэт ухаарна. Бид болон бидэнтэй зэрэгцэн оршиж буй төрөлтнүүд, амьтад бүгд эрх тэгш. Хүмүүс ургамал, модыг хүртэл хүндэтгэн харилцах болно.

Бид амьдралын хэв маягаа тэнгэрлэг чанартай болгон өөрчлөх аваас бидний дотоодын тэнгэрлэг оюун ухаан дахин сэргэж, улмаар

бидэнд төгсгөлгүй олон шинэ нээлт бүтээл, ая тух хурууны үзүүрээр л ирдэг болно. Бид нисдэг машинтай болно, би одоо хийж байгааг бус, харин бүр илүү ая тухтайг хэлж байна. Бусад гаргийнханд байдаг шиг нисдэг бүстэй ч болж магад шүү дээ.

Бидний шинжлэх ухаан, технологийн ойлголт ч бас Дэлхийгээсээ халих болно. Яагаад гэвэл дэвшингүй, энэрэнгүй уур амьсгал маань бидэнд илүү дэвшилтэт гаргийн хүмүүстэй харилцаа холбоо тогтоох, тэднээс суралцах, тэдэнтэй мэдлэгээ харилцан солилцох боломж олгоно.

Үндэстэн бүр хүрэлцээтэй байгалийн нөөц баялагтай болж, чин сэтгэлээсээ бие биедээ тусална. Орчлонгийн илүү дэвшилтэт нийгэмд, тухайлбал бусад гарагт миний харснаар мөнгөгүй тогтолцоо байдаг. Гэхдээ тогтолцоонд гол нь байгаа юм биш. Хүмүүс өөрсдөө эхлээд амьдрал, нийгмийн тухай ухагдахуунаа өөрчлөх хэрэгтэйд гол нь байгаа юм. Нэгэнт тэд илүү нийтгэч, найрсаг, даян дэлхийн нэгэн гэр бүл шиг харилцаатай болж өөрчлөгдвөл энэ төрлийн солилцооны тогтолцоо аяндаа биеллээ олно.

Хүн бүр бие биетэйгээ: хайр, сонирхол, эзэмшил хөрөнгөө дуртайяа хуваалцан амьдарна. Ингэж бид илүү жаргалтай амьдарч, золгүй хүмүүс цөөрч, орон гэргүй, өлсгөлөн хүн, хүүхэд багасах буюу байхгүй болж, өвчин багасах буюу бүрмөсөн алга болно. Амьтад ч хамгаалагдана: махан идэштэнгүй болж, зөвхөн цагаан эсвэл веган хоолтнууд л байдаг болно.

Та бүхэн бие биетэйгээ өдөр бүр инээмсэглэн мэндчилж, ажил дээрээ ч өрсөлдөөнгүй болно; хүн бүр бие биеэ ая таваар нь байлгаж, ердөө л хайрлана, нөхөрлөнө. Гаргийн ухамсар өндөрт гарахын хэрээр хайр, нинжин сэтгэлийн энэхүү энерги улам эрч хүчтэй байх болно.

Дэлхий даяараа веган байх нь энэрэнгүй сэтгэлийн дэвшил бөгөөд энэ нь бүх соёл, үндэстэнг дэвшүүлэн нэгтгэх бөгөөд хүн, амьтдад ялгалгүй амар амгаланг бэлэглэнэ. Алж хөнөөх үйлдлийг бүхий л амьд оршихуйг хүндлэх сэтгэлээр сольсны үр дүнд үүсэх дотоодын амар амгалан давалгаа лугаа энэ дэлхийгээр түгэн, хүмүүний сэтгэлийг дэвшүүлж, Дэлхий дээр Диваажинг цогцлооно. Энэ бүхэн нь бид бүгдийг мөнх үргэлжлэх Алтан Эринд хүргэнэ.



*Supreme Master Ching Hai in Monaco, 2007*



## Хавсралт

### 1. Далайн түвшний өсөлт, дэлхий даяар түүний үзүүлэх нөлөө

Далайн түвшний өсөлт нь зөвхөн арлын жижиг улсуудын анхаарах асуудал биш билээ. Дэлхийн нийт хүн амын 70 гаруй хувь далайн эрэг орчмын хавтгай газарт, мөн дэлхийн хамгийн том 15 хотын 11 нь гол, мөрний далайд цутгах хэсгийн эрэг дээр оршдог. 20 дугаар зуунд далайн түвшин 10-20 см-ээр (4-8 инч) дээшилсэн байна.

21 дүгээр зуунд далайн түвшин 9-88 см-ээр дээшилнэ гэсэн таамгийг Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний хороо (УАӨЗГМХ) дэвшүүлжээ. **Далайн түвшний өсөлтийг таамагласан энэхүү хэмжээ нь харьцангуй бага хэдий ч өргөн хүрээг хамрах эвдрэл сүйрэл гарахад нөлөөлнө.** Далайн эргийн үер, шуурганаас үүдэлтэй гэмтэл, эргийн хөрсний нурулт, элэгдэл, цэвэр усны нөөц давслаг устай холилдон бохирдох, далайн эрэг орчмын нутаг болон усны хүчийг сааруулан хамгаалагч элсэн арлууд усанд автах, далайд цутгах хэсэгт гол, мөрний усны давслаг ихсэх зэрэг нь бүгд далайн усны түвшин багахан төдий нэмэгдэхэд үүсэх бодит нөхцөл байдал.

**Гринландын мөсөн давхарга хайлж байгаа нь почирдмоор бодит үнэний нэг илрэл юм.** УАӨЗГМХ-ноос мэдээлснээр “Гринландын дулаарал нь дэлхийн дунджаас 1-3 дахин их байж болзошгүйг цаг уурын загварчлал харуулж байна. Мөсөн бүрхүүлийн загварчлалаас харахад тухайн орон нутгийн дулаарал 3°C [5.4°F]-аас илүү гарч, мянган жилийн турш ийнхүү үргэлжилбэл, Гринландын мөсөн бүрхүүл бараг бүхэлдээ хайлж, улмаар далайн түвшин ойролцоогоор 7 м-ээр дээшилнэ.” гэжээ. (Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний хороо. Үнэлгээ, шинжилгээний гурав дахь тайлан. Бодлого боловсруулагчдад зориулсан хураангуй.)

“Хэрвээ бид хүлэмжийн хийн ялгаруулалтыг эрс хязгаарлахгүй бол Гринландын болон Баруун Антарктидын мөсөн бүрхүүлийн хооронд далайн түвшин 13 метр (43 фут)-ээр нэмэгдэх аюул дэлхийд нүүрлэх болно. Далайн түвшний энэхүү их хэмжээний өсөлтийн багахан хэсэг л гэхэд эдийн засаг, хүмүүнлэгийн гамшиг дагуулах болно. Далайн

түвшин нэмэгдсэнээр гарч болзошгүй үр дагаврууд:

- **Дасан зохицоход тэрбум доллар зарцуулна.** – Энэ нь бидний хүчрэх эсэхээс хамаарна. Сүүлийн үеийн судалгаагаар далайн түвшин ердөө 1 метр нэмэгдэхэд дасан зохицох өртөг АНУ-д ойролцоогоор 156 тэрбум (ДНБ-ий 3%) америк доллар болох аж.
- Далайн түвшин ердөө 1 метр нэмэгдэхэд Малдив зэрэг зарим арлын орон усанд живнэ. Кирибати (Номхон далайн арлын улс)-гийн 2 арал аль хэдийнээ далайн давалгаан дор орчихоод байна. **Хэрвээ дулаарал одоогийн хурдаар үргэлжилбэл Лондон, Бангкок, Нью-Йорк зэрэг хот далайн усанд живж, олон сая хүнийг нүүлгэн шилжүүлэхэд хүргэн, эдийн засагт асар их хохирол учрах болно.**
- Далайн түвшин нэмэгдэх нь газрын гадаргын болон гүний цэвэр усны нөөцийг бохирдуулж, дэлхийн цэвэр усны өнөөгийн хомсдолыг дордуулна.
- Далайн зарим эрэг дээрх тариалангийн (ялангуяа, цагаан будааны) газрууд усанд автана. (Эх сурвалж: [http://www.greenpeace.org/international/campaigns/climate-change/impacts/sea\\_level\\_rise/](http://www.greenpeace.org/international/campaigns/climate-change/impacts/sea_level_rise/))

## 2. Дэлхийн илүү олон мөнх цэвдэг мөсөн гол татарна

- Дэлхийн жимс, хүнсний ногооны охь болсон Калифорнийн Төв хэсгийн хөндийг усаар хангаж байдаг Сиерра Невада уулсын цас, мөс хаврын эхэнд аль хэдийнээ хайлж байгаа бөгөөд энэ зууны төгсгөл гэхэд 30-70 хувиар багассан байхыг тооцоолсон байна. (Эх сурвалж: [http://www.sierranevadaalliance.org/programs/db/pics/1133215435\\_14399.f\\_pdf.pdf](http://www.sierranevadaalliance.org/programs/db/pics/1133215435_14399.f_pdf.pdf) Sierra Climate Change Toolkit 2nd edition, Sierra Nevada Alliance)
- Африкийн хамгийн өндөр Килиманжаро уулын мөсөн бүрхүүл 1989-өөс 2000 оны хооронд л гэхэд 33%-аар багассаныг оролцуулаад өнгөрсөн зуун жилд 80%-аар багасжээ. (Эх сурвалж: Thompson LG, Mosley-Thompson E, Davis ME, Henderson KA, Brecher NH, Zagorodnov VS, Mashiotta TA, Lin PN, Mikhalenko VN, Hardy DR, Beer J. 2002. “Kilimanjaro ice core records: evidence of Holocene climate change in tropical Africa”. Science 298: 589–593. <http://bprc.osu.edu/Icecore/589.pdf>)
- Дэлхийн дулаарлаас шалтгаалан Хятадын мөсөн голууд жилд 7 хувиар багасаж байгаа нь ундны усны эх сурвалжаа болгон амьдардаг 300 сая хүнд гамшигт нөлөө үзүүлж болзошгүй. (Эх сурвалж: “Ice-capped Roof Of World Turns To Desert” By Geoffrey Lean 08 May 2006, The Independent, <http://www.>

[countercurrents.org/cc-lean080506.htm](http://countercurrents.org/cc-lean080506.htm))

- Төв Азийн уул нуруудын мөсөн бүрхүүл 1930 оноос хойш 35-50 хувиар багасаж, олон зуун жижиг мөсөн гол хэдийнээ устаад байна. (Эх сурвалж: <http://www.unep.org/pdf/ABCSummaryFinal.pdf> UNEP Atmospheric Brown Clouds: Regional Assessment Report With Focus on Asia 2008)

### 3. Дэлхийн цаг агаарын цочир үзэгдлүүд

#### *2010 он өнөөг хүртэлх хугацааны хамгийн халуун жил:*

АНУ-ын Агаар мандал, далай судлалын үндэсний удирдах газрын (АМДСУУГ) цаг уур судлаач эрдэмтдийн хэлсэнчлэн энэ жил түүхэн дэх хамгийн халуун нь болох төлөвтэй байна.

3, 4, 5, 6 дугаар сарууд түүхэн дэх хамгийн халуун, 7 дугаар сар удаах халуун сар болж өнгөрчээ.

Түүнчлэн тус газрын эрдэмтэн Дэвид Ийстэрлинг 2010 оны 6 дугаар сард дэлхийн бөмбөрцгийн хуурай газар бүхэлдээ дулаан байсан тухай ердийн бус үр дүнг онцолсон байна.

**Цаашилбал, Дэлхийн нийт хуурай газрын 19%-ийг эзэлж байгаа хойд хэсгийн Финлянд, Орос зэргийг оролцуулан 17 улс оронд урьд өмнө болж байгаагүй хэт их цочир халалт болж байна.**

Энэ бол нэгэн ижил жилд Дэлхийн гадаргын хамгийн их газар нутгийг хамарч урьд өмнө байгаагүй өндөр хэмээр халсан тохиолдол байв. Энэхүү харанга дэлдсэн баримтад үндэслэн АНУ-ын Цас Мөсний мэдээллийн Үндэсний Төвийн захирал Доктор Марк Серрез “Энэ тохиолдол нь дэлхийн дулаарал зогсоогүйг илэрхийлж байна.” гэж мэдээлсэн.

АНУ-ын Агаар мандал судлалын Үндэсний Төв (АМСҮТ)-ийн захирал Кевин Тренберт “Өнгөрсөн удаад ийм халуун болоод, цагаан толгойн үсгээр тэмдэглээд ч барахааргүй, түүхэнд байгаагүй их олон хар салхитай жил болж, Катрина, Рита хар салхи гарахад хүрсэн. Энэ жил Атлантидад агаарын температур 2005 оныхоос өндөр байна.” гэж хэлээд ийм нөхцөлд давтамж нь нэмэгдэж байгаа халуун орны салхи, шуурганд бэлэн байх хэрэгтэйг анхааруулжээ.”

(Эх сурвалж: <http://solveclimate.com/blog/20100816/most-ever-heat-record-temperatures-19-percent-earths-surface>

<http://news.discovery.com/earth/heat-record-climate-change.html>

<http://www.washingtonpost.com/wp-dyn/content/article/2010/08/13/AR2010081306090.html>

<http://www.accuweather.com/blogs/news/story/35632/hottest-year-on-record-so-far.asp>

<http://green.blogs.nytimes.com/2010/08/17/weather-extremes-and-climate-change>

## ***Орос Улсад***

2010 онд Орос улсад хэт халснаас зөвхөн 7 дугаар сард Москва хотод 14340 хүн нас баржээ. Мөн энэ халалт Оросын газар нутгийн баруун хэсгийг сүүлийн тавин жилд тохиолдоогүй туйлын хүнд ган гачиг болоход нөлөөлсөн тул Оросын Засгийн газар улаан буудайн экспортоо яаралтай зогсооход хүрсэн байна. Үүгээр зогсохгүй, хэт халалт нь Оросын баруун хэсгийн ихэнх газар нутаг түймрийн ноцтой аюулд өртөхөд нөлөөлсөн байна.

(Эх сурвалж: <http://climateprogress.org/2010/08/07/russian-heat-wave-drought-soil-moisture-wheat>)

## ***АНУ-д***

АНУ-ын Флорида мужид 2010 оны эхээр тэсгэм хүйтэн байснаа, тухайн бүсэд урьд өмнө байгаагүй хамгийн халуун зунтай золгожээ.

## ***Австралид***

Австралийн хойд хэсэгт 5-аас 10 дугаар сард урьд өмнөхөөс илүүтэй чийглэг байсан бол баруун өмнөд хэсэгт хамгийн их хуурайшилттай байв.

## ***Өмнөд Америкт***

Амазон мөрний сав газрын зарим хэсэг ган гачигаас болж боогдон усны түвшин нь түүхэнд байгаагүй доод хэмжээндээ хүрсэн байна.

([http://seattletimes.nwsource.com/html/businesstechnology/2013716921\\_apyescidisastrousyear.html](http://seattletimes.nwsource.com/html/businesstechnology/2013716921_apyescidisastrousyear.html))

#### **4. Томоохон хэмжээний ой, хээрийн түймрийн гамшиг**

##### ***Австрали улсад***

Австралийн өмнөд хэсэгт хэт халж, аадар бороо ихээр орж байсан нь үерийг хойд нутаг уруу урсан сүүдлэхээр ихэсгэж болзошгүй байсан тул Зүүн Австрали давтан гарч мэдэх гал түймэр, үерээс хамгаалах бэлэн байдлаа өндөрсгөв. Зуун жилд нэг удаа тохиодог байсан халуун агаарын урсгал нь амралтын өдрүүдэд улам ихэсч, хэт халуун хийгээд хуурай салхины улмаас сүүлийн 25 жил дэх хамгийн хүчтэй ой хээрийн түймрийг өдөөнө гэж таамаглаж байна.

(Эх сурвалж: [http://www.google.com/hostednews/afp/article/ALeqM5gyUztdckUqzd\\_SFg9jC1fRmHlWEg](http://www.google.com/hostednews/afp/article/ALeqM5gyUztdckUqzd_SFg9jC1fRmHlWEg))

##### ***Орос улсад***

2010 оны 8 дугаар сард Оросын ой, хүлрийн түймэр хяналтаас гарч гархсаар нутгийн баруун хэсгийн ихэнхийг хамарч, Оросын 7 муж онц байдал зарлаж байсан. Нийтдээ, Орос улс даяар 188525 га (465000 акр) газар нутгийг хамарсан 520 ой, хээрийн түймэр гарч, бараг 650000 гектар газар шатсан байна.

(Эх сурвалж: <http://online.wsj.com/article/SB10001424052748704017904575408833952872038.html>)

#### **5. Дэлхийн томоохон хэмжээний үер усны гамшиг**

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр тухайн жилийн 9 дүгээр сард зөвхөн үерээс болж 59 орны 6300 гаруй хүн эндсэн.

Свисс Ре-гийн мэдээлснээр 2010 оны 11 дүгээр сарын 30-нд ойролцоогоор 260000 хүн байгалийн гамшигт нэрвэгдэж нас барсан байна. Түүнчлэн, 2010 онд гамшгаас болж эдийн засгийн 222 тэрбум америк долларын алдагдал хүлээсэн нь Хонг Конгийн эдийн засгаас ч их хэмжээтэй юм.

([http://seattletimes.nwsource.com/html/business/technology/2013716921\\_apyescidisastrouyear.html](http://seattletimes.nwsource.com/html/business/technology/2013716921_apyescidisastrouyear.html))

##### ***Хятад улсад***

2010 оны зун Хятадын ихэнх нутгаар орсон бороо 10 жилд болж байгаагүй аймшигт үерийг эхлүүлж, олон томоохон голын ус аюултай

түвшинд хүрч нэмэгдэх, тоолшгүй олон хөрсний гулсалт үүсэхэд нөлөөлжээ. Үерийн улмаас 1.4 сая орон гэр сүйдэж, 275 тэрбум юаны (41 тэрбум доллар) эдийн засгийн шууд хохирол учирсан байна.

Үүнд Хятадын зүүн хойд хэсэг хамгийн их өртөж, хотууд бүхэлдээ үерт автаж, Хойд Солонгостой хил залгадаг гол мөрний ус аюултай түвшинд хүрч үерлэж болзошгүй байдал нь хоёр улсын аль алиныг түгшээж байв.

(Эх сурвалж: <http://www.google.com/hostednews/afp/article/ALeqM5juX85JVgP2tsnqUSZxNgLuXejxDw>)

### ***Пакистан улсад***

2010 оны Пакистаны үер 7 дугаар сард муссон салхины улмаас орсон хэд хэдэн хүчтэй борооноос үүдэн эхэлжээ. 2000 гаруй хүн эндэж, нэг сая гаруй орон гэр сүйдсэн байна. Мөн 20 сая орчим хүн бэртсэн буюу орон гэргүй болжээ.

(Эх сурвалж: [http://en.wikipedia.org/wiki/2010\\_Pakistan\\_floods](http://en.wikipedia.org/wiki/2010_Pakistan_floods))

### ***Австрали улсад***

2011 оны 1 дүгээр сард Австралийн Квийнслэнд “библийн хэмжээний” гамшиг хэмээн тодорхойлогдсон асар их хэмжээний үерт өртсөн байна. Франц болон Герман улсын нутаг дэвсгэрээс ч их талбайд 20 гаруй хот сүйдсэн буюу үерт автсан байна. Уг хямрал Австралийн хамгийн чийгшил ихтэй хэмээн бүртгэгдсэн хаврын улирлаас үүдэлтэй байлаа. Квийнслэндэд орших гол мөрний тогтолцооны дор хаяж 6 нь эргээ сүйтгэн хальжээ. Үерт 200000 орчим хүн өртөж, ихэнх хүнийг нүүлгэн шилжүүлсэн байна. Хохирлыг нөхөн сэргээхэд хэдэн тэрбум австрали доллар шаардагдахаар байна.

(Эх сурвалж: <http://www.bbc.co.uk/news/world-asia-pacific-12102126>)

## **6. Дэлхийн томоохон газар хөдлөлтийн гамшиг**

### ***Хятад улсад***

- 2008 оны 5 дугаар сард Сичуан мужид болсон 8 баллын хүчтэй газар хөдлөлт Хятадын баруун өмнөдийн их хэмжээний газар нутгийг сүйдэлсэнд хамгийн багадаа 87000 хүн эндсэн буюу

сураггүй алга болсон байна.

- 2009 оны 8 дугаар сард Гоулдмудад 6.2 баллын хүчтэй газар хөдөлж хөрсний нуралт үүсгэн 30 орчим айлын гэрийг нураажээ.
- 2010 оны 4 дүгээр сард Хятадын баруун хэсэгт 6.9 баллын хүчтэй газар хөдөлсөнд багаар тооцоход 589 хүн эндэж, 10000 гаруй хүн гэмтжээ.

(Эх сурвалж: <http://www.telegraph.co.uk/news/worldnews/asia/china/7588401/China-earthquake-kills-hundreds.html>)

### ***Исланд ба бусад улс оронд***

Галт уулын дэлбэрэлтээс болж нислэг хэдэн өдрөөр саатсан нь 7 сая гаруй хүний аяллыг тасалдуулсан байна. Конго, Гуатемала, Эквадор, Филиппин, Индонез дэх бусад галт уулын оргилолтоос болж хүмүүсийг яаралтай аюулгүй газарт нүүлгэжээ. Эдгээр нь тухайн жилийн эхээр хэдэн зуун хүний амийг авсан үер, хөрсний гулсалт, газар хөдлөлтүүдийн дараа болсон байна.

### ***Индонез улсад***

10 дугаар сард Индонез гурван аюулд дараалан өртсөн байна: үхэлд хүргэхээр 7.7 баллын хүчтэй газар хөдлөлт, 500 гаруй хүний аминд хүрсэн цунами, 390000 гаруй хүнийг дүрвэхэд нөлөөлсөн галт уулын аюул. (Эх сурвалж: [http://seattletimes.nwsourc.com/html/business/technology/2013716921\\_apyescidisastrousyear.html](http://seattletimes.nwsourc.com/html/business/technology/2013716921_apyescidisastrousyear.html))

### ***Дэлхийн эргэн тойронд***

2010 оны 1 дүгээр сарын эхээр **Соломон арлуудад** 3 удаа хүчтэй газар хөдлөлт болж, үүнээс хэдхэн долоо хоногийн дараа 7.0 баллын газар хөтлөлт **Хаити**-гийн зарим хэсгийг газрын хөрстэй тэгшилж, нэг сая гаруй хүн орон гэргүй болж, 230000 гаруй хүн нас барж, 300,000 гаруй хүн гэмтжээ. **Солонгос**, **Япон** улсад ч газар хөдлөв. Дараа нь **Чилид** хамгийн хүчтэй 8.8 баллын газар хөдлөлт болсон. **Япон**, **Мексик**, **Суматра**, саяхан **Баруун Хятадад** газар хөдлөлтийн чичирхийлэл үргэлжилсээр байв. 2010 оны 4 дүгээр сарын байдлаар эдгээр гамшигт нас барагсдын тоо бараг 250000-д хүрсэн байна.

(Эх сурвалж: <http://www.businessweek.com/news/2010-04-15/killer-quakes-on-rise-with-cities-on-fault-lines-roger-bilham.html>)

## 7. Дэлхийн хүнсний хомсдол

### ***Цаг уурын таамаглашгүй байдал хүнсний хангамжийн тогтвортой байдалд аюул учруулж байна:***

2010 оны 9 дүгээр сарын 7-ны Мягмар гарагт Шри Ланкад төвтэй Олон Улсын Усны Менежментийн Хүрээлэнгээс (ОУУМХ) Шведийн Стокгольм хотноо олон улсын эрдэмтдийн Дэлхийн усны долоо хоногийн чуулганд нэгэн тайланг танилцуулав. Уг тайланд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хур тунадасны түвшин тогтворгүй болж, хур бороо орох хугацаа тодорхой бус, хэмжээ янз бүр байгаа нь хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйцээр улам бүр нөлөөлж байгааг анхааруулсан байна.

Үүний нэг баримт бол Азид ургацын ойролцоогоор 66%-ийг, Африкт бүр 94%-ийг усалгаагаар бус харин зөвхөн бороогоор тэтгэх болсон явдал.

Энэ зун Орост аюултай түймэр гарахад хүргэсэн туйлын хуурай нөхцөл, эсрэгээр нь Пакистанд болсон гамшигт үер зэрэг өнөө цагийн эдгээр жишээг Энэтхэгийн Шинжлэх ухаан, хүрээлэн буй орчны төв (ШУХОТ)-ийн тэргүүн Сунита Нарайн онцлоод “Бид улам олон өдөр бороотой, улам их устай, тэгсэн хэр нь илүү хувьсамхай байх тэр л цэгт ойртоод байгаа нь ган, үер болоход хүргэж байна.” хэмээв.

(Эх сурвалж: <http://www.france24.com/en/20100907-erratic-global-weather-threatens-food-security>)

## 8. Дэлхийн дулаарал: “Хэм-хэмээр” хөтөч

Дэлхийн дулаарал өнөөгийн хурдаар үргэлжлэх юм бол бид устаж үгүй болоход хүрнэ. Тэгвэл Дэлхий халахын хэрээр чухам юу болох вэ? Зургаан хэм: Халуун гараг дээрх бидний ирээдүй, Марк Лунас, National Geographic, 2008 оны 1 дүгээр сарын 22 (Lynus, M, 2007) эх сурвалжаас авсан “хэм-хэмээр” хөтчийг танилцуулъя.

### 1°C хэмээр нэмэгдэхэд

